



УДИРДЛАГЫН  
АКАДЕМИ

**НУТГИЙН ӨӨРИЙН УДИРДЛАГЫН АСУУДЛУУД:  
МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ  
ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН  
ТУХАЙ ХУУЛЬД ЗААСАН ОРОН НУТГИЙН ЧИГ  
ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН СУДАЛГАА**

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

041

Улаанбаатар хот  
2023 он

Нутгийн өөрийн удирдлагын асуудлууд: Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан орон нутгийн чиг үүргийн хэрэгжилтийн судалгаа

Энэхүү бүтээлийн зохиогчийн эрхийг хуулийн дагуу хамгаалсан болно. Бүтээлийг бүтнээр буюу хэсэгчлэн хувилах, нийтлэх, электрон системд оруулах болон бусад ямар нэг хэлбэрээр олшруулахыг хориглоно.

Судалгааны баг:

**Удирдагч:**

Ядамсүрэнгийн Бямбаяр, доктор, профессор

*Удирдлагын академийн Төрийн захиргааны тэнхимийн профессор*

**Судлаачид:**

Түмэндэмбэрэлийн Түмэнцогтоо, доктор

*Удирдлагын академийн Төрийн захиргааны тэнхимийн эрхлэгч*

Цанжидын Дэлгэржаргал, доктор

*Удирдлагын академийн Төрийн захиргааны тэнхимийн дэд профессор*

Дондовын Оюунцэцэг, Удирдлагын академийн докторант

*Удирдлагын академийн Төрийн захиргааны тэнхимийн ахлах багш*

Шагдарын Мөнгөнчимэг, магистр

*Удирдлагын академийн Төрийн инновац, хөгжлийн албаны Нутгийн удирдлагын сургалт, судалгаа, мэдээллийн зохицуулагч*

## АГУУЛГА

ЗУРГИЙН ЖАГСААЛТ .....	IV
ХҮСНЭГГИЙН ЖАГСААЛТ .....	V
ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ .....	VI
ӨМНӨХ ҮГ .....	VII

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. УДИРТГАЛ .....	1
1.1. Судалгааны асуудал .....	1
1.2. Судалгааны асуулт .....	3
1.3. Судалгааны зорилго .....	4
1.4. Судалгааны зорилт .....	4
1.5. Судалгааны хамрах хүрээ .....	4
1.6. Хүлээгдэж буй үр дүн .....	4

ХОЁРДУГААР БҮЛЭГ. СУДЛАГДСАН БАЙДЛЫН ТОЙМ .....	5
2.1. Чиг үүргийн талаарх ойлголт .....	5
2.2. Чиг үүргийг орон нутагт хуваарилах буюу төвлөрлийг сааруулах ....	6
2.3. Чиг үүргийн талаар хийгдсэн судалгаа, тэдгээрийн үр дүн .....	11
2.4. Судалгааны үзэл баримтлал .....	18

ГУРАВДУГААР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ .....	21
3.1. Судалгааны эх олонлог, түүвэр .....	21
3.2. Судалгааны үндсэн ойлголт, түүний хэмжүүр .....	22
3.3. Судалгааны өгөгдөл цуглуулах арга, үйл явц .....	23
3.4. Өгөгдөлд шинжилгээ хийх арга, үйл явц .....	25

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ШИНЖИЛГЭЭ .....	27
4.1. Орон нутгийн чиг үүрэгт хамаарах хуулиудад хийсэн шинжилгээ ....	27
4.2. Орон нутгийн шийдвэрт хийсэн шинжилгээ .....	49

ТАВДУГААР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ .....	64
---	----

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ .....	66
ХАВСРАЛТ .....	70

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төвлөрлийг сааруулах дороос санаачилга гаргах загвар.....	10
Зураг 2. Төвлөрлийг сааруулах замаар үйлчилгээ хүргэдэг уламжлалт загвар .....	11
Зураг 3. Судалгааны үзэл баримтлал .....	19
Зураг 4. Шинжилгээ хийсэн ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамж .....	24

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Судалгаанд хамрагдсан аймаг, сум, нийслэл, дүүрэг.....	22
Хүснэгт 2. Судалгааны үндсэн ойлголт, тодорхойлолт, хэмжүүр.....	23
Хүснэгт 3. Нэмэлт өөрчлөлт орсон хуулиуд.....	33
Хүснэгт 4. Агуулгын шинжилгээ хийсэн шийдвэрийн тоо (Аймаг, сум, нийслэл, дүүргийн ИТХ, Засаг даргын шийдвэр, түүвэрлэн авснаар, оноор).....	50

## ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

АЗЗА	Авто зам засвар, арчлалт
ЕТГ	Ерөнхийлөгчийн Тамгын газар
ЗГХЭГ	Засгийн Газрын Хэрэг Эрхлэх газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИНХ	Иргэдийн Нийтийн Хурал
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ННФ	Нээлттэй Нийгэм Форум
НҮБХХ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОХУ	Оросын Холбооны Улс
ТАЗ	Төрийн Албаны Зөвлөл
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
УИХ	Улсын Их Хурал
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ЭЗХАХБ	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага
ЕСТАС	The Mongolia Economic Capacity Building Technical Assistance Project

## ӨМНӨХ ҮГ

“Нутгийн өөрийн удирдлагын асуудлууд: Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан орон нутгийн чиг үүргийн хэрэгжилтийн судалгаа”-ны үр дүн, тайланг Танд толилуулж байна.

2020 оны 12 дугаар сард баталж, 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжүүлж байгаа Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгад орон нутгийн чиг үүргийг тодорхойлж, орон нутаг нь өөрийн эрхлэх асуудалтай, бие даан хэрэгжүүлэх чиг үүрэгтэй байхыг хуульчилсан билээ. Уг хуульд салбарын хууль тогтоомжийг нийцүүлэх ажил удааширч, тэр хэрээрээ орон нутгийн чиг үүргийн хэрэгжилт ч зогсонги байдалд орох эрсдэлтэй байгаа үед орон нутгийн чиг үүргийн хуваарилалт нь оновчтой эсэх, орон нутгийн чиг үүрэгт хамаарах салбарын хууль тогтоомж нийцэж байгаа эсэх талаар судлах хэрэгцээ зайлшгүй үүссэн билээ. Энэ хүрээнд уг судалгааг холбогдох хууль тогтоомж, аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэрт шинжилгээ хийж, орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэх, хууль тогтоомжийг үүнд нийцүүлэх талаар нэгдсэн дүгнэлт, санал зөвлөмж боловсрууллаа.

Судалгааны хүрээнд орон нутгийн 23 чиг үүрэгт шууд хамаарах 50 хууль болон нийслэл, 4 аймаг, 13 сум, 2 дүүргийн Хурал, Засаг даргын сүүлийн 3 жилийн 13 мянга гаруй шийдвэрт шинжилгээ хийв. Энэхүү судалгааны тайлан нь шийдвэр гаргагчид, төрийн албан хаагчдад хууль тогтоомжийн төсөл, бодлого боловсруулахад суурь мэдээлэл, санаа авах гарын авлага нь болохын зэрэгцээ судлаачдад судалгааны эх сурвалж, багш, оюутан, суралцагчдад сургалтын хэрэглэгдэхүүн болно гэдэгт найдаж байна.

Энэхүү судалгааг гүйцэтгэхэд бүх талын дэмжлэг үзүүлсэн Удирдлагын академийн захиргаа, Эрдмийн зөвлөл, судалгааны мэдээллийг цуглуулах, нэгтгэхэд гүн туслалцаа үзүүлсэн, судалгаанд хамрагдсан аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга, ИТХ-ын удирдлага, тэдгээрийн ажлын албаны албан хаагчид, хэлэлцүүлэгт идэвхтэй оролцож, санал бодлоо илэрхийлсэн төрийн албан хаагчид, эрдэмтэн багш, судлаачид, мэргэжил нэгт нөхөддөө судалгааны багийнхныхаа нэрийн өмнөөс болон хувиасаа чин сэтгэлийн угаас талархал илэрхийлье.

Судалгааны мэдээллийг цуглуулах, нэгтгэх, боловсруулах, шинжлэх, дүгнэх, тайлагнах бүхий л ажилд хамтдаа байж, нэг баг болж ажилласан судалгааны багийн багш, судлаачид, хамтран зүтгэгчиддээ цаашдын эрдмийн ажилд нь амжилт хүсье!

*Судалгааны удирдагч, доктор, профессор  
Ядамсүрэнгийн Бямбаяр*





# НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. УДИРТГАЛ

## 1.1. Судалгааны асуудал

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 2020 оны шинэчилсэн найруулгад “орон нутгийн чиг үүрэг”-ийг засаг захиргааны нэгж тус бүрээр нь ангилан тогтоосон билээ. Энэ нь Монголын түүхэнд анх удаа орон нутгийн эрхлэн гүйцэтгэх асуудлыг хуульчилсан хэрэг гэж үзэж болох юм. Анх орон нутгийн чиг үүргийг 1925 оны Нутгийн захиргааны дүрмэнд (“аймаг бүрийн өөрөө эрхлэн шийтгэвэл зохих хэрэг зүйл” гэж) тусгайлан (Хууль зүйн үндэсний хүрээлэн, 2010, хууд. 539) зааж байсан бөгөөд харин үүнээс хойш (тухайлбал, 1933 оны аймгийн Хурал ба аймгийн Яамны дүрэм зэрэгт) тухайн нэгжийн “эрхлэн шийтгэх асуудал” гэж заалгүй, “аймгийн Хурал, аймгийн Яамны үүрэг”-ийн хүрээнд голчлон “дээд газруудаас гаргасан хууль, тогтоол, тушаал зэргийг хэрэг дээр биелүүлэн гүйцэтгэх” (Хууль зүйн үндэсний хүрээлэн, 2010, хууд. 517) гэх зэргээр заах болсон нь нэг талаас эрх мэдлийн төвлөрөл ихэсч, орон нутаг бие даан эрхлэн хөтөлж, хэрэгжүүлж байх асуудалгүй болж, гагцхүү дээрээс тогтоосон, дээд байгууллагаас уламжилсан эрх, үүргийг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэх болсныг харуулж байгаа юм. Нөгөө талаас Зөвлөлт маягийн эрх зүйн тогтолцоо төлөвшиж, хууль тогтоомжийн эх зохиох арга зүй өөрчлөгдсөн, аливаа байгууллага, этгээд, албан тушаалтны эрх, үүргийг хуваарилахад баримтлах зарчим нь төвлөрсөн, дээрээс доош чиглэсэн хэлбэртэй болсон нь орон нутгийн бие даан эрхлэх асуудлыг тусгайлан тогтоох, хуульчлах боломжгүй болсныг илтгэнэ.

1992 оны Монгол Улсын Үндсэн хуульд аймаг, нийслэл, сум дүүрэг нь “... хуулиар тусгайлан олгосон чиг үүрэгтэй...” (Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэг) байхаар заасан хэдий ч урьдын адил 2020 оныг хүртэл орон нутгийн чиг үүргийг хуулиар тусгайлан олгож байсангүй. Татвар, төсөв, өмчийн харилцаа зэрэг тодорхой эрх мэдлийн хүрээг орон нутагт шилжүүлж байсан (зарим тохиолдолд буцаан төвлөрүүлж ч байсан) боловч Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 2020 оны шинэчилсэн найруулгад “орон нутгийн чиг үүрэг”-т хамаарах асуудлыг тусгайлан зааж, зөвхөн “нэмэгдүүлж болно” (хасахгүй гэсэн утгаар) гэж хамгаалсан нь том дэвшил болсон билээ.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 2020 оны шинэчилсэн найруулгад нийт 23 чиг үүргийг орон

нутгийн чиг үүрэгт хамаарахыг заасан бөгөөд аймаг, сум, баг, нийслэл, дүүрэг, хороонд тухайн чиг үүргийг зааглаж хуваарилсан байна. Эдгээр чиг үүргүүдийн зарим нь тодорхой хууль, түүнийг дагаж гарсан эрх бүхий байгууллагын шийдвэрээр засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж бүрийн эрхлэн гүйцэтгэх чиг үүрэг юм. Тухайлбал, хуулийн 20.1.1-д заасан “орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлт” нь “Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль”, түүнд холбогдох бусад шийдвэрээр, 20.1.3-т заасан “орон нутгийн төсөв, албан татвар, төлбөр, хураамж” нь төсвийн тухай болон татварын тухай хууль тогтоомжид зааснаар засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж тус бүрийн эрхлэн гүйцэтгэх чиг үүргийн хүрээ, хязгаарыг тогтоосон байдаг.

Үүний зэрэгцээ зарим чиг үүрэг нь зөвхөн орон нутагт (аймаг, нийслэлд) хэрэгжих, нутгийн өөрийн удирдлагаас тогтоох (тогтоовол зохих) хэм хэмжээний хүрээнд хэрэгжих ёстой чиг үүрэг юм. Тухайлбал, хуулийн 20.1.5-д заасан “орон нутгийн хүний нөөцийн бодлогын төлөвлөлт, хөтөлбөр” гэх чиг үүрэг юм. Энэхүү чиг үүргийн хүрээнд аймгийн хэмжээнд хүний нөөцийн төлөвлөлт хийж, бодлого боловсруулан хэрэгжүүлэх, үүний хэрэгжилтийг сумын түвшинд хангах асуудал хамаарах юм.

Өмнө нь орон нутгийн чиг үүргийг ийнхүү хуулиар тусгайлан олгож байгаагүй, салбарын хуулиудаар орон нутгийн Хурал, Засаг даргад эрх мэдлийг хэсэгчлэн шилжүүлэх хэлбэрээр л орон нутгийн чиг үүргийг томьёолж, ойлгож, хэрэгжүүлж ирсэн юм. Иймээс орон нутагт өөрийн гэх чиг үүрэг байхгүй мэт ойлгогдож, чиг үүргийг хэзээ ч хамаагүй буцаан төвлөрүүлэх боломжтой, салбарын хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулахдаа төвлөрүүлэх, эс төвлөрүүлэхээ шийдвэрлэдэг байсан тул “Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-д заасан орон нутгийн чиг үүрэг нь одоогоор эхлэл төдий, салбарын хуулиудад холбогдох нэмэлт өөрчлөлт оруулж байж, сая орон нутгийн “өөрийнх” нь чиг үүрэг болж төлөвших учиртай нь харагдаж байна.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Засаглалын талаар баримтлах бодлогын 5.2-т заасан “Төрийн захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тодорхойлох замаар чиг үүрэг, эрх мэдлийн хуваарилалтыг нарийвчилна” гэсэн зорилтын хүрээнд 2050 он гэхэд “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж бие даан хөгжих нөхцөлийг бэхжүүлсэн байна” гэж хүрэх үр дүнгээ тодорхойлсноос үзэхэд орон нутгийн чиг үүргийг оновчтой хуваарилах нь уг зорилтыг хангахад чухал нөлөөтэй болохыг харуулж байна.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 2020 оны шинэчилсэн найруулгыг хэрэгжүүлж эхэлснээс хойш уг хуульд холбогдох салбарын хууль тогтоомжийг нийцүүлэх ажлыг зохион байгуулж байгаа гэх боловч 2022 оны 4 дүгээр сард зөвхөн нэр томьёо,

ойлголтыг нийцүүлэн 146 хуульд нэгэн зэрэг өөрчлөлт оруулжээ. УИХ-ын 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 45 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуультай бусад хууль тогтоомжийг нийцүүлэх, холбогдох хуулийн төслийг өргөн мэдүүлэх” гэж Засгийн газарт үүрэг болгосон хэдий ч өнгөрсөн хугацаанд нэмэлт өөрчлөлт оруулсан хуулиудад дээр дурдсан “нийцүүлэх ажил” үндсэндээ хийгдээгүй байна.

Энэ нь төрийн захиргааны төв байгууллагуудын зүгээс хуульд заасан орон нутгийн чиг үүргийн агуулга, хэрэгжүүлэх нөхцөлийн талаар нэгдсэн бодлогогүй, эрх мэдлийг дахин хуваарилах талаар бодитой алхам хийхгүй, холбогдох салбарын хууль тогтоомжид эрх мэдлийн төвлөрлийг сааруулах талаар санаачилга гаргахгүй байгааг харуулж байгаа юм.

Түүнчлэн “Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн нэр томъёоны тайлбар [хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6]-т орон нутгийн чиг үүргийг “хуульд заасны дагуу нутгийн өөрийн удирдлагад тусгайлан олгосон, нутгийн өөрөө удирдах байгууллага хариуцан шийдвэрлэх эдийн засаг, нийгмийн шинжтэй асуудал” гэж тодорхойлсон нь эдгээр чиг үүрэг нь зөвхөн нутгийн өөрөө удирдах байгууллагад хамаатай, нутгийн захиргааны байгууллагад хамаарахгүй мэт ойлголтыг төрүүлсэн, үүнээс хамаарч чиг үүрэг хэрэгжихгүй, хийдэгдэл үүсэх ч магадлалтай байна.

Энэхүү нөхцөл байдал нь хууль тогтоомжид заасан орон нутгийн чиг үүргийн агуулга, хэрэгжилт, дахин хуваарилах асуудлыг тусгайлан судлах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж байгаа юм. Энэ нь аливаа бодлого, шийдвэрийг боловсруулж хэрэгжүүлэхэд судалгааны үндэслэлтэй хандах, цаашид дээрх асуудлаар төрийн байгууллагуудад зөвлөх үйлчилгээ үзүүлэх, төрийн албан хаагчдыг чадавхжуулах сургалтын хэрэглэгдэхүүнийг баяжуулахад шаардлагатай судалгааны өгөгдөл болох юм.

## 1.2. Судалгааны асуулт

Уг судалгаа нь орон нутгийн чиг үүргийн хэрэгжилтийг Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд судлах бөгөөд дараах асуултыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Орон нутгийн чиг үүргийг салбарын хуулиудад хэрхэн уялдуулан зохицуулсан байна вэ?
2. Орон нутгийн чиг үүрэг нь засаг захиргааны нэгж бүрт хэрхэн хэрэгжиж байна вэ?

### 1.3. Судалгааны зорилго

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан орон нутгийн чиг үүргийн хуваарилалт, түүний хэрэгжилтэд шинжилгээ хийж дүгнэлт санал боловсруулах.

### 1.4. Судалгааны зорилт

- Орон нутгийн чиг үүргийн талаарх ойлголт, түүнийг хэрэглэж ирсэн түүхэн уламжлал болон гадаад улс орнуудын туршлагыг судалж, үр дүнг нэгтгэн дүгнэх.
- Аймаг, сум, баг, нийслэл, дүүрэг, хороонд орон нутгийн чиг үүргийг зааглаж, хуваарилсан байдлыг судлан тодорхойлох.
- Орон нутгийн чиг үүргийг салбарын хуулиуд, бусад хууль тогтоомжид уялдуулан зохицуулсан байдлыг судлах.
- Орон нутгийн чиг үүргийн хэрэгжилтийг аймаг, сум, баг, нийслэл, дүүрэг, хорооны түвшинд судлах, тулгамдсан асуудлыг тодорхойлох.

### 1.5. Судалгааны хамрах хүрээ

Уг судалгааг Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан орон нутгийн 23 чиг үүргийн хүрээнд гүйцэтгэнэ. Орон нутгийн чиг үүргийн хэрэгжилтийн байдлыг судалгааны түүврээр тогтоосон аймаг, сум, баг, нийслэл, дүүрэг, хорооны түвшинд судалж тодорхойлно. Төрийн байгууллага, бүтцийн нэгж, албан тушаалтны ажил үүргийг судлахгүй.

### 1.6. Хүлээгдэж буй үр дүн

- Судалгааны үр дүн нь нутгийн өөрийн удирдлагын чиглэлээр хийгдэх дараагийн шатны судалгааны суурь өгөгдөл болно. Тухайлбал, ИТХ болон Засаг даргын үйл ажиллагаа, бүрэн эрх, зохион байгуулалтын талаар хуульд орсон өөрчлөлт, түүний хэрэгжилтийг судлахад үндсэн мэдээллээр ашиглагдана.
- Судалгааны өгөгдөл, үр дүн нь Удирдлагын академийн сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах, хичээлийн агуулгыг баяжуулахад практик ач холбогдолтой мэдээлэл болно.
- Судалгааны үр дүнг нутгийн өөрийн удирдлага болон чиг үүргийн талаар судалгаа, шинжилгээ хийх эрдэмтэн судлаачид өгөгдөл болгон ашиглах боломжтой.
- Төрийн бодлого, хуулийн төсөл боловсруулах, шийдвэр гаргахдаа захиалагч болон төрийн албан хаагчид судалгааны үр дүн, санал зөвлөмжийг ашиглах боломжтой.

# ХОЁРДУГААР БҮЛЭГ. СУДЛАГДСАН БАЙДЛЫН ТОЙМ

## 2.1. Чиг үүргийн талаарх ойлголт

Монгол хэлнээ “чиг үүрэг” гэдэг ойлголт нь оросоор “функция”, англиар “function” гэдэг (functiō - гүйцэтгэх гэх утгатай латин үгнээс гаралтай) үгийн утга дүйцэх нэр томъёо болж 1970-аад оны сүүлчээс төлөвшсөн байна. Хэдийгээр Монголд анагаах ухаан, математик, физикийн шинжлэх ухаанд ХХ зууны дунд үеэс “функция/function” гэх нэр томъёог орчуулалгүй, орос дуудлагаар нь “функц” гэж хэрэглээд сурчихсан байсан боловч нийгмийн ухаанд “чиг үүрэг” гэж хэрэглэх болжээ (ШУА, 1978, хууд. 271).

Судлаачид, голчлон хууль зүйн ухааны судлаачид “чиг үүрэг” хэмээх нэр томъёоны утгыг “... зайлшгүй гүйцэтгэх ёстой үйл ажиллагаа...” (Лүндэндорж, 2005, хууд. 193-194), “үүрэг биелүүлэх” (Нарангэрэл, 2012, хууд. 277), “нэгж байгууллагаас тухайлсан үүргийг хэрэгжүүлэх, хянах, хариуцлагын хүрээ” (Сүнжид, 2016, хууд. 65) гэх зэргээр тайлбарласан байна.

Чиг үүргийг, тэр дундаа төрийн байгууллагын чиг үүргийг олон янзаар тодорхойлсон байдаг. Тухайлбал, профессор Сальвадор Паррадо “чиг үүрэг нь Засгийн газрын хийж буй ажил, Засгийн газрын de-facto үйл ажиллагаа явуулж буй талбарт хамаарна” гээд “бодит байдал дээр хэрэгжүүлж байгаа чиг үүрэг нь хууль тогтоомжид заасантай нийцэхгүй байх нь ч бий, тухайлбал, нутгийн удирдлага нь хуульд зааснаас хавьгүй олон чиг үүргийг хэрэгжүүлж байдаг” гэж тэмдэглэсэн байна (Salvador Parrado, 2005, p 5).

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 22 дугаар тогтоолоор баталсан “Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал”-д чиг үүргийг “төрийн байгууллагад хуулиар тогтоосон эрх мэдлийн хүрээнд тодорхой үр дүнд хүрэх зорилгоор хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны тогтвортой чиглэл” гэж тодорхойлсон бөгөөд үүнээс хойш гарсан хууль тогтоомж, эрх зүйн бусад акт, бодлогын баримт бичиг, судалгааны бүтээлд энэхүү тодорхойлолтыг голчлон ашиглаж байна (Монгол Улсын Засгийн газрын тогтоол, 2018). Тухайлбал, 2022 онд Конрад Аденауэрын сангаас эрхлэн гаргасан “Захиргааны шинжлэх ухааны нэр томъёоны толь бичигт энэ тодорхойлолтыг авч ашиглажээ (Конрад-Аденауэр-Сан, 2022, хууд. 448).

Дээр дурдсанаас харахад төрийн байгууллагын чиг үүргийг түүний хуулиар тогтоосон эрх хэмжээ, үйл ажиллагаатай нь холбож авч үзсэн байх бөгөөд үүний хүрээнд “орон нутгийн чиг үүрэг” хэмээх ойлголтыг “орон

нутаг (засаг захиргааны нэгж, хот, тосгон)-аас тодорхой нутаг дэвсгэрийн хэмжээнд өөрсдөө хариуцан хэрэгжүүлэх ажил үүрэг” гэж тодорхойлж болохоор байна. Орон нутгийн чиг үүргийг улс орон бүр өөрийн төрийн тогтолцоо, эрх зүйн систем, түүхэн уламжлал, төв-орон нутгийн харилцааны онцлогоос шалтгаалан өөр өөрөөр ойлгож, томьёолж, хуваарилж, мөн хэрэгжүүлж ирсэн бөгөөд орон нутгийн чиг үүргийг солонгосоор 업무 범위 (эрхлэх асуудлын хүрээ), оросоор вопросы местного значения (орон нутгийн хэмжээний асуудал), германаар Die Kommunale Aufgaben (орон нутгийн үүрэг) гэх мэтчилэн нэрлэдэг байна.

1985 оноос Европын орнуудад тууштай хэрэгжүүлж байгаа “Нутгийн өөрөө удирдах ёсны тухай Европын Харти”-д (Council of Europe, 1985) орон нутгийн чиг үүрэг, түүний хэмжээ, хүрээ хязгаар, хэрэгжүүлэх эрх мэдэл нь улс орон бүрт ялгаатай байхыг хүлээн зөвшөөрч, гагцхүү орон нутгийн эрх хэмжээ нь (англи эх дээр нь “basic powers and responsibilities”; франц эх дээр нь “les compétences” гэж, герман орчуулгад нь “Die grundlegenden Zuständigkeiten” гэж байгаа<sup>1</sup>) саадгүй хэрэгжих бүтэц, зохион байгуулалт, санхүүгийн хангалттай нөөцтэй байхыг үндсэн нөхцөл болгон томьёолсон байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудал” гэсэн томьёолол байгаа нь дээр дурдсан “орон нутгийн эрхлэх асуудал”, “орон нутгийн чиг үүрэг” зэрэг нэр томьёотой дүйцэх утгатай болохыг харуулна. Монгол Улсын Үндсэн хуульд заасан энэ агуулга нь “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 2020 оны шинэчилсэн найруулгад тусгалаа олж, орон нутгийн чиг үүргийг “хуульд заасны дагуу нутгийн өөрийн удирдлагад тусгайлан олгосон, нутгийн өөрөө удирдах байгууллага хариуцан шийдвэрлэх эдийн засаг, нийгмийн шинжтэй асуудал” гэж ойлгохоор зааж, аймаг, сум, баг, нийслэл, дүүрэг, хороо шийдвэрлэж байх чиг үүргийг тус тусад нь тогтоосон байна.

## 2.2. Чиг үүргийг орон нутагт хуваарилах буюу төвлөрлийг сааруулах

Хатуу төвлөрсөн тогтолцоотой байсан Монгол Улсын хувьд 1990-ээд оны эхэн үеэс орон нутагт эрх мэдэл шилжүүлэх, орон нутгийн бие даасан байдлыг дээшлүүлэх асуудал яригдаж эхэлсэн билээ. Монгол Улсын Засгийн газрын Удирдлагын хөгжлийн хөтөлбөрөөс эхлээд эрх мэдлийн төвлөрлийг

1 Энэ нь проф. Сальвадор Паррадо (2005) судалгаандаа “Англо-Саксоны орнуудад “power and responsibility” гэж түлхүү хэрэглэдэг байхад Эх газрын буюу Наполеоник уламжлалтай Франц зэрэг орнуудад “competence” гэж тодорхойлдог” гэснийг батлан харуулж байгаа бөгөөд энд Нутгийн өөрөө удирдах ёсны Европын Хартийн англи, франц эх нь нэгэн адил хүчин төгөлдөр, үндсэн эх гэж тооцогддог гэдгийг цохон тэмдэглэв. Герман орчуулгыг монгол хэлнээ хөрвүүлбэл “үндсэн үүрэг” гэсэн утгатай.

сааруулах асуудлыг хөндөж, "...боловсрол, эрүүл мэнд, соёлын үйлчилгээг үзүүлэх чиг үүргийг үндсэнд нь нутгийн захиргааны байгууллагад..." шилжүүлсэн гэж "Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлого" (УИХ-ын 1996 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн 38 дугаар тогтоол)-д дурдсанаас харахад орон нутагт чиг үүрэг хуваарилах чиглэлээр тодорхой үр дүнд хүрч байсныг илтгэнэ. Энэ үеэс л төрийн удирдлагын эрх мэдлийг орон нутагт шилжүүлэх замаар зах зээлийн харилцаанд зохицсон удирдлага, зохион байгуулалт, ажил үүргийн хуваарь, арга хэлбэрийг бий болгох, энэ чиглэлээр бодлого боловсруулж хэрэгжүүлэх өргөн хүрээтэй шаардлагыг багтаасан "төвлөрлийг сааруулах" гэдэг нэр томъёо онол, практикийн талбар дээр эргэлтэд орсон юм (Долгоржав. Я. , Төвлөрлийг сааруулж, үйлчилгээ хүргэх асуудалд, 1999, хууд. 142).

Профессор Я.Долгоржав Монголд "...Үндсэн хуульдаа нутгийн өөрийн удирдлагын зарчмуудыг онцгойлон анхаарч тусгасан ч хэрэг дээрээ төвлөрлийг сааруулах чиглэлийн зарчим орон нутагт хэрэгжиж байгаа" гээд энэ нь "...төвлөрсөн удирдлагын тогтолцоотой байсан улсын хувьд зүй ёсны хэрэг..." (Долгоржав Я. , 2023, хууд. 53) гэж үзсэн байна. Ийм өнцгөөс харвал "орон нутгийн чиг үүрэг"-ийг төвлөрлийг сааруулах арга замаар л орон нутагт шилжүүлэх учиртай болж байна. Төвлөрлийг сааруулах талаар олон улсын судлаачид Дэлхийн II дайны дараагаас идэвхтэй судлах болсон нь дайны үеэр бий болсон төр засгийн эрх мэдлийн болон нийгэм, эдийн засгийн хүчтэй төвлөрлийг сааруулах хэрэгцээ, түүнчлэн шинээр тусгаар тогтносон орнуудад төр засгийг эмхлэн байгуулах, ардчиллыг хөгжүүлэх шаардлагатай шууд холбоотой юм.

Төвлөрлийг сааруулах ойлголтыг хамгийн цэгцтэй томъёолсон тодорхойлолт бол АНУ-ын Сиракюзийн Их сургуулийн профессор, Дэлхийн банкны зөвлөх агсан Деннис Рондинелли (1943-2007)-н тодорхойлолт гэж үзэж болно. Тэрээр 1980 онд нийтэлсэн өгүүлэлдээ "төвлөрлийг сааруулах гэдэг нь төрийн чиг үүргийг төлөвлөх, шийдвэрлэх, эрхлэн хөтлөх эрх зүйн болон улс төрийн эрх мэдлийг төв Засгийн газар болон түүний агентлагуудаас орон нутаг дахь салбар нэгж, харьяа байгууллага, хагас автономит төрийн өмчийн корпорац, бүс нутгийн байгууллагууд, орон нутгийн бие даасан байгууллага, төрийн бус байгууллагуудад шилжүүлэх буюу төлөөлүүлэн олгох явдал (Rondinelli Dennis, 1980)" хэмээн тодорхойлсон байдаг. Мөн Вэбстэр "аливаа төвлөрсөн эрх мэдэл, хяналтыг өөр хэсгүүд буюу үйл ажиллагаа явагддаг хэсэг рүү шилжүүлэх (Webster, 1995)" гэж ерөнхий тодорхойлсон байна.

Харин Дэлхийн банкны "төвлөрлийг сааруулах асуудал хариуцсан баг (Decentralization Thematic Team)"-ийнхан төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой эрх мэдэл, хариуцлагыг төв Засгийн газраас түүнд захирагдах

хагас бие даасан төрийн болон хувийн хэвшлийн байгууллагад шилжүүлэх явдал гэж тодорхойлсон нь зөвхөн төрийн янз бүрийн шатны байгууллага хооронд биш, илүү өргөн хүрээтэй асуудал гэж үзсэн байна. Эндээс бид төвлөрлийг сааруулах нь төрийн эрх мэдэл, чиг үүрэг, хариуцлага, нөөцийг засаг захиргааны нэгж дэх төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшилд шилжүүлэх үйл явц гэж ойлгож болно.

Төв засгийн газраас ямар байгууллагууд төлөвлөх, шийдвэр гаргах, удирдах эрх мэдлийг хэдий хэмжээгээр хэнд шилжүүлж байгаагаас хамаарч төвлөрлийг сааруулах гурван үндсэн хэлбэр байдаг. Д.Рондинелли нь шилжүүлж байгаа эрх мэдлийн цар хүрээ, хэмжээгээр нь төвлөрлийг сааруулах хэлбэрийг нягтралыг сийрэгжүүлэх (deconcentration), эрх мэдэл төлөөлүүлэх (delegation), эрх мэдлийг бүрэн шилжүүлэх (devolution) гэж ангилсан байна (Rondinelli Dennis, 1980). Д.Рондинелли энэ ангиллаа "төвлөрлийг сааруулах төрлүүд" (Types of Decentralization) гэж нэрлэсэн байх бөгөөд хожим нь НҮБХХ-өөс гаргасан гарын авлагад уг ангиллыг "Forms of Decentralization" буюу төвлөрлийг сааруулах хэлбэр гэсэн агуулгаар тэмдэглэсэн байдаг. Тухайлбал,

- *Нягтралыг сийрэгжүүлэх (deconcentration)*: Энэ нь эрх мэдлийг доод шатны захиргааны түвшинд төлөөлүүлж хэрэгжүүлнэ гэсэн үг юм. Төв Засгийн газрын хүрээний яам, агентлаг, орон нутаг дахь харьяа байгууллагууддаа захиргааны зарим эрх мэдэл, хариуцлагыг олгож, голчлон эцсийн шийдвэр гаргах, хяналт тавих эрхийг өөртөө үлдээдэг. Энэ нь техникийн үр ашгийг нэмэгдүүлэх, төвийн яамдын ажлын ачааллыг багасгах, тэднийг өдөр тутмын захиргааны ажлаас чөлөөлж илүү бодлогын асуудлууд дээр төвлөрүүлэх явдал юм. Өөрөөр хэлбэл "нягтралыг сийрэгжүүлэх" нь эрх мэдэл, чиг үүргийг захиргааны байгууллагуудын хооронд тараан байршуулах гэж ойлгож болно. Гэхдээ нягтралыг сийрэгжүүлэх хэлбэр нь "Ази, Номхон далайн орнуудын практикаас харахад төвлөрлийг сааруулах бүх хэлбэр дотроос хамгийн бага тархсан нь" гэж профессор Я.Долгоржав тэмдэглэсэн байдаг (Долгоржав Я. , Төвлөрлийг сааруулсан удирдлагын хэв маяг, 2023)
- *Эрх мэдлийг төлөөлүүлэх (delegation)*: Энэ нь эрх мэдлийг хагас бие даасан байгууллагуудаас төлөөлүүлж хэрэгжүүлэх гэсэн утгатай. Өөрөөр хэлбэл, тодорхой чиг үүргийг хэрэгжүүлэх хариуцлагыг төрийн захиргаанаас "гадагш" буюу төв Засгийн газраас шууд бус удирдлагаар хангадаг байгууллагууд болох төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, хөгжлийн агентлагууд, төслийн нэгж зэрэг төрийн захиргааны бус байгууллага, этгээдэд шилжүүлэхийг ойлгодог байна. Д.Рондинеллигийн бичсэнээр эрх мэдэл төлөөлүүлэх хэлбэрийг зарим оронд "үр ашиггүй ажилладаг захиргаанаас чухал ач холбогдолтой



үүргийг холдуулах арга зам” байдлаар, заримд нь “төрийн албанаас үр ашигтайгаар хүргэж чадахгүй үйлчилгээг тодорхой хэмжээний үйлчилгээний хөлстэйгөөр шууд бусаар хүргэх арга зам” гэж ойлгон хэрэгжүүлсэн байна. Үүний зэрэгцээ эрх мэдэл төлөөлүүлэх хэлбэр нь “өндөр ашигтай, үнэ цэнтэй нөөцийн удирдлагад олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх арга” байх учиртай хэмээн үздэг байна.

- *Эрх мэдлийг бүрэн шилжүүлэх (devolution)*: Эрх мэдлийг орон нутгийн захиргаанд бүрмөсөн хариуцуулж шилжүүлэх гэсэн агуулгатай. Өөрөөр хэлбэл, эрх мэдэлтэй, эд хөрөнгөтэй, бие даасан, хүчирхэг орон нутгийг бий болгох явдал юм. Тодорхой чиг үүргийг орон нутагт тухайн чиг үүрэгт хамаарах бүхий л төрлийн нөөц, хариуцлага, хяналтын хамт шилжүүлж, тухайн асуудлаар бүрэн биеэ даах нөхцөлийг бүрдүүлэхийг ойлгоно. Эрх мэдлийг ийнхүү иж бүрэн шилжүүлснээр үр дүнд нь өөрийн нутаг дэвсгэртэй, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай орлогыг өөрөө бүрдүүлдэг, боловсон хүчнээ өөрсдөө томилдог, бие даасан эрхтэй орон нутгийг бий болгоно гэсэн үг. Гэвч практик дээр төв Засгийн газар нь орон нутгийг хянах, санхүүжүүлэх эрхээ тодорхой түвшинд хадгалсаар (хадгалахыг хүссээр) байдаг тул эрх мэдэл бүрэн шилжсэн эсэх нь зарим тохиолдолд эргэлзээ төрүүлдэг байна. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (2020)-ийн шинэчлэлийн хүрээнд орон нутгийн чиг үүргийг “эрх мэдэл шилжүүлэх” хэлбэрээр хуваарилна гэдгийг хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалд “чиг үүргийг орон нутаг бие даан шийдвэрлэх бөгөөд төрөөс үүнд оролцохгүй” гэсэн нь үүнийг батална.

Дэлхийн улс орнуудын төвлөрлийг сааруулах бодлого тухайн орны төрийн байгууламж, засаг захиргааны хуваарь, улс төрийн дэглэм, үндэстний үнэт зүйл, түүх, соёл болон шинэчлэлийн зорилгоос хамаарч харилцан адилгүй хэрэгжиж байгаа боловч дараах нийтлэг зарчмыг баримталдаг байна. Үүнд:

- Субсидиар буюу иргэдэд хамгийн ойр байгаа тухайн чиг үүргийг хэрэгжүүлэх чадавч бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид хуваарилах.
- Тодорхой байх буюу төрийн байгууллагын эрх хэмжээ, чиг үүрэг, хариуцлагыг төрийн байгууллагын түвшинд хооронд нь давхардалгүйгээр хуваарилах.
- Чиг үүрэг санхүүжилтийн эх үүсвэртэй байх буюу чиг үүргийг тухайн түвшинд хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийн хамт хуваарилах.
- Бүх талын оролцоог хангах буюу төвлөрлийг сааруулах бодлогыг хэрэгжүүлэхэд холбогдох төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангаж, харилцан зөвшилцөх.

- Нотолгоо, баримтад тулгуурлах буюу шинжлэх ухааны онол, арга зүй, судалгаа, дүн шинжилгээ, олон улсын сайн туршлагад тулгуурлах зарчим юм.

Гэхдээ төвлөрлийг сааруулах бодлого, үйл ажиллагаа нь субсидиар зарчимд суурилсан байх нь хамгийн чухал юм. Субсидиар зарчим нь улс төрийн эрх мэдэл нь нийгмийн хэрэгт маш тодорхой хязгаарласан тохиолдолд буюу нийгэмлэг (хүй элгэн) өөрөө удирдлагын зорилтоо шийдвэрлэж чадахгүй нөхцөлд л оролцож болно гэсэн үг юм (ОХУ-ын Улс Түмний Найрамдлын сургууль, 2017, хууд. 70).

Өмнө өгүүлсэн Европын Хартид субсидиар зарчим гэдэг ойлголтыг “төрийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх үүргийг иргэдэд хамгийн ойр байгаа эрх мэдэл бүхий байгууллагад өгөх ёстой (Нутгийн өөрөө удирдах ёсны Европын Харти, 1985, 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг)” гэж үздэг. Өөрөөр хэлбэл, субсидиар зарчмын дагуу хуваарилах гэдэг нь доод түвшний байгууллагууд өөрт байгаа боломжийг ашиглан төрийн үйлчилгээ үзүүлэх боломжгүй байгаа тохиолдолд л дээд түвшинд шилжүүлэхийг хэлдэг байна (Паул Витт, 2018, хууд. 23). Төвлөрлийг сааруулах үйл явц нь “дээрээс нь доош нь”, “доороос нь дээш нь” чиглэсэн гэсэн хоёр үндсэн загвараар дамжин хэрэгждэг. Тухайлбал, Хойд Америк болон Европын орнууд төвлөрлийг сааруулахдаа “дээрээс нь доош нь” чиглэсэн загварыг түлхүү хэрэглэдэг ажээ.

Харин “доороос нь дээш нь” чиглэсэн загварыг сүүлийн үед цөөн хэдэн улс орон ашиглаж байгаагийн нэг нь Швед улс юм (OECD, 2019).

### Зураг 1. Төвлөрлийг сааруулах дорос санаачилга гаргах загвар




Эх сурвалж: (Долгоржав Я., Төвлөрлийг сааруулж, үйлчилгээ хүргэх асуудалд, 1999)

Швед улсын туршлагаас харвал “орон нутгийн иргэдийн өөрсдийнх нь санаачилга идэвх, чармайлтад илүү тулгуурлах, нөгөө талаас төв Засгийн газрын зүгээс нэгэнт дороос бүрдсэн нөхцөл байдалд нийцүүлэн эрх мэдлийг оновчтой төлөөлүүлэх, шилжүүлэх ажлыг хослуулан хийх зохимжтой нөхцөлийг бүрдүүлэх (Долгоржав Я. , Төвлөрлийг сааруулж, үйлчилгээ хүргэх асуудалд, 1999)”-д анхаардаг байна (Зураг 1).

Төвлөрлийг сааруулах үйл явцыг хэрэгжүүлж байсан Ази, Номхон далайн орнуудын хувьд “дээрээс нь доош нь” буюу төвлөрсөн удирдлагын замаар төв Засгийн газар нь бүх санаачилгыг гартаа аван эрх мэдлийг янз бүрийн хэлбэрээр шилжүүлэх загварыг хэрэглэсэн байдаг (Долгоржав Я. , Төвлөрлийг сааруулж, үйлчилгээ хүргэх асуудалд, 1999). Үүнийг төвлөрлийг сааруулах уламжлалт загвар гэж нэрлэдэг (Зураг 2). Уламжлалт гэх загварыг хатуу төвлөрсөн тогтолцооны уламжлалтай, түүнийг дагаад орон нутаг нь ч гэсэн бие даасан эрх мэдлийг хэрэгжүүлсэн туршлагагүй орнуудад төв Засгийн газрын санаачилгаар түлхүү авч хэрэглэсэн байдаг.

**Зураг 2. Төвлөрлийг сааруулах замаар үйлчилгээ хүргэдэг уламжлалт загвар**



Эх сурвалж: (Долгоржав Я. , Төвлөрлийг сааруулж, үйлчилгээ хүргэх асуудалд, 1999)

### 2.3. Чиг үүргийн талаар хийгдсэн судалгаа, тэдгээрийн үр дүн

Судалгааны тайлан:

Улс орон бүр өөр өөрийн онцлогт тохирсон, орон нутгийн чадамждаа нийцүүлэн чиг үүргийг хуваарилахдаа төсвийн зарлагыг оновчтой санхүүжүүлэх, зарлагын хуваарилалтыг үр нөлөөтэй болгохын тулд “санхүүжилт нь үүрэг функцээ дагадаг” (Удирдлагын академи, 2012, хууд. 17) гэсэн зарчмыг баримтлан, тухайн чиг үүргийн зорилго, арга зүй, хамрах хүрээнээс хамаарч чиг үүргийн шинжилгээг хийж хэрэгжүүлдэг байна. Чиг үүргийн шинжилгээний үндсэн 5 төрлөөр (Ник Маннинг, Нил Парисон, 2004, хууд. 7-9) шинжилгээ хийсэн гадаадын улс орнуудыг товч дурдвал:

*Бодлого хөтөлбөрийн шинжилгээ* (Ач холбогдол багатай хөтөлбөрийг зогсоож, тэргүүлэх ач холбогдол бүхий хөтөлбөрт анхаарал хандуулах зорилготой): 1998 онд Казахстан улс “Чиг үүргийн шинжилгээ”, Бразил улс “Засгийн газрын хөтөлбөрийн шинжилгээ”;

*Үр ашгийн шинжилгээ* (Байгууллагын, бизнесийн үйл явцыг өөрчилснөөр бүтээгдэхүүнийг илүү үр ашигтайгаар нийлүүлж чадна гэж үздэг): 2001 онд Хойд Македон улс “Цалингийн санг бууруулах шинжилгээ”, 2002 онд Папуа Шинэ Гвиней улс “Жанжин штабын орон тоог цомхотгох үйл ажиллагаа”;

*Дээд түвшнээс эхлэн хийдэг хөтөлбөрийн болон үр ашгийн шинжилгээ* (Ач холбогдол багатай чиг үүргийг тэргүүлэх чиг үүрэг болгон өөрчлөх бодлогын хэмжээний шинэтгэл хийхэд буюу дээрээс доош чиглэхэд анхаарлаа хандуулдаг): Шинэ Зеланд улс “Төрийн салбарын шинжилгээ”;

*Яам агентлагийн түвшин дэх чиг үүргийн шинжилгээ* (Зарим хөтөлбөрийг өөрчлөх, зарим үйл ажиллагааг хасах, байгууллагын бүтцийг бүрэн хэмжээгээр өөрчлөхөд чиглэдэг): 2000-2001 онд Папуа Шинэ Гвиней улс Гадаад хэргийн яам болон Тээврийн яамны “Чиг үүргийн шинжилгээ”, Латви улс “Хөдөө аж ахуйн яамны чиг үүргийн шинжилгээ”, 2002 онд Микронезийн холбооны улсын Чуук муж “Төрийн сангийн чиг үүргийн шинжилгээ”;

*Доод түвшний буюу байгууллагын үйл явцын шинжилгээ* (Тодорхой яам, агентлагийн бүтцэд цогц өөрчлөлт оруулах, тодорхой чиг үүрэг, үйлчилгээнээс татгалзах, өөрчлөхөд чиглэдэг): Ямаик улс “Агентлагуудыг шинэчлэх шинжилгээ”, Танзани улс “Агентлагийн статусын шинжилгээ”, Их Британи улс “Захиргааны үйлчилгээг зах зээлд шилжүүлэх урьдчилсан шинжилгээ” хийсэн байна.

Мөн гадаадын зарим улс орнуудад хийсэн ач холбогдол бүхий чиг үүргийн шинжилгээнүүд бий. Үүнд: Бразилын Засгийн газрын хөтөлбөрүүдийн шинжилгээ, Канадын Засгийн газраас хэрэгжүүлсэн 1994 оны хөтөлбөрийн шинжилгээ болон Үйлчилгээ хүргэх боломжит механизмын шинжилгээ, Ямаик улсад хийсэн агентлагуудыг шинэчлэх шинжилгээ, Иорданы Захиргааны хөгжлийн газрын чиг үүргийн шинжилгээ, Казахстаны 1998 оны чиг үүргийн шинжилгээ, Шинэ Зеландын улсын салбарын шинжилгээ, Никарагуа улсын бүтэц, чиг үүргийн шинжилгээ, Папуа Шинэ Гвиней улсын чиг үүргийн шинжилгээ, Тайландын чиг үүргийн шинжилгээ, Тажикстан улс дахь чиглэлийн яамдын чиг үүргийн шинжилгээ, ОХУ-ын хөтөлбөрийн болон чиг үүргийн шинжилгээ, Молдав улсад хийсэн үндэсний хэмжээний чиг үүргийн шинжилгээг дурдаж болно.

Эдгээрээс гадна Франц, ХБНГУ, Португал, Испани улсын нутгийн өөрийн удирдлагад чиг үүрэг, эрх мэдэл хуваарилах харьцуулсан судалгааг ЭЗХАХБ-аас 2005 онд хийсэн бөгөөд эрх хэмжээ, чиг үүрэг зэрэг ойлголтуудыг нарийвчлан тодорхойлж, Европын холбоо, Европын зөвлөлөөс гаргасан дүрэм, зохицуулалтад чиг үүргийн хуваарилалт хэрхэн нийцэж буйг

харьцуулан шинжилж, эрх хэмжээ, үйлчилгээг нутгийн удирдлагад шилжүүлэн төвлөрлийг сааруулах зарчмыг тодорхойлон, зөвлөмж гаргасан байна. Судалгааны үр дүнгээс харахад Франц, ХБНГУ, Португал, Испани зэрэг улсад орон нутгийн чиг үүрэг адил байдлаар хуваарилагдсан байна.

Чиг үүргийн шинжилгээ хийсэн гадаад орнуудын туршлагаас үзэхэд улс орон бүр өөр өөрийн онцлогт тохируулан чиг үүргийн шинжилгээ хийсэн байгаа нь харагдаж байгаа бөгөөд гол төлөв яам, агентлагийн түвшинг хамарч, төрийн захиргааны төв байгууллага, төв Засгийн газрын санаачилгаар, гадаад дотоодын зөвлөхүүдийн хүчээр гүйцэтгүүлж, хөтөлбөрийн үр дүн, үр ашгийг дээшлүүлэх, төсөв хэмнэх, төрийн байгууллагуудын бүтэц, орон тоог өөрчлөх, цомхотгоход чиглэсэн нийтлэг байдалтай байна. Харин Молдав болон Европын холбооны гишүүн 4 орны нутгийн удирдлагын байгууллагын чиг үүргийн судалгаа нь орон нутгийн түвшинд хийгджээ.

Монгол Улсад чиг үүргийн хэд хэдэн шинжилгээ хийгдэж байсан боловч тэдгээр нь зөвхөн төрийн нэг байгууллага, эсвэл нэг салбарыг хамарч байв.

2005 онд Нээлттэй Нийгэм Форумас төв Засгийн газар болон орон нутгийн удирдлага, тэдгээрийн үүрэг, эрх мэдэл, чиг үүргийн хуваарилалт, төсвийн нөхцөл байдал, төрийн үйлчилгээний удирдлага зохион байгуулалтад тулгамдаж буй асуудлыг тодорхойлох болон тэдгээр асуудлыг олон улсын нийтлэг хандлагын дагуу шийдвэрлэж болох бодлогын зөвлөмж боловсруулахад чиглэсэн “Үндэсний ба нутгийн удирдлагын чиг үүргийн зохистой хуваарилалт” сэдвээр судалгаа хийжээ. Уг судалгаагаар засаг захиргааны нэгжүүдэд оноосон чиг үүргийн хуваарилалт нь хэт ерөнхийлсөн, орон нутгийн бүх түвшинд нэгэн төрлийн байдлаар хуваарилсан нь оновчгүй зохицуулалт бөгөөд хот хөдөөгийн онцлогийг харгалзаж орон нутаг дахь төрийн удирдлага ба нутгийн өөрийн удирдлагын эрх мэдэл, чиг үүргийн ялгаа заагийг Үндсэн хууль болоод бусад салбар хуулиудад тодорхой тусгаж өгөх зайлшгүй шаардлага байна гэж дүгнэсэн байна (Нээлттэй нийгэм форум, 2005).

Төрийн албаны шинэтгэлийн стратегитай уялдуулан чиг үүргийн шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх цаг болсон гэж үзсэний үндсэн дээр 2006-2007 онд ЗГХЭГ, ТАЗ-ийн захиалгаар Удирдлагын академийн судалгааны баг “Төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагын чиг үүргийн шинжилгээ” сэдэвт судалгааг хийж гүйцэтгэжээ. Уг судалгаанд нийт 11 яам, холбогдох агентлагууд, нийслэлийн ЗДТГ, дүүргүүд, мөн Хөвсгөл, Хэнтий, Ховд, Булган, Өмнөговь аймгийн ЗДТГ, аймаг бүрээс 2 сумын ЗДТГ-ыг судалгаанд хамруулан хариуцсан чиг үүргээ хэрэгжүүлэхэд тулгарч байгаа хүндрэл бэрхшээлийг тодорхойлж, түүнээс гарах арга замын талаар зөвлөмж боловсруулсан (Удирдлагын академи, 2007, хууд 38-41). Мөн төрийн чиг үүргийг орон нутагт үр нөлөөтэй шилжүүлсэн Англи, Канад,

Швед, Герман, Франц улсуудад хийгдсэн чиг үүргийн шинжилгээний арга туршлагыг тусгаж, жишээ болгон оруулсан байна. Тус судалгааны тайланд яам агентлагийн тоог цөөрүүлэх, яам тус бүрээр чиг үүргийн шинжилгээ хийж, чиг үүргийг хариуцах субъектийг тодорхой болгох, Засгийн газраас зайлшгүй хийгдэх чиг үүргийн хуваарилалт, төрийн байгууллагын бүтцийг тогтоох ажлын дарааллыг харуулсан бүдүүвчийг ашиглах саналыг дэвшүүлсэн байдаг.

2007 онд Дэлхийн банкны санхүүжилттэй ЕСТАС төслийн хүрээнд Сангийн яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Боловсрол, соёл шинжлэх ухааны яамдад чиг үүргийн шинжилгээ хийж яам тус бүрээр, түүний бүтцийн болон харьяа газар тус бүрээр гүйцэтгэх ажлуудыг нарийвчлан шинжилж, бүтэц орон тоонд шинжилгээ хийн тухай бүрт нь дүгнэлт гаргасан байдаг (Дэлхийн банк, 2007). Энэхүү судалгааны үр дүнгээс хууль тогтоомж, эрх зүйн актууд болон бодлогын тэргүүлэх чиг үүрэгт үзүүлэх нөлөөлөл, чиг үүргийн ангиллын талаар зөвлөмж боловсруулсан байна.

Нээлттэй Нийгэм Форумас 2008 онд “Орон нутгийн төсвийн зарлагын шинжилгээ” сэдэвт бодлогын судалгааг хийж гүйцэтгэсэн байна. Уг судалгаа нь төв, орон нутгийн удирдлагын байгууллага хооронд чиг үүрэг, нөөцийг хуваарилах асуудлыг судлан үзэж, төрийн байгууллагын үндсэн чиг үүргүүдийг ангилах талаар зөвлөмж гаргасан байна (Нээлттэй Нийгэм Форум, 2010). Тухайн судалгааны үр дүнд орон нутгийн чиг үүргийг хуваарилахдаа үйлчилгээ нь иргэдэд аль болох ойр байх, иргэд өөрсдийн хүртэх үйлчилгээний тоо хэмжээ, чанарыг сонгох эрхээр хангагдах, санхүүжилт нь чиг үүргээ дагах зарчмыг мөрдлөг болгох зөвлөмж боловсруулсан төдийгүй орон нутгийн үйлчилгээг гүйцэтгэлийн үр дүнгийн стандартад суурилан хүргэх (тухайлбал, боловсролын үйлчилгээ), санхүүжүүлэх загварыг санал болгосон байна.

НҮБХХ-өөс 2010-2011 онд хийсэн “Нутгийн удирдлагын чиг үүргийн шинжилгээ: Боловсролын салбар” судалгаагаар боловсролын салбарын хууль тогтоомжуудад шинжилгээ хийж, орон нутагт боловсролын салбарын үйлчилгээний чанар хүртээмж болон тулгарч буй бэрхшээлийг даван туулах талаар зөвлөмж боловсруулжээ.

2012 онд Азийн хөгжлийн банкны төслийн баг, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороотой хамтран яам агентлагийн чиг үүргийн давхардлыг арилгах, яам, агентлагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах зорилгоор эдгээр байгууллагын үндсэн чиг үүрэг, түүний хэрэгжилтэд шинжилгээ хийсэн. Олон улсын байгууллагуудын зүгээс чиг үүргийн шинжилгээнд ач холбогдол өгч тухайн салбар, эсвэл орон нутгийн түвшний гүйцэтгэж буй чиг үүргийг оновчтой болгох нь тухайн салбарыг хөгжүүлэх хөшүүрэг болж төвлөрлийг сааруулах боломжтой гэж үзэж байв (Удирдлагын академи, 2012, хууд. 36).

ЗГХЭГ-ын захиалгаар 2012 онд Удирдлагын академийн судалгааны багийн гүйцэтгэсэн “Төрийн болон нутгийн удирдлагын байгууллагуудын чиг үүргийн шинжилгээ” нь нутгийн өөрийн удирдлагын болон нутгийн захиргааны байгууллагуудын гүйцэтгэж буй чиг үүргийг голлон судалсан бөгөөд эдгээр байгууллага албан тушаалтнуудын үйл ажиллагаа нь тухайн орон нутагт ажиллаж буй салбарын босоо удирдлагатай байгууллагуудын чиг үүрэгтэй хэрхэн уялдаж байгааг шинжилснээрээ онцлог байсан. Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид төв, орон нутгийн байгууллагуудын чиг үүргийг тодорхойлсон хэдий ч хэрэгждэггүйг дурдаад чиг үүргийг хуваарилахдаа удирдлагын түвшин хооронд (босоо) болон байгууллага хооронд (хэвтээ) шилжүүлэх чиг үүргүүдийг ангилж, холбогдох хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах бодлогын зөвлөмж боловсруулжээ. [Удирдлагын академи, 2012, хууд. 135].

Судлаач Я.Бямбаяр “Төвлөрлийг сааруулж, нутгийн удирдлагыг бэхжүүлэх нь: Уламжлал, шинэчлэл, сургамж” сэдэвт докторын судалгааны бүтээлдээ төвлөрлийг сааруулах, орон нутгийн бие даасан байдлыг бэхжүүлэх талаар Монгол Улсын Үндсэн хуулиар зохицуулж ирсэн түүх болон өнөөгийн байдалд шинжилгээ хийж, тулгарч буй асуудлуудыг тодорхойлсон ач холбогдолтой судалгааг хийсэн.

Монгол Улсын төрийн болон нутгийн удирдлагын бодлогын мэргэжлийн зөвлөхүүдээс бүрдсэн судлаачдын баг 2017 онд “Үр нөлөө бүхий нутгийн удирдлагын тогтолцоо” сэдвээр ажиллаж бодлогын зөвлөмж боловсруулжээ (Конрад Аденауэр сан, 2017). Судалгаагаар төрийн байгууллагуудын чиг үүргийн хуваарь тодорхойгүй, энэ нь нутгийн удирдлагын үйл ажиллагааны үр дүнд сөргөөр нөлөөлж байгааг тогтоосон бөгөөд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагийн тухай хууль болон салбарын хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулснаар төв, орон нутгийн чиг үүргийг илүү нарын хуваарилах боломжтой гэж үзэн зөвлөмж боловсруулсан байна. (Цанжид, 2017).

УИХ-ын Тамгын газар, НҮБХХ-өөс хэрэгжүүлсэн төслийн хүрээнд 2019 онд “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн шинжилгээ” судалгааг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн түвшин хооронд эрх, чиг үүргийг хуваарилах эрх зүйн зохицуулалтын зарчмыг тодорхой болгох зорилгоор хийсэн байна (Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн шинжилгээ, 2019). Судалгаагаар засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн чиг үүргийн хуваарилалтыг нэгжийн болон бусад хуулиар тодорхойлж байгаа боловч хариуцлагын тогтолцоог сайжруулах, эрх, чиг үүргийн давхардал, тодорхой бус байдлыг арилгахад цаашид эрх зүйн орчныг сайжруулах хэрэгцээ, шаардлага байгааг (Монгол Улсын засаг захиргаа,

нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн шинжилгээ, 2019, хууд. 99) тодорхойлж, шийдвэрлэх саналуудыг дэвшүүлсэн.

ЗГХЭГ-т хэрэгжиж байгаа “Төвлөрлийг сааруулах бодлогын дэмжлэг” төслөөс 2020 онд “Орон нутагт хэрэгжүүлэхээр заасан чиг үүргүүд, тэдгээрийн хэрэгжилт, хүндрэл бэрхшээл, шийдвэрлэх арга замууд” нөхцөл байдлын судалгааг Сэлэнгэ аймгийн жишээн дээр хийсэн байна. Орон нутгийн чиг үүргүүд, тэдгээрийн хэрэгжилт, хүндрэл бэрхшээл, боловсронгуй болгох шаардлага, тулгамдсан асуудлыг тодорхойлох, хууль эрх зүйн хүрээнд шийдвэрлэх боломжийн талаар санал дүгнэлт боловсруулах зорилгоор хийсэн судалгааны үр дүнгээс үзэхэд тухайн чиг үүргийг хэрэгжүүлэхэд хуулиуд хоорондоо зөрчилтэй, давхардал болон хийдэлтэй, тодорхойгүй, хэт ерөнхий тусгагдсан байдал олон байна гэж судлаачид дүгнэсэн байна (ЗГХЭГ, Швейцарын хөгжлийн агентлаг, 2020). Улмаар чиг үүргийн шинжилгээг бүх шатанд хийж, чиг үүргийг дахин хуваарилах, үүнтэй холбоотой хүний нөөцийн бодлогыг оновчтой тодорхойлох, аймаг сумын ЗДТГ болон нутгийн захиргааны байгууллагуудын бүтэц, орон тоог чиг үүргийн шинжилгээний үр дүнд үндэслэн шинэчлэн батлах, төсвийг хянахдаа орон нутгийн нөхцөл байдал, онцлогийг харгалзан зохистой байдлаар тусгах шаардлагатай гэж үзсэн байна.

Мөн төслийн хүрээнд 2021 онд Хүний хөгжил, судалгаа сургалтын төвөөс “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуультай Төсвийн тухай хуулийг харьцуулсан судалгаа”-г хийж гүйцэтгэжээ. Энэхүү судалгаа нь шинэчлэн баталсан Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуультай Төсвийн тухай хуулийн орон нутгийн хэрэгжүүлэх чиг үүрэг, орон нутгийн төсвийн зарлага, санхүүжүүлэх эх үүсвэрийн талаарх заалт болон холбогдох бусад заалтууд хэрхэн нийцэж байгаа талаар харьцуулсан судалгааг хийж, санал дүгнэлт гаргах зорилготой байсан бөгөөд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн орлого, зарлага, эрх мэдэл, чиг үүрэг төр болон засаг захиргааны нэгж хооронд хэрхэн шилжсэн өөрчлөлтийг харьцуулан, хууль хэрэгжиж эхлэх үед үүсэж болзошгүй зөрчлүүдийг тодорхойлж санал дүгнэлтээ боловсруулсан байна (Хүний хөгжил судалгаа, сургалтын төв, 2021).

Уг төслөөс 2021 онд “Шинэчлэн баталсан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн орлого, зарлага, төсвийн тэнцэл, төсвийн шилжүүлэгт үзүүлэх үр нөлөө” сэдэвт судалгааг хийж, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн



дагуу аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн орлого, зарлага, тусгай зориулалтын шилжүүлэг, дээд шатны төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлгийн хэмжээнд орох өөрчлөлт, түүний үр нөлөөг тооцох болон аймаг, нийслэл, сум, дүүргийн түвшинд төсвийн төвлөрөл саарч, төсвийн бие даасан байдал нэмэгдэх эсэхийг шинжлэн дүгнэлт өгчээ. Судалгаанаас гарсан үр дүнд үндэслэн төвлөрлийг сааруулах бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд иргэнд хамгийн ойр нэгжид үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг төсөв, санхүүгийнх нь хамт хуваарилж, үр дүнг тооцдог байх нь төсвийн хөрөнгийн үр ашиг, үр дүнг дээшлүүлэхэд эерэгээр нөлөөлөх юм гэсэн саналыг дэвшүүлсэн байна (Шинэчлэн баталсан Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн орлого, зарлага, төсвийн тэнцэл, төсвийн шилжүүлэгт үзүүлэх үр нөлөө, 2021).

*Үндэсний хэмжээний хурал, чуулган дээр судлаачдын тавьсан илтгэл:*

2015 оны 12 сард “Нутгийн удирдлага: Сорилт ба шийдэл” үндэсний чуулганыг УИХ, ЕТГ, ЗГХЭГ, нийслэлийн ИТХ, НҮБХХ-ийн хамтран зохион байгуулсан. Уг чуулганаар нутгийн удирдлагад тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга замын талаар мэргэжлийн судлаачдын хийсэн судалгаа, шийдлийг хэлэлцсэн байна. Уг чуулганд хэлэлцүүлсэн судлаач Д.Сүнжидийн “Орон нутгийн түвшин дэх чиг үүргийн хуваарилалт” сэдэвт илтгэлд хуулиар тодорхойлсон нутгийн удирдлагын чиг үүрэг, түүнийг нэгжийн түвшинд тодорхойлсон байдалд дүн шинжилгээ хийж, тулгамдаж буй асуудлыг шийдэх хувилбарыг дэвшүүлсэн байдаг. Уг чуулганаас Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай болон бусад хуульд зохих өөрчлөлтийг оруулах, орон нутгийн чиг үүргийг хуваарилах, эрх шилжүүлэхдээ санхүүжилтийг давхар шилжүүлдэг байх, хуульд заасан нутгийн удирдлагын болон төрийн захиргааны байгууллагын эрх хэмжээг тодорхойлсон 300 гаруй хуулийг хамруулан чиг үүргийн шинжилгээ хийх замаар зураглалыг гаргах, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүдийг хот хөдөөгийн байдлаар чиг үүргийг нь ялгаатай тогтоох боломжийг судлах зөвлөмж боловсруулан гаргасан байна (Д.Сүнжид, 2016).

2018 оны 9 сард болсон Ардчиллын IV чуулганаар нутгийн захиргааны бие даасан байдлыг хангах, иргэдийн идэвх оролцоог нэмэгдүүлэх, төрийн эрх мэдлийг доод шатанд шилжүүлэх, иргэдэд үйлчилгээг ойртуулж шуурхай хүргэх асуудлуудын хүрээнд “Төвлөрлийг сааруулах замаар иргэдэд үйлчилгээг ойртуулах нь” ерөнхий сэдвээр илтгэл хэлэлцүүлж, харилцан туршлага солилцсон байна. Төвлөрлийг сааруулах бодлогыг амжилттай хэрэгжүүлэх үндсэн хэрэгсэл нь чиг үүргийг дахин хуваарилах бөгөөд чиг үүргийн шинжилгээгээр тухайн чиг үүргийн хууль эрх зүйн орчин, төсөв санхүүгийн орчныг шинжилж, дахин хуваарилалтад хамрагдах шаардлагатай чиг үүргийг тухайн чиг үүргийн хэрэгжилтэд

оролцогч бүх талууд буюу яам, агентлаг, аймаг, нийслэл, сум, дүүргийн захиргааны байгууллагын төлөөллийг оролцуулж оновчтой шийдэл гарган, уг шийдлийг хууль эрх зүйн орчинд нэмэлт өөрчлөлт оруулах санал болгон боловсруулах нь чухал гэдэг дээр чуулганд оролцогчид санал нэгдсэн байна (П.Зоригтбаатар, 2018).


1997-1999 он, 2001-2004 он, 2013, 2017-2020, 2021-2023 онуудад ИТХ-ын төлөөлөгчдийн эрх зүйн болон эдийн засгийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх, чадавхыг бэхжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газар, НҮБХХ, Швейцарын хөгжлийн агентлагаас хамтран “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхыг бэхжүүлэх нь” төслийг үе шаттайгаар хэрэгжүүлсэн. Уг төслийн хүрээнд бүх аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын төлөөлөгч, төрийн албан хаагчид, иргэний нийгэм болон хувийн хэвшлийн төлөөлөгч, иргэдэд зориулсан “Нутгийн удирдлагын чадавхыг дээшлүүлэх нь” сургалтыг зохион байгуулж, цуврал гарын авлагыг бэлтгэн гаргажээ.

#### **2.4. Судалгааны үзэл баримтлал**

Судлагдсан байдлын тоймоос үзвэл Монгол Улсын хувьд 1990-ээд оны эхэн үеэс орон нутагт эрх мэдэл шилжүүлэх, орон нутгийн бие даасан байдлыг дээшлүүлэх асуудал яригдаж эхэлжээ. Энэ үеэс төвлөрлийг сааруулах бодлогыг боловсруулж, эрх мэдэл, чиг үүргийг орон нутагт шилжүүлэх анхны алхам хийсэн байна.

Хатуу төвлөрсөн тогтолцоотой байсан манай орны хувьд “дээрээс доош” чиглэсэн буюу уламжлалт загварын дагуу эрх мэдэл, чиг үүргийг шилжүүлдэг. Энэ үүднээс 2020 онд баталсан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгад орон нутгийн чиг үүргийг тодорхойлохдоо “эрх мэдлийг бүрэн шилжүүлэх” (devolution) үзэл баримтлалыг агуулсан гэж үзээд орон нутгийн чиг үүргийг субсидиар зарчимд үндэслэн (Монгол Улсын Засгийн газраас баталсан “Чиг үүргийг дахин хуваарилах аргачлал”-д зааснаар) хуваарилж, энэхүү хуваарьт салбарын хууль тогтоомж, эрх зүйн бусад зохицуулалтыг нийцүүлэх ажил (Монгол Улсын Их Хурлын 2020 оны 45 дугаар тогтоолоор Засгийн газарт даалгасны дагуу) хийх ёстой гэсэн судалгааны ерөнхий үзэл баримтлалыг дэвшүүлж байна (Зураг 3).

### Зураг 3. Судалгааны үзэл баримтлал



Энэхүү үзэл баримтлалын хүрээнд орон нутгийн чиг үүргийг Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дагуу хэрхэн хуваарилсан, үүнд салбаруудын эрх зүйн зохицуулалтыг нийцүүлэх ажил яаж хийгдэж байгаа, энэхүү нийцүүлэх ажил нь хуулийн агуулгын хүрээнд байгаа эсэх, чиг үүргийг орон нутагт яаж хүлээн авч, хэрхэн хэрэгжүүлж байгааг авч үзэх боломжтой.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлд орон нутгийн эрхлэх асуудлыг “нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудал” гээд үүнийг “нутгийн өөрөө удирдах байгууллага бие даан шийдвэрлэх”-ээр заасан байдаг. Монгол Улсын Үндсэн хуульд заасан энэ агуулга нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 2020 оны шинэчилсэн найруулгад тусгалаа олж, аймаг, сум, баг, нийслэл, дүүрэг, хороо шийдвэрлэж байх чиг үүргийг тус тусад нь тогтоосон байна. Энэ нь төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд орон нутгийн чиг үүргийг дээрээс доод түвшинд ялгаатай хуваарилах үндэслэл болсон.

Тус хуулийн үзэл баримтлалаас харвал орон нутаг чиг үүрэгтэй байх эрх зүйн үндсийг бататгаж өгсөн төдийгүй аймаг, сум, баг, мөн нийслэл, дүүрэг, хорооны чиг үүргийг хуулиар тусгайлан тодорхойлж, нэгж тус бүрээр нь заагласан байна. Аймаг, нийслэлд сум, дүүргийн асуудлыг зохицуулах, хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, хяналт тавих чиг үүрэг давамгайлсан

байна. Харин сум, дүүрэг нь орон нутгийн өөрийн удирдлагын бие даасан нэгж байж, иргэдийн амьдралын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, орон нутгийн чиг үүргийн хэрэгжилтийг голлон хариуцах нэгж байхаар тусгажээ. Ингэхдээ иргэдэд хамгийн ойр нэгж болох баг, хороонд төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх, ойртуулах, иргэдийн оролцоог хангах чиг үүргийг хуваарилсан байна. Нутгийн өөрийн удирдлагын бусад хэлбэрийг хэрэгжүүлэх, эрх зүйн харилцаанд оролцох үндсийг бий болгож өгчээ.

# ГУРАВДУГААР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Уг судалгаа нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (2020)-д заасан орон нутгийн чиг үүргийн хэрэгжилтийн байдлыг тодорхойлоход чиглэсэн. Энэ утгаараа судалгаа нь тодорхойлох /дискрептив/ судалгааны төрөлд хамаарч байна. Иймд тодорхойлох судалгаанд тавигддаг шаардлага, түүний арга зүйг удирдлага болгон ажиллалаа.

## 3.1. Судалгааны эх олонлог, түүвэр

Судалгааны зорилгын хүрээнд 21 аймаг, 330 сум, 1648 баг, нийслэл, 9 дүүрэг, 204 хороо судалгааны эх олонлог болно. Гэхдээ судалгааны эх олонлог хэт өргөн, нөөц хязгаарлагдмал байгаа нь эх олонлогийн хүрээг хумих шаардлага үүссэн. Судалгааны зорилго, онцлогоос хамааран мужилсан (кластер) болон эксперт түүврийн аргад үндэслэн судалгааны түүврээр 4 аймаг, эдгээр аймгийн 13 сум, 1 тосгон болон нийслэл, нийслэлийн 2 дүүргийг сонгон авав. Ингэхдээ эхний шатанд аймгуудын өрсөлдөх чадварын индекс үндэслэн, хамгийн дээд ба доод эрэмбээс тус бүр хоёр аймаг, нийт дөрвөн аймгийг сонгосон. Тухайлбал, өрсөлдөх чадварын индекс (2022)<sup>2</sup>-ээр хамгийн дээд эрэмбэд Дорноговь (100), Орхон (97.33), хамгийн доод эрэмбэд Булган (47.14), Завхан (45.14) аймгууд багтсан. Түүврээр сонгогдсон эдгээр аймгууд нь Зүүн бүсээс бусад бүсийн төлөөллийг мөн хангаж байгаа болно. Дараагийн шатанд сонгогдсон аймгуудын сумд болон, нийслэлийн дүүргийг дараах шалгуурыг үндэслэн нарийвчлан тогтов. Үүнд:

- Судалгааны онцлог (Тухайлбал, орон нутгийн чиг үүрэг нь газар нутгийн байршил, тухайн орон нутгийн онцлогоос үндсэндээ хамаарахгүй, орон нутагт нийтлэг байдлаар хэрэгждэг хууль эрх зүйн хүрээ, удирдах албан тушаалтны мэдлэг ур чадвар, арга барилаас хамаардаг онцлогтой)
- Судалгаанд шаардлагатай өгөгдөл мэдээллийн олдоц
- Судлаачдын мэдлэг, туршлага, хамтын ажиллагаа
- Судалгаанд шаардлагатай төсөв, санхүүгийн нөөц
- Газар зүйн байршил, тээвэр логистикийн нөхцөл
- Хот суурин, хөдөөд гүйцэтгэж буй чиг үүргийн агуулга, ялгаа

Дээрх шалгуурын хүрээнд Дорноговь аймгийн Даланжаргалан, Өргөн, Сайншанд, Сайхандулаан; Завхан аймгийн Тосонцэнгэл, Улиастай, Цагаанчулуут, Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант; Булган аймгийн

2 Аймгуудын өрсөлдөх чадварын тайлан, 2022

Булган, Хангал, Хишиг-Өндөр сумд болон Хялганат тосгон; Нийслэл, нийслэлийн Багахангай, Баянзүрх дүүргийг судалгааны түүврээ болгов (Хүснэгт 1). Уг судалгааны түүврийг дараах хүснэгтэд нэгтгэн үзүүлэв.

### Хүснэгт 1. Судалгаанд хамрагдсан аймаг, сум, нийслэл, дүүрэг

№	Аймаг, нийслэл	Сонгогдсон сум, дүүрэг
1.	Дорноговь	Даланжаргалан Өргөн Сайншанд Сайхандулаан
2.	Орхон	Баян-Өндөр Жаргалант
3.	Булган	Булган Хангал Хишиг-Өндөр Хялганат (тосгон)
4.	Завхан	Тосонцэнгэл Улиастай Цагаанчулуут
5.	Улаанбаатар	Баянзүрх Багахангай

Энэхүү судалгаа нь захиалгат судалгаа бөгөөд судалгааны үр дүн нь зөвхөн түүврээр тогтоосон орон нутаг (засаг захиргааны нэгж)-т хамаарах болно.

### 3.2. Судалгааны үндсэн ойлголт, түүний хэмжүүр

Орон нутгийн чиг үүрэгт Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (2020)-ийн 20 дугаар зүйлд заасан эдийн засаг, нийгмийн шинжтэй асуудлыг хамаатуулан авч үзсэн. Орон нутгийн чиг үүргийн хэрэгжилтийг тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид хуулиар олгосон чиг үүргийг тухайн нэгжийн Хурал, Засаг даргаас хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд бие даан шийдвэрлэсэн байдлаар тодорхойлно.

## Хүснэгт 2. Судалгааны үндсэн ойлголт, тодорхойлолт, хэмжүүр

Үндсэн ойлголт	Тодорхойлолт	Хэмжүүр
Орон нутгийн чиг үүргийн хэрэгжилт	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид хуулиар олгосон чиг үүргийг тухайн нэгжийн Хурал, Засаг даргаас хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд бие даан шийдвэрлэсэн байдал	Хуулиар тогтоосон орон нутгийн чиг үүрэг ба энэ хүрээнд гаргасан Хурал, Засаг даргын шийдвэрийн үндэслэл, агуулгын нийцэл

### 3.3. Судалгааны өгөгдөл цуглуулах арга, үйл явц

Судалгааны зорилго, асуултад хариулт олохын тулд баримт бичиг судлал болон сурвалжилгын аргыг ашиглан шаардлагатай өгөгдөл мэдээллийг цуглуулав. Судалгаанд шаардлагатай суурь өгөгдөл нь хоёрдогч эх сурвалж бүхий мэдээлэл байсан тул баримт бичиг судлалын аргыг гол болгов. Уг аргын тусламжтайгаар орон нутгийн чиг үүрэг, түүний хэрэгжилттэй холбоотой мэдээллийг дараах хэрэглэгдэхүүнээс түүвэрлэн бүрдүүллээ. Тухайлбал,

- Эрх зүйн сурвалж (Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, салбарын хуулиуд, аймаг, сум, нийслэл, дүүргийн ИТХ-ын хуралдааны материал болон тогтоол, Засаг даргын захирамж, орон нутгийн хэмжээнд хэрэгжиж буй бодлогын баримт бичиг, холбогдох журам г.м)
- Ном бүтээл, өгүүлэл, тайлан (нутгийн удирдлага, чиг үүргийн талаарх гадаад, дотоодын судлаачдын бүтээл, өгүүлэл болон зарим түүхэн эх сурвалж бүхий баримт бичиг, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийн тайлан, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан г.м).

Судалгааны өгөгдөл цуглуулах үйл явц хоёр үе шаттайгаар хийгдсэн. Нэгд, судалгааны өгөгдөл цуглуулахтай холбоотой бэлтгэл ажлыг хангав. Энэ хүрээнд эрх зүйн эх сурвалжийн шинжилгээнд зориулж нийт 50 хуулийг түүвэрлэлээ (Хавсралт 1). Мөн түүврээр сонгогдсон орон нутгийн холбогдох албан тушаалтан (Засаг даргын Тамгын газрын дарга, ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга)-тай утсаар холбогдож судалгааны зорилгыг танилцуулж, тухайн орон нутагт судалгаа хийх хүсэлт бүхий албан тоотыг холбогдох удирдамжийн хамт урьдчилан хүргүүлсэн.

Хоёрт, бэлтгэл ажил хангагдсанаар судалгааны өгөгдөл цуглуулах нөхцөл бүрдэж, судалгааны багийн гишүүд түүврээр тогтоосон орон нутагт очиж

шаардлагатай өгөгдөл, мэдээллийг дараах хэрэглэгдэхүүнээс түүвэрлэн цуглуулав. Үүнд:

- Орон нутгийн чиг үүрэгтэй холбоотой Засаг дарга болон ИТХ-аас гаргасан шийдвэр (Засаг даргын захирамж, ИТХ-ын тогтоол)
- Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, түүний хэрэгжилтийн тайлан
- Орон нутгийн чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээнд гаргасан бодлогын баримт бичиг, холбогдох бусад мэдээлэл (стратегийн төлөвлөгөө, арга хэмжээний төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн тайлан)
- Орон нутгийн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн баримт бичиг (дүрэм, журам, заавар, удирдамж г.м)
- ИТХ-ын тэмдэглэл болон холбогдох бусад баримт бичиг (хороод, намын бүлгүүдийн санал, дүгнэлт)
- Орон нутгийн чиг үүрэг, үйл ажиллагаанд хамаарах төсөвтэй холбоотой баримт, бичиг, мэдээлэл (төсөвтэй холбоотой гаргасан шийдвэр, төсвийн зарцуулалтын тайлан г.м)
- Судалгааны ажлын үр дүнд олж цуглуулсан, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (2020)-ийн 20-26 дугаар зүйлд заасан чиг үүрэгтэй агуулгаараа хамаатай гэж үзэх, 728 ИТХ-ын тогтоол, 5547 Засаг даргын захирамжийг түүвэрлэн, нийт 6275 баримтыг үндсэн өгөгдөл болгон авсан (Зураг 4).

#### Зураг 4. Шинжилгээ хийсэн ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамж



Эх сурвалж: Судалгааны өгөгдөл

Үүнээс гадна баримт бичиг судлалын аргаар цуглуулсан өгөгдөл, мэдээллийнталаартодруулгаавах, заримэх сурвалжийнталаардэлгэрэнгүй мэдээлэл олох зорилгоор орон нутгийн холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага зохион байгуулсан. Үүнд аймаг, сум, нийслэл, дүүргийн



Засаг дарга, ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга, ЗДТГ-ын дарга, Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн дарга, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга, ЗДТГ-ын болон ИТХ-ын ажлын албаны холбогдох асуудлыг хариуцсан ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн, Тосгоны захирагч, Багийн ИНХ-ын дарга, Засаг дарга зэрэг нийт 75 хүн хамрагдсан.

#### **3.4. Өгөгдөлд шинжилгээ хийх арга, үйл явц**

Баримт бичиг судлал болон сурвалжилгын аргаар цуглуулсан өгөгдөлд агуулгын (контент) шинжилгээ хийж, түүний үр дүнг нэгтгэн дүгнэсэн. Тухайлбал, юуны өмнө баримт бичиг судлалын аргаар цуглуулсан бүх баримт, материалыг цэгцэлж, системчлэх ажил хийгдэв. Үүний хүрээнд өгөгдлийн боловсруулалт, шинжилгээнд бэлтгэх зорилгоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (2020)-д заасан орон нутгийн чиг үүрэгт хамаарах сүүлийн гурван жилийн (2021, 2022, 2023 он) ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамжуудыг хамаарал бүхий чиг үүргээр нь бүлэглэж хүснэгт бэлтгэв (Хавсралт 2 а, 2 б).

Мөн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 45 дугаар тогтоолын 1.3-т “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуультай бусад хууль тогтоомжийг нийцүүлэх, холбогдох хуулийн төслийг өргөн мэдүүлэхийг” Засгийн газарт даалгасны дагуу Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (2020)-д бусад хууль тогтоомжийг нийцүүлсэн байдлыг судлах зорилгоор 50 хуулийг багтаасан эрх зүйн эх сурвалжийн хүснэгтийг бэлэн болгов (Хавсралт 1). Ингэхдээ орон нутгийн чиг үүрэгт хамаарах тухайн баримтын гол утгыг илэрхийлж буй ангилалд нь сэдэвчлэн хамаатуулсан.

Дараагийн алхамд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан орон нутгийн чиг үүрэг нь засаг захиргааны нэгж бүрд хэрэгжиж буй бодит байдлыг тодорхойлоход чиглэсэн. Дээрх хоёр зорилгын хүрээнд шинжилгээг хийж, утга агуулгын нийцлийг гаргахдаа түлхүүр үгийг гол шалгуур болгон ашигласан. Тухайлбал, орон нутгийн чиг үүргийн хэрэгжилтийг судлахдаа хуульд заасан засаг захиргааны нэгж бүрийн чиг үүрэг болон аймаг, сум, нийслэл, дүүргийн ИТХ-аас гаргасан шийдвэр (тогтоол, захирамж) хоёрын агуулгын нийцлээр тодорхойлсон. Ингэхдээ Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд орон нутгийн чиг үүрэг гэж заасан эдийн засаг, нийгмийн шинжтэй асуудлын утга, агуулгыг нэр үгээр, харин тухайн чиг үүргийг хэрэгжүүлэх эрх зүйн үйлдлийг нь ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамжийн агуулгад асуудлыг шийдэж буй үйл үгээр нь мөшгөн хөөж, шинжилгээг хийсэн болно.

Гуравт, баримт бичгийн шинжилгээний үр дүнг нэгтгэж, дүгнэв. Гэхдээ энд цугларсан бүх баримтын агуулгыг задлан шинжилж багтаах боломж хязгаарлагдмал байсан тул орон нутгийн чиг үүрэг бүрийн хувьд тодорхой жишээ бүхий баримтыг авч өгөгдлийн шинжилгээг хийн, үр дүнг нэгтгэсэн болно. Харин цугларсан бусад баримтыг энэ чиглэлд судалгаа хийдэг, сонирхдог хэн бүхэн цаашид судалгааны эргэлтэд оруулж ашиглах боломж нь нээлттэй юм.

Дөрөвт, орон нутгийн холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага зохион байгуулж сурвалжилгын аргаар цуглуулсан өгөгдлийг шинжлэх үйл явц болно. Уг ажлыг гүйцэтгэхдээ эхлээд аудио хэлбэрээр цуглуулсан өгөгдлийг бичвэрт буулгаж, түлхүүр үгийн давтамж болон өгүүлбэрийн утга агуулгаар задлан шинжилсэн болно. Ингэхдээ баримт бичгийн шинжилгээний үр дүнг тодруулах, түүнийг бататгах, нэмэлт мэдээллээр баяжуулах ажлыг хийхийн зэрэгцээ Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан орон нутгийн чиг үүргийн хэрэгжилтийн өнөөгийн төлөв байдлыг тодорхойлов.

# ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ШИНЖИЛГЭЭ

## 4.1. Орон нутгийн чиг үүрэгт хамаарах хуулиудад хийсэн шинжилгээ

Судалгааны зорилтын хүрээнд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан орон нутгийн чиг үүргийг аймаг, сум, баг, нийслэл, дүүрэг, хороонд зааглан хуваарилсан талаар болон холбогдох бусад хуулиуд нь орон нутгийн чиг үүрэгтэй хэрхэн уялдаатай байгааг тодруулах шинжилгээг хийв. Шинжилгээг хийхдээ Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан дарааллаар авч үзсэн бөгөөд холбогдох салбарын хуулиуд дахь тухайн чиг үүрэгт шууд хамаарах зүйл, заалттай нь тулган нийцэж байгаа эсэхийг шалгалаа. Үүний зэрэгцээ Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсанаас хойш буюу 2020 оны 12 дугаар сарын 24-нөөс хойш холбогдох салбарын хуульд нэмэлт өөрчлөлт орсон эсэхийг мөн тодруулж, өмнө нь дурдсан “нийцүүлэх ажил” хийгдсэн эсэхийг тодруулсан болно (Хавсралт 3 а, 3 б).

Орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэхдээ аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал үзэл баримтлал, агуулгынх нь хувьд шийдвэрлэж, тухайн нутаг дэвсгэрт хэрэгжих хэм хэмжээг тогтоох бөгөөд тухайн шатны Засаг дарга уг асуудлыг нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах төрлийн шийдвэр гаргана. Харин Засаг даргын харьяа байгууллага, эрхлэх асуудлын хүрээний агентлаг болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, бусад холбогдох байгууллагууд хариуцан эрхлэн гүйцэтгэх, хэрэгжүүлэх, үйлчилгээг хүргэх ажлыг гүйцэтгэнэ.

Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын Үндсэн хуулийн 61 дүгээр зүйл, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт тус тус заасны дагуу нутгийн захиргааны байгууллагын бүтэц, зохион байгуулалт, орон тооны хязгаарыг нэг маягаар буюу нэг бүрчлэн тогтоодог.

Тухайн чиг үүргийг хэрэгжүүлэх ажил үүрэг, үйлчилгээг хүргэх бүтцийг энэхүү судалгааны хүрээнд аймаг, сум, нийслэл, дүүргийн түвшинд ямар байгууллага, нэгж, албан тушаалтан эрхлэн гүйцэтгэж байгааг товч шинжлэн үзэв.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасан **“Орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлт”** чиг үүргийг аймагт “дунд хугацааны хөгжлийн үндсэн чиглэл, бодлого, төлөвлөлт”, суманд “үндсэн чиглэл, бодлого,

төлөвлөлт”, нийслэлд “хөгжлийн бодлого, төлөвлөлт”, дүүрэгт “ерөнхий ба хэсэгчилсэн төлөвлөгөө” гэж хуваарилсан байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль (2020)-д “... аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” (тус хуулийн 6 дугаар зүйлийн 7 дахь хэсэг), “Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр” (тус хуулийн 6 дугаар зүйлийн 8 дахь хэсэг), “аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө” (тус хуулийн 6 дугаар зүйлийн 9 дэх хэсэг)-г аймаг, нийслэлийн ИТХ хэлэлцэх, батлах, буцаах (тус хуулийн 9 дүгээр зүйлийн 11 дэх хэсэг); аймаг, нийслэлийн Засаг дарга боловсруулж өргөн мэдүүлэх, төлөвлөлтийн баримт бичгүүдийн уялдааг хангах, зохицуулах, хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах (тус хуулийн 9 дүгээр зүйлийн 10 дахь хэсэг) чиг үүрэгтэй байхаар заажээ.

Харин сум, дүүрэгт хамаарах хөгжлийн төлөвлөлтийн чиг үүрэг нь тухайн нэгжид хамаарах ямар нэгэн төлөвлөлтийн баримт бичиг байх эсэхийг хуульд заагаагүйн улмаас зөвхөн дээд шатны нэгжийн хөгжлийн төлөвлөлтөд оролцох хэм хэмжээгээр тодорхойлогдсон байна. Тус хуулийн дээр дурдсан холбогдох зүйл заалтуудад 2021 оны 11 болон 12 дугаар сард нэмэлт өөрчлөлт оруулсан боловч орон нутгийн чиг үүрэгт нийцүүлээгүй байна.

Уг чиг үүргийн хувьд захиргааны ажил үүргийг нь аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, нийслэлд Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, дүүрэгт Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтэс, суманд Салбарын бодлогын мэргэжилтэн хариуцна.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т заасан **“Орон нутгийн өмчийн удирдлага”** чиг үүрэг нь аймаг, сум, нийслэл, дүүрэгт тус тусын өөрийн өмчийн ашиглалт, эзэмшилт, захиран зарцуулалт, түүнд тавих хяналтыг хэрэгжүүлэхээр заасан байна. Үүнд холбогдох хууль нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай (1996) бөгөөд уг хуульд “Орон нутгийн өмчийн зүйлс нь энэ хуулийн 3 дугаар зүйлд заасны дагуу нийтийн зориулалттай өмч, орон нутгийн өөрийн өмчөөс бүрдэнэ” (хуулийн 74 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг) гэдгээс өөрөөр орон нутгийн өмчийг ялган тодорхойлсон зүйл алга. Түүнчлэн орон нутгийн өмчийн харилцааг төрийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах журмаар (хуулийн 5 дугаар бүлэг) зохицуулж байна. Мөн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж тус бүрт өмч байх эсэх талаар зохицуулалт тодорхойгүй.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь тухайн нэгжийн “...өмчийн зүйлсийг хүн амаа төлөөлөн өмчлөгч нь...” (хуулийн 77 дугаар зүйлийн 1 дэх хэсэг) байхаар, Засаг дарга нь Хурлаас тогтоосон эрх хэмжээний хүрээнд орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах (хуулийн 78 дугаар

зүйлийн 2 дахь хэсгийн 1)-аар тогтоожээ. Эндээс үзвэл орон нутгийн өмч нь нийтийн өмчийн бие даасан нэг хэлбэр эсэх талаар тодорхойгүй хэвээр байна.

Тухайн чиг үүргийн хүрээнд захиргааны үүргийг аймаг, нийслэлийн түвшинд аймаг, нийслэлийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс; аймгийн түвшинд Орон нутгийн өмчийн газар; нийслэлийн түвшинд нийслэлийн Өмчийн харилцааны газар; дүүрэгт ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтэс, суманд Санхүүгийн алба хариуцан хэрэгжүүлнэ.

**“Орон нутгийн төсөв, албан татвар, төлбөр, хураамж”** чиг үүрэг нь аймаг, сум, нийслэл, дүүрэгт тухайн нэгжийн төсөв, түүний төлөвлөлт, гүйцэтгэл, тайлан, хяналтыг хэрэгжүүлэх болон хууль тогтоомжид заасан хүрээнд албан татвар, төлбөр, хураамжийн хувь хэмжээг тогтоох эрхээр тодорхойлогдсон байна. Төсвийн тухай хууль (2011)-д орон нутгийн төсвийг “...аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан, тухайн шатны төсөвт харьяалагдах ерөнхийлөн захирагчийн бүрдүүлж, хуваарилан зарцуулах төсөв” (Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 27) гэж тодорхойлсноос үзэхэд орон нутгийн чиг үүрэгт нийцэлтэй байна. Мөн хуульд аймаг, нийслэл (хуулийн 23 дугаар зүйлийн 9 дэх хэсгийн 1-3), сум, дүүрэг (хуулийн 23 дугаар зүйлийн 9 дэх хэсгийн 1-3)-ийн төсвийн орлого бол “орон нутгийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг, орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр, борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого” юм гэж заажээ.

Нутгийн өөрөө удирдах ёсны тухай Европын Хартийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “орон нутаг нь үндэсний эдийн засгийн бодлогын хүрээнд өөрийн гэсэн санхүүгийн зохих хэмжээний нөөцтэй байх, үүнийгээ өөрийн эрх мэдлийн хэмжээнд чөлөөтэй захиран зарцуулах эрхтэй” (Local authorities shall be entitled, within national economic policy, to adequate financial resources of their own, of which they may dispose freely within the framework of their powers) (Council of Europe, 1985) гэсэн байна. Мөн Европын Хартийн 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Орон нутгийн санхүүгийн нөөцийн ядаж нэг хэсэг нь өөрсдөө хувь хэмжээг нь тогтоох эрхтэй татвар, төлбөр, хураамжаас бүрдэнэ” (Part at least of the financial resources of local authorities shall derive from local taxes and charges of which, within the limits of statute, they have the power to determine the rate) гэж заажээ. Үүнээс үзэхэд орон нутгийн төсвийн дор хаяж тодорхой хэсэг нь орон нутгийн өмчөөс олох татварын бус орлого, орон нутаг өөрөө хувь хэмжээг тогтоосон татварын орлогоос бүрдэж, түүнийгээ өөрөө мэдэж захиран зарцуулдаг эрхтэй байж гэмээ нь орон нутгийн бие даасан төсвийн тогтолцоо бий болно.

Аймаг, нийслэлийн ИТХ-аас дараах төрлийн татвар, төлбөр, хураамжийн хувь хэмжээг Татварын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэгт заасны дагуу бие даан тогтоож байна. Үүнд:

- Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу ажлын байр, лангуу зэрэг тодорхой байршилд байрлахгүй ил задгай худалдаа, үйлчилгээ эрхэлж байгаа хувь хүний; хувиараа зорчигч, эсхүл ачаа тээврийн үйлчилгээ эрхэлж байгаа хувь хүний албан татварын хувь хэмжээг;
- Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу хөрөнгийн байршил, зориулалт, хэмжээ, зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн байдлыг харгалзан татварын хувь хэмжээг (уг хуульд 2021 оны 7 дугаар сарын 7-ны өдөр оруулсан нэмэлт өөрчлөлтөөр татварын хувь хэмжээг 0.6-1.0 хувь байсныг 0.6-2.0 хувь болгосон);
- Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэлд ногдуулах албан татварын хэмжээг;
- Нийслэл хотын албан татварын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт байршил, хүн амын төвлөрлийг харгалзан нийслэл хотын албан татварын хувь, хэмжээг (уг хуульд 2021 оны 7 дугаар сарын 7-ны өдөр оруулсан нэмэлт өөрчлөлтөөр татварын хувь хэмжээг 0-1.0 хувь байсныг 0-2.0 хувь болгосон);
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу ургамлын нөөц, тархац, ач холбогдол, ашиглагдах эрхтний онцлог, зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн байдлыг харгалзан ургамлын нэр төрөл тус бүрээр төлбөрийн хэмжээг;
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу рашаан ашигласны төлбөрийн хувь хэмжээг;
- Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу 22 төрөл (отоглох цэг, тамхи худалдах, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх гэх мэт)-ийн улсын тэмдэгтийн хураамжийн хувь хэмжээг;

Сум, дүүргийн ИТХ-аас дараах төрлийн татвар, төлбөр, хураамжийн хувь хэмжээг Татварын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу бие даан тогтоож байгаа. Үүнд:

- Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар малын тоо толгойн албан татварын хувь хэмжээг;

- Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь хэсэгт заасны дагуу тухайн нутаг дэвсгэрт мөрдөх хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хувь хэмжээг;

Харин Татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.21 дэх хэсэгт нохойны албан татвартай байхаар, 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэгт Монгол Улсын Их Хурлаас тусгайлан эрх олгосны дагуу аймаг, нийслэлийн ИТХ татварын хувь хэмжээг тогтоож болохоор заасан. Татварын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгыг 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөж эхэлснээс хойш Монгол Улсын Их Хурлаас аймаг, нийслэлийн ИТХ-д тусгайлан эрх олгоогүй байна. Өмнө нь нохойны албан татварын хувь хэмжээг аймаг, нийслэлийн ИТХ тогтоож байжээ.

Уг чиг үүрэгт хамаарах захиргааны чиг үүргийг (төсвийн төлөвлөлт, хэрэгжилт, татварын орлого бүрдүүлэх зэрэг) аймаг, нийслэл, дүүрэгт ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс, татварын газар/хэлтэс; суманд ЗДТГ-ын Санхүүгийн алба, татварын байцаагч хариуцан гүйцэтгэнэ.

**“Орон нутгийн сан”** хэмээх чиг үүрэг нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1.4-т зааснаар “орон нутгаас байгуулж ажиллуулж болох сангуудын ерөнхий нэр” гэж, эсвэл уг хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар “Төсвийн тухай хуульд зааснаас өөр, төсвийн бус хөрөнгөөс бүрдэх сангийн нэр” гэж ойлгохоор хоёрдмол утгатай болжээ. Гэтэл мөн хуулийн 21, 22, 24, 25 дугаар зүйлд аймаг, сум, нийслэл, дүүрэгт зөвхөн Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, хуваарилалт болон бусад сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, тайлан, хяналтыг хэрэгжүүлэх чиг үүргийг хуваарилсан байна.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Аймаг, сум, нийслэл, дүүрэг нь энэ хуульд заасан өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжих зориулалт бүхий Төсвийн тухай хуульд зааснаас өөр бусад сантай байж болно. Уг санг бүрдүүлэх эх үүсвэр нь төсвийн бус хөрөнгө байна” гэж зааж тус санг бүрдүүлэх, захиран зарцуулах, хяналт тавих журмыг тухайн шатны хурал тогтоохоор хуульчилсан байна. Аймаг, сум, нийслэл, дүүргийн ИТХ нь бараг бүгд орон нутгийн сантай байхаар журам боловсруулж баталсан байна. Гэтэл энэ сангийн зорилго, үйл ажиллагаа, хөрөнгийн эх үүсвэр, зарцуулалтын талаар аймаг, сумдын ИТХ-аас баталсан журмуудыг ХЗДХЯ одоог хүртэл бүртгээгүй байна.

Хурлаас баталсан эдгээр журмуудын талаар ХЗДХЯ болон Сангийн яамнаас ирүүлсэн нэг хариунд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4-т “төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх” гэж заасан тул Төсвийн тухай хуульд заасан бусад орлого буюу “төсвийн бус хөрөнгө” гэсэн ойлголт байхгүй

гэсэн нь Орон нутгийн санг Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу ийм санг байгуулах, ажиллуулах боломжгүйд хүргэснийг харуулж байна. Үүнээс үзэхэд “Орон нутгийн сан” хэмээх чиг үүрэгт Төсвийн тухай хууль болон бусад холбогдох хуулиудаа огт нийцэхгүй байна.

Уг чиг үүрэгт хамаарах захиргааны ажил үүргийг аймаг, нийслэл, дүүрэгт Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс, суманд Санхүүгийн алба, түүнчлэн аймаг, нийслэлд Худалдан авах ажиллагааны газар хэрэгжүүлнэ.

**“Орон нутгийн хүний нөөцийн бодлогын төлөвлөлт, хөтөлбөр”** чиг үүрэг нь зөвхөн аймаг, сумын хэмжээнд хэрэгжүүлэхээр хуульд заасан бөгөөд аймаг нь төлөвлөлт, хөтөлбөрийг, сум нь хөтөлбөрийн хэрэгжилт, ажиллах нөхцөлийг нь хариуцахаар тогтоосон байна. Хуульд заасан орон нутгийн чиг үүргийн дотор энэхүү чиг үүрэг нь ямар нэгэн салбарын хууль тогтоомжид хамаарахгүй.

Мэргэжилтэй хүний нөөцийг бэлтгэх, тогтвортой ажиллуулах, сургаж хөгжүүлэхтэй холбоотой хуулиар олгогдсон энэхүү чиг үүрэг нь аймаг, сумын хэмжээнд бие даан хүний нөөцийн төлөвлөлтийг хийж, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлагаар тодорхойлогдож байна. Гагцхүү Төрийн албаны тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсэгт “...төрийн албаны хөгжлийн бодлого, төлөвлөлтөд нийцүүлэн төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр боловсруулж ...” хэрэгжүүлэх бүрэн эрхийг Засгийн газарт ногдуулсан байгаагаас өөр зохицуулалтгүй байна.

Энэ чиг үүрэгт хамаарах захиргааны үүргийг аймаг, нийслэл, дүүрэгт ЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, суманд Засаг даргын Тамгын газрын дарга нутаг дэвсгэртээ хариуцан зохион байгуулна.

**“Орон нутгийн үйлдвэрлэл, хүнс, хөдөө аж ахуй”** чиг үүргийн тухайд аймагт хөтөлбөр, хэрэгжилтэд тавих хяналтыг, харин сум, дүүрэгт хэрэгжилтийг хариуцуулсан ба харин жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн менежментийг аймаг, нийслэлд хуваарилжээ.

Орон нутгийн үйлдвэрлэл, хүнс, хөдөө аж ахуйн чиг үүрэгт хамаарах дор дурдсан хуулиудыг шинжлэн үзвэл уг чиг үүрэгт нийцүүлсэн, орон нутагт хамаарах зохицуулалтыг өнөөг хүртэл хийгээгүй байна (Хүснэгт 3). Гэхдээ эдгээр хуулиудад 2020 оны 12 дугаар сарын 24-ны өдрөөс хойших хугацаанд нэмэлт өөрчлөлт орсон.



### Хүснэгт 3. Нэмэлт өөрчлөлт орсон хуулиуд

№	Хуулийн нэр	Батлагдсан он	Нэмэлт өөрчлөлт орсон он, сар
1.	Хоршооны тухай хууль	2021	2022.06.03
2.	Үйлдвэрлэл технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль	2022	2023.01.06
3.	Инновацын тухай хууль	2012	2021.12.07
4.	Таримал ургамлын үр сортын тухай хууль	2021	2022.11.11
5.	Тариалангийн тухай хууль	2016	2022.04.22
6.	Хүнсний тухай хууль	2012	2022.04.22
7.	Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль	2012	2022.11.11
8.	Малын генетик нөөцийн тухай хууль	2017	2021.12.30
9.	Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль	2017	2022.04.22
10.	Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль	2011	-
11.	Органик хүнсний тухай хууль	2016	2021.11.12 2022.11.11
12.	Баяжуулсан хүнсний тухай хууль	2018	2021.12.16 2022.11.11
13.	Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль	2019	2021.07.07 2022.04.22 2022.06.17

Эх сурвалж: Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем ([legalinfo.mn](http://legalinfo.mn))

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 18<sup>1</sup> дугаар зүйлийн 18<sup>1.1</sup> дэх хэсэгт “аймаг, нийслэлийн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн менежментийн асуудлыг хариуцах” гэж хуулиар нэмж, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг болон 24 дүгээр зүйлийн 1.6 дахь хэсэгт заасан “аймаг, нийслэлийн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн менежмент” гэсэн чиг үүрэгтэй нийцүүлсэн байна.

Гэхдээ уг чиг үүргийг хэрэгжүүлэх этгээд нь аймаг, нийслэлд “жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршооны асуудал хариуцсан байгууллага”, сум, дүүрэгт уг асуудлыг хариуцсан албан хаагч байхаар зааж, эрх хэмжээг нь хуваарилсан. Энэ нь “Жижиг, дунд үйлдвэрийн талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлэх” чиг үүргийн хүрээн дэх төрийн захиргааны байгууллагын эрх хэмжээг Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын хооронд дахин хуваарилах байдлаар л чиг үүргийн хуваарийг шийдвэрлэхийг оролдсон гэж болохоор байна. Өөрөөр хэлбэл, салбарын хуулийн зохицуулалт нь орон нутгийн чиг үүрэгтэйгээ бүрэн нийцээгүй байна.

Дээрх чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалт нь үйлдвэрлэл, хүнс, хөдөө аж ахуйн салбарын эрх зүйн зохицуулалтад хамаарах бөгөөд эдгээрээс Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 11, 12, 13, 14-т заасан бэлчээрийн менежмент, малын тэжээлийн нөөц бүрдүүлэлт, үйлдвэрлэлийн зориулалттай усан хангамж, мал, амьтны халдварт, шимэгчлэх өвчинтэй тэмцэх, хортон шавжийн устгал, хяналт, түүний гамшгаас урьдчилан сэргийлэх, хор хохирлыг арилгах, мал эмнэлгийн үйлчилгээ гэсэн чиг үүрэг нь төрийн чиг үүрэгт хамаарч байгаа бөгөөд эдгээрийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагаар төлөөлөн гүйцэтгүүлэхээр заасан байна.

Уг чиг үүргийн захиргааны ажил үүргийг аймаг, нийслэлд Хүнс, хөдөө аж ахуйн газар; дүүрэгт Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэс, Хөдөө аж ахуйн тасаг, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв; суманд Хөдөө аж ахуйн тасаг хариуцна.

**“Хүн амын ундны болон ахуйн хэрэгцээний усан хангамж”** чиг үүргийн хувьд нийслэлийн хүн амын ундны болон ахуйн хэрэгцээний уст цэгийн төлөвлөлт, хяналтыг нийслэлд; төвлөрсөн бус хүн амын ундны болон ахуйн хэрэгцээний уст цэгийн төлөвлөлт, байршил, ашиглалт, хамгаалалтыг дүүрэгт; сумын хэмжээний нийт уст цэгийн төлөвлөлт, байршил, ашиглалт, хамгаалалтыг суманд тус тус хуваарилсан бөгөөд бусдын эзэмшил, ашиглалтад олгоогүй уст цэгийн хамгаалалт, ашиглалт, зохицуулалтыг багт хэрэгжүүлэхээр заасан байна. Энэ хуулиар аймагт ямар нэг чиг үүрэг хуваарилаагүй.

Уг орон нутгийн чиг үүрэгтэй холбоотой асуудлыг Усны тухай хууль (2012) болон Байгаль орчныг хамгаалах тухай хууль (1995)-аар нарийвчлан зохицуулсан ч энэ нь засаг захиргааны нэгжид олгосон чиг үүрэг бус, харин ИТХ, Засаг даргын бүрэн эрхийн хүрээнд хэрэгжих зохицуулалттай байдаг. Тухайлбал, сум, дүүргийн Засаг дарга “усны нөөц хомсдох, гол, горхи, нуур, булаг, шанд, рашаан, худгийн ус ширгэх, бохирдох тохиолдолд тухайн эх үүсвэрээс ус ашиглахыг зогсоох, тэдгээрийг нөхөн сэргээх” (Усны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1.3 дэх хэсэг), баг, хорооны Засаг дарга “гол,

горхи, булаг, шанд, рашааны эхийг хамгаалах, ...бохирдлоос сэргийлэх арга хэмжээнд иргэдийг татан оролцуулах” (мөн хуулийн 15 дугаар зүйлийн 1.2 дахь хэсэг) гэх мэт эрх хэмжээ хамаарч байна. Эдгээр хуульд 2021 оны 7, 12 дугаар сар, 2022 оны 4, 6, 11, 12 дугаар сар, 2023 оны 1, 7 дугаар сард тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд орон нутгийн чиг үүрэгт нийцүүлэх талаар анхаарсан нь харагдаж байна.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд зааснаас үзвэл багийн чиг үүрэгт бусдын эзэмшил, ашиглалтад олгоогүй уст цэгийн хамгаалалт, ашиглалт гэсэн зохицуулалт хамаарч байна. Хүн амын ундны болон ахуйн хэрэгцээний усан хангамжтай холбоотой чиг үүрэг хорооны түвшинд огт байхгүй. Харин Усны тухай хуульд баг, хорооны Засаг даргын бүрэн эрхэд “нутаг дэвсгэртээ байгаа уст цэгийн ашиглалт, хамгаалалт, эзэмшилтэд хяналт тавих” гэж зааснаас үзвэл хууль хоорондын нийцэл байхгүй, мөн баг, хорооны Засаг даргад олгосон эрх хэмжээ нь илүү өргөн хүрээтэй байна.

Эндээс үзвэл “Хүн амын ундны болон ахуйн хэрэгцээний усан хангамж” гэсэн чиг үүргийг аймаг-нийслэл, сум-дүүрэг, баг-хороо хэмээн адилтган хуваарилсан бөгөөд уг хуваарилалтыг яам, Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллага тус бүрийн эрх хэмжээгээр задлан томъёолсон нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн чиг үүргийн хуваарилалтын үзэл баримтлалтай нийцэхгүй байна.

Энэ чиг үүрэг нь нийслэлд Байгаль орчны газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын инженерийн байгууламжийн хэлтэс, Ус сувгийн удирдах газар; аймагт Байгаль орчин, аялал жуулчлалын газар; суманд Байгаль орчны мэргэжилтний хариуцан гүйцэтгэх ажил үүрэгт хамаарна.

**“Худалдаа үйлчилгээний зохицуулалт”** нь аймаг, нийслэлд нийтлэг зохицуулалт, хяналт; суманд зохион байгуулалт, хяналт; дүүрэгт зөвшөөрөл, хяналт тавих гэж хуваарилагдсан байх бөгөөд Зөвшөөрлийн тухай хууль болон холбогдох салбарын бусад хуулиудаар зөвшөөрөл олгох, зохицуулалт хийх, хяналт тавих чиг үүрэг нь хуваарилагдсан байна. Тухайлбал, худалдаа, үйлчилгээний зохицуулалттай холбоотой орон нутгийн чиг үүрэг нь тухайн үйл ажиллагааныхаа төрлөөс хамааран ялгаатай хууль тогтоомжоор зохицуулагддаг. Холбогдох салбарын хууль тогтоомжид зааснаар худалдаа, үйлчилгээний талаарх асуудал нь орон нутагт тухайн шатны ИТХ, Засаг даргын бүрэн эрхийн хүрээгээр зохицуулагдаж байна. Тухайлбал, Тамхины хяналтын тухай хууль (2015)-ийн 7.3-р зүйлд “тамхи худалдах үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийг сум, дүүргийн Засаг дарга олгоно”, 11.1-д тус хуулийн биелэлтэд “...бүх шатны Засаг дарга хяналт тавих” гэж заажээ. Мөн “Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих,

архидан согтуурахтай тэмцэх тухай хууль (2022)“-д зааснаар “согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг аймаг, нийслэлийн Засаг дарга олгох” зохицуулалттай байна.

Энэ чиг үүргийн захиргааны ажил үүргийг аймагт ЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс; нийслэлд Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэс; дүүрэгт ЗДТГ-ын Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэс; суманд Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн хариуцан хэрэгжүүлнэ.

**“Орон сууц, нийтийн аж ахуй”** чиг үүргийн хувьд удирдлага, үйлчилгээг нь нийслэлд; зөвхөн удирдлагыг нь суманд хуваарилсан байх бөгөөд бусад нэгж, тухайлбал, аймаг, дүүрэгт энэхүү чиг үүрэг байхгүй байхаар хуульд заажээ. Харин Орон сууцны тухай хууль (1999)-д зааснаар аймаг, сум, нийслэл, дүүрэгт орон сууцны талаарх ИТХ, Засаг даргын бүрэн эрхийг тодорхойлсон байна. Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хууль (2003)-д зөвхөн аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрхийг тодорхойлсон. Эдгээр хуульд 2021 оны 12 дугаар сар, 2022 оны 4, 6, 11 дүгээр сард тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд орон нутгийн чиг үүрэгт нийцүүлэх ажил огт хийгдээгүй байна.

Тухайн чиг үүргийн хэрэгжилтийг аймагт Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар; аймгийн төвийн сумдад Тохижилт, үйлчилгээ ОНӨААТҮГ; нийслэлд Захирагчийн ажлын албаны Нийслэлийн орон сууцны бодлогын газар, Хот тохижилтын газар ОНӨААТҮГ; дүүрэгт ЗДТГ-ын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс хариуцна.

**“Орон нутаг дахь нийтийн тээвэр”** чиг үүргийн хүрээнд сум хоорондын нийтийн тээврийн зохицуулалтыг аймаг; нийтийн тээвэр, такси үйлчилгээний зохицуулалтыг нийслэл хариуцахаар тогтоосон байна. Авто тээврийн тухай хуульд нутаг дэвсгэртээ нийтийн тээврийн нийтлэг зохицуулалтыг хийх аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын бүрэн эрхийг тодорхойлсноос үзэхэд орон нутгийн чиг үүрэгт нийцүүлсэн гэж үзэх үндэслэлгүй байна. Өөрөөр хэлбэл, аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргад нийтлэг байдлаар бүрэн эрх олгосон нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан орон нутгийн чиг үүрэгт нийцэхгүй байна. Энэ хуульд 2020 оны 12 дугаар сарын 24-ны өдрөөс хойш 5 удаа нэмэлт өөрчлөлт оруулсан боловч “нийслэл, сум” гэснийг “сум, нийслэл” гэж өөрчилснөөс өөрөөр орон нутгийн чиг үүрэгт нийцүүлэх ажил хийгдээгүй байна.

Энэхүү чиг үүргийг аймагт ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс; нийслэлд Нийтийн тээврийн газар хариуцан зохион байгуулна.

**“Суурин газрын замын хөдөлгөөн, авто зогсоол”** чиг үүргийн тухайд зохицуулалт, автозам, зогсоолын төлөвлөлт, байршлын зохион байгуулалтыг нийслэлд; авто зогсоолын арчилгааг дүүрэгт; зохион байгуулалтыг суманд тус тус ноогдуулсан байна. Харин замын хөдөлгөөнийг зохицуулах, аюулгүй байдлыг хангахтай холбоотой чиг үүргийг Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд тухайлан зааглаж хуваарилаагүй байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль (2015)-д аймаг, сум, нийслэл, дүүргийн ИТХ, Засаг даргын бүрэн эрхийг тодорхойлсон байгааг орон нутгийн чиг үүрэгтэй нийцүүлээгүй байна. Харин Авто замын тухай хууль (2017)-д замын байгууламжийн талаар (үүнд авто зогсоол хамаарна) заахдаа авто замыг эзэмшигч нь “...өөрийн эзэмшлийн авто зам, замын байгууламжийн засвар, арчлалтыг хариуцна” гэж (мөн хуулийн 17 дугаар зүйлийн 5 дахь хэсэг) заасан байх бөгөөд нийслэл, орон нутгийн чанартай авто зам, түүний зурвас газрыг эзэмшигч нь аймаг, нийслэлийн Засаг дарга байхаар мөн хуульд (17 дугаар зүйлийн 3 дахь хэсэг) заасан байгаа юм. Орон нутгийн чиг үүрэгт заасан авто зогсоолын төлөвлөлт, байршлын зохион байгуулалтыг хариуцах чиг үүрэг нь нийслэлийн хувьд хуульд нийцэж байгаа боловч аймгийн чиг үүрэгт энэ нь байхгүй юм.

Дээрх чиг үүргийг нийслэлд Нийслэлийн замын хөдөлгөөний төлөвлөлт, зохицуулалт, инженерчлэлийн газар, Замын хөдөлгөөний удирдлагын төв хэрэгжүүлнэ. Энэ чиг үүргийн тодорхой хэсгийг Тээврийн цагдаагийн алба хариуцан гүйцэтгэнэ.

**“Гудамж, талбайн нэр, хаягжуулалт”** чиг үүргийн хүрээнд “гудамж, талбайн нэр, хаягжилтын нийтлэг зохицуулалт” гэх нэрээр аймагт; “гудамж, зам талбай, барилга байгууламжийн нэр, хаягжуулалтын зохицуулалт” гэх нэрээр нийслэлд тус тус хуваарилсан байна.

Улсын бүртгэлийн ерөнхий хууль (2018)-д гудамж, талбайн нэр, хаяг, хаягжуулалтын асуудлыг тусгахдаа “хаягийн сан”-г “хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлсэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, хороолол, гудамжны нэр, байрны дугаар, газар, усны нэрийн жагсаалт” гэж тодорхойлсноос өөрөөр орон нутаг, түүний дотор ИТХ, Засаг даргад эрх хэмжээ олгосон зохицуулалтгүй байна.

Хаягжуулалтын тухай хуулиар (2013) гудамж, талбайн нэр, хаягжуулах ажил (үг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.10 дахь хэсэг)-ыг аймаг, нийслэлийн Засаг даргад хариуцуулсан нь харагдах боловч гудамж талбайд нэр өгөх эрхийг зохицуулсан хуулийн заалт алга. Засгийн газрын 2019 оны 325 дугаар тогтоолоор баталсан “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам”-нд хот, суурин газрын гудамж, талбайд нэр өгөх, өөрчлөх, нэрэмжит болгох санал боловсруулах үүрэг бүхий төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн төлөөлөөс бүрдсэн 9-11 хүний бүрэлдэхүүнтэй

орон тооны бус комиссыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын дэргэд байгуулж ажиллуулах бөгөөд энэхүү комисс нь гудамж, талбайд нэр өгөх, өөрчлөх, нэрэмжит болгох саналыг боловсруулж, Засаг дарга нь шийдвэрлүүлэхээр заасан байна. Үүнээс гадна ИТХ-д зөвхөн гудамж, үл хөдлөх эд хөрөнгийн дугаарлалтын эхлэлийг тогтоох эрхийг олгосон, Засаг даргад орон нутгийн энэхүү чиг үүргийн тодорхой хэсгийг эрх хэмжээ болгон хэсэгчлэн шилжүүлсэн байгаа нь уг журмыг Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан орон нутгийн чиг үүрэгт нийцүүлэх шаардлагатай байгааг нотолж байна.

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн дагуу Засгийн газраас гаргасан 2022 оны 180 дугаар тогтоолын 3 дахь хэсэгт “Харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд гудамж, зам, талбай, үл хөдлөх хөрөнгийн хаягийн мэдээллийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах, хаягжуулах ажлыг шуурхай, үр дүнтэй зохион байгуулах, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг орон нутгийн төсөвт тусгаж шийдвэрлүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, хаягжуулалтын үйл ажиллагааг дэмжиж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд тус тус даалгасугай” гэж заасан нь орон нутгийн чиг үүргийг хуваарилсан, Засаг даргыг үүрэгжүүлсэн хэрэг биш, нэг удаа гүйцэтгэх ажил үүрэг төдий болжээ.

Тухайн чиг үүргийг аймаг, нийслэл, дүүрэгт Улсын бүртгэлийн газар, хэлтэс; суманд Улсын бүртгэгч хариуцан хэрэгжүүлнэ.

**“Хөшөө дурсгалын зохицуулалт”** чиг үүргийг хуваарилахдаа аймаг, нийслэлд хөшөө дурсгалын нийтлэг зохицуулалт, суманд хөшөө дурсгалын байршил, хамгаалалтыг хариуцуулсан байна. Гэхдээ Соёлын өвийг хамгаалах тухай хууль (2014)-д “хөшөө дурсгал” нь “түүх, соёлын үл хөдлөх дурсгал”-ын нэг төрөл бөгөөд аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, Засаг дарга нь соёлын биет өв, түүний дотор түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, бүртгэх, үзлэг тооллого хийх, зохистой ашиглах, хяналт тавих бүрэн эрхтэй болохыг зааж өгсөн байна. Хэдийгээр энэхүү хуульд 2022 оны 4 дүгээр сард нэмэлт өөрчлөлт оруулсан боловч Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан орон нутгийн чиг үүрэгт нийцүүлэх ажил хийгээгүй байна.

Соёлын өвийг хамгаалах тухай хуульд “Соёлын биет өвийг түүх, соёлын үл хөдлөх дурсгал болон хөдлөх дурсгалт зүйл” гэж ангилаад Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 19-д “түүхэн дурсгалт зүйлийн хамгаалалт” нь төрийн чиг үүрэг бөгөөд орон нутаг төлөөлөн гүйцэтгэхээр заажээ. “Түүхэн дурсгалт зүйл” гэдэгт соёлын биет өвийг бүхэлд нь хамааруулан ойлгох бөгөөд энэ хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 13-т “хөшөө дурсгалын зохицуулалт” гэж заасныг дотроо агуулж байгаа гэж үзэхээр байна.

Соёлын өвийг хамгаалах тухай хуульд зааснаар аймаг, сум, нийслэл, дүүргийн ИТХ-д соёлын өвийг хамгаалах бодлого, чиглэл, төсөв батлах, санал гаргах, үнэлэлт дүгнэлт өгөх болон сум, дүүргийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтыг батлах, баг, хорооны ИНХ-д соёлын өвийг хамгаалахад олон нийтийг татан оролцуулах, оролцоог урамшуулах санал гаргах бүрэн эрхийг олгожээ. Харин аймаг, нийслэлийн Засаг даргад соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, ашиглах, хамгаалах, хяналт тавих, сэргээн засварлах, сурталчлах, оролцоог урамшуулах, сум, дүүргийн Засаг даргад соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, хамгаалах, хяналт тавих, сэргээн засварлах, баг, хорооны Засаг даргад соёлын өвийг хамгаалахад олон нийтийг татан оролцуулах, оролцоог урамшуулах ажлыг тус тус зохион байгуулахаар хуульд заажээ.

Энэ нь “хөшөө дурсгалын зохицуулалт” төдийгүй “соёлын үл хөдлөх биет өв”-тэй холбоотой эрх хэмжээг Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга болон ИТХ, ИНХ-уудад дахин хуваарилах байдлаар чиг үүргийн хуваарийг шийдвэрлэхийг оролдсон гэж үзэж болохоор байна. Энэ чиг үүргийг аймаг, нийслэлд Соёл урлагийн газар, ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс; дүүрэгт ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн хэлтэс, суманд ЗДТГ-ын Нийгмийн бодлогын мэргэжилтэн хэрэгжүүлнэ.

**“Нийтийн эзэмшлийн зам, талбай, олон нийтийн соёл амралтын хүрээлэн, ногоон байгууламж”** чиг үүргийн хувьд төлөвлөлт, хяналт болон хот байгуулалт, барилга, стандарт, хяналт, зохицуулалтыг нийслэлд, арчилгаа, хамгаалалтыг дүүрэгт, ашиглалт, хамгаалалтыг суманд хуваарилсан байна. Хот байгуулалтын тухай хууль [2008]-д хот байгуулалтын талаарх (түүний дотор нийтийн эзэмшлийн зам, талбай, олон нийтийн соёл амралтын хүрээлэн, ногоон байгууламжийн асуудал ороод) аймаг, нийслэлийн ИТХ, Засаг даргын бүрэн эрхийг тодорхой заасан боловч Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсанаас хойш эдгээр бүрэн эрх болон бусад зохицуулалтыг орон нутгийн чиг үүрэгт нийцүүлэх ажил хийгдээгүй байна.

Гагцхүү “Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль”-д энэхүү чиг үүрэг нь нийслэлийн хэмжээнд тодорхой тусгагдсан бөгөөд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан “орон нутгийн чиг үүрэг”-тэй нийцсэн гэж үзэж болохоор байна.

Уг чиг үүргийг аймагт Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар; нийслэлд Хот байгуулалт, хөгжлийн газар, Хот тохижилтын газар ОНӨААТҮГ, Захирагчийн ажлын албаны Хотын ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн хэлтэс; дүүрэгт ЗДТГ-ын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс хэрэгжүүлнэ.

**“Орон нутгийн аялал, жуулчлалын бодлого, менежмент”** чиг үүргийг аймаг, нийслэлд, үйл ажиллагааны зохицуулалтыг нь суманд хэрэгжүүлнэ гэж Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан.

Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулга (2023)-д аймаг, нийслэлийн ИТХ-д “бодлого, хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, Засаг даргын тайланг хэлэлцэх”, аймаг, нийслэлийн Засаг даргад “бодлогын хэрэгжилтийг хангах, дэд бүтцийг хөгжүүлэх, сурталчлан таниулах” эрх хэмжээтэй байхаар заасан нь орон нутаг бие даасан бодлого боловсруулж, хэрэгжүүлэх чиг үүргийг уг хуульд тусгаагүй орхижээ. Энэ нь салбарын эрх зүйн зохицуулалтыг орон нутгийн чиг үүрэгт нийцүүлэх ажиллагаа хийгдээгүйг харуулж байна.

Гэхдээ Аялал жуулчлалын тухай хуулиар сум, дүүргийн Засаг даргад нутаг дэвсгэртээ аялал жуулчлалын арга хэмжээ зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх, иргэдийн оролцоог хангах, зохицуулах, хяналт тавих бүрэн эрх олгосон нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан сум, дүүргийн чиг үүрэгтэй тодорхой хэмжээгээр нийцэж байна гэж үзэж болно.

Дээрх чиг үүргийг аймагт Байгаль орчин, аялал жуулчлалын газар; нийслэлд Аялал жуулчлалын газар хэрэгжүүлнэ.

**“Хог хаягдлын менежмент”** чиг үүргийг аймагт “аюултай болон үйлдвэрлэлийн хог хаягдлын менежмент”, суманд “хог хаягдлын цэгийн байршил, энгийн хог хаягдлын менежмент”, нийслэлд “нэгдсэн төлөвлөлт, удирдлага, зохицуулалт” гэж хуваарилсан байхад харин дүүрэгт ерөнхий утгаар нь “хог хаягдлын менежмент” гэж томъёолсон байна. Хог хаягдлын тухай хууль (2017)-д “энгийн хог хаягдлын менежмент” сум, дүүргийн түвшинд, “аюултай хог хаягдлын менежмент” нь аймаг, нийслэлийн түвшинд байхаар зохицуулсан нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан “орон нутгийн чиг үүрэг”-тэй зарим талаар нийцэж байна.

Түүнчлэн Хог хаягдлын тухай хуульд аймаг, сум, нийслэл, дүүрэг нь “хог хаягдлын мэдээллийн дэд сан”-тай байхаар, мөн хог хаягдлын менежментэд зориулсан “төсөв”-тэй, түүнийгээ зарцуулах эрхтэй байхаар заасан нь орон нутгийн чиг үүрэгт нийцэж байгааг харуулж байна.

Харин хог хаягдлын талаарх нийслэл, дүүргийн чиг үүргийг хэт өргөн хүрээтэй, ерөнхий утгаар заасан нь нэг талаас орон нутаг Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх, нөгөө талаас салбарын холбогдох хуулийг мөрдөж, ИТХ, Засаг дарга бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд өөр хоорондоо зөрчилдөж мэдэхээр байна.



Энэхүү чиг үүргийг аймагт Байгаль, орчин аялал жуулчлалын газар; аймгийн төвийн сумдад Тохижилт, үйлчилгээ ОНӨААТҮГ; нийслэлд Захирагчийн ажлын албаны Орчны бохирдол, хог хаягдлын удирдлагын хэлтэс; дүүрэгт Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Хот тохижилтын газар ОНӨААТҮГ хэрэгжүүлнэ.

**“Оршуулгын газрын зохицуулалт”** чиг үүргийг “нийтлэг зохицуулалт, менежмент” гэж нийслэлд; “үйл ажиллагааны зохицуулалт” гэж сум, дүүрэгт тус тус хуваарилаж, харин аймагт энэ талаар чиг үүрэг хуваарилаагүй байна. Газрын тухай хууль (2002)-д “нийтийн эдэлбэр газарт ... оршуулгын газар хамаарна [Хуулийн 12 дугаар зүйлийн 2 дахь хэсэг]” гэж заасан ч оршуулгын газрын зохицуулалтын талаар тус хуульд тодорхой заалт алга байна. Нийслэлийн хэмжээнд уг асуудлыг нийслэлийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн нутаг дэвсгэрт оршуулгын үйл ажиллагаа зохион байгуулах журам”-ын дагуу зохицуулж байна.

Энэ чиг үүргийг аймагт Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар; нийслэлд Газар зохион байгуулалтын алба, Улаанбаатар буян компани хариуцна.

**“Төрийн болон орон нутгийн өмчийн боловсрол, эрүүл мэнд, нийгэм, соёлын байгууллагын барилга, байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар”** гэх чиг үүргийг нийслэлд “нийслэлийн музей, театр, номын сан, соёлын ордон, биеийн тамир, спортын цогцолборын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар” гэж, аймагт эдгээрээс гадна “аймгийн музей, театр, номын сан, соёлын ордон, биеийн тамир, спортын цогцолбор, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, нэгдсэн эмнэлгийн ашиглалт, засвар”; суманд “сумын сургууль, цэцэрлэг, эмнэлэг, соёлын төв, номын сан, биеийн тамир, спортын цогцолборын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар”, дүүрэгт “дүүргийн сургууль, цэцэрлэг, эмнэлэг, соёлын төв, номын сан, биеийн тамир, спортын цогцолборын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар” -ыг хариуцан зохион байгуулахаар заажээ.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 18-д “төрийн болон орон нутгийн өмчит, төрийн үйлчилгээний байгууллагуудын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар”-ыг орон нутаг хариуцахаар заасан боловч тухайн чиг үүргийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүдэд хуваарилахдаа байгууллагуудын тус тусын өмчлөлийн барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засварыг хариуцуулахаар тогтоосон нь төрийн өмчит боловсрол, эрүүл мэнд, нийгэм, соёлын байгууллагын барилга, байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засварыг хуваарилаагүй үлдсэнийг харуулж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль (1996)-ийн 78-р зүйлийн 2 дахь хэсгийн 1-д Засаг дарга нь “ИТХ-аас олгосон эрх хэмжээний дотор орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах” бүрэн эрхтэй байхаар заасан нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар орон нутгийн чиг үүргийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүдэд хуваарилсантай нийцэж байна.

Төрийн өмчийн боловсрол, эрүүл мэнд, нийгэм, соёлын байгууллагын барилга, байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засварыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9<sup>1</sup> дүгээр зүйлд зааснаар төрийн өмчийн эд хөрөнгийг эзэмших, ашиглах, хамгаалах ажлыг эрхлэн гүйцэтгэх үүрэгтэй Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцна. Энэ нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан орон нутгийн чиг үүрэгтэй зөрчилдөж байна.

Уг чиг үүргийг аймагт Боловсрол, шинжлэх ухааны газар; нийслэлд Боловсролын газар, аймаг, нийслэлд Эрүүл мэндийн газар; аймаг, нийслэл, дүүрэгт ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс; суманд Нийгмийн бодлогын мэргэжилтэн хариуцан хэрэгжүүлнэ.

**“Гал түймэр, үерийн хамгаалалтын байгууламж, суваг шуудуу”** чиг үүргийн хувьд тэдгээрт хамааралтай барилга байгууламжийн арчлалтыг сум, төлөвлөлт, ашиглалт, хяналт тавих эрхийг аймаг, нийслэл хэрэгжүүлэхээр Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заажээ. Харин Галын аюулгүй байдлын тухай хууль (2015)-ийн 15 дугаар зүйлд аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын үүргийг тогтоож өгсөн байдаг. Тухайлбал, Засаг дарга хууль тогтоомж, галын аюулгүй байдлын норм нормативыг хэрэгжүүлэх, гал түймэртэй тэмцэх, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх гэх мэт үйл ажиллагааг хариуцах үүрэгтэй.

Ойн тухай хууль (2012)-д аймаг, сум, нийслэл, дүүргийн ИТХ нь гал түймрээс хамгаалах арга хэмжээний хөтөлбөр, төсөв батлах, биелэлтийг нь сонсох, хяналт тавих бүрэн эрхтэй байхаар, Засаг дарга нь гал түймрээс хамгаалах хөтөлбөр боловсруулах, биелэлтийг хангах, түймэр унтраах ажлыг зохион байгуулах, хяналт тавих, хохирлын хэмжээг тогтоох, нөхөн төлүүлэх, ойг нөхөн сэргээх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтийг хангах бүрэн эрхтэй байхаар тогтоосон. Үүнээс үзэхэд эдгээр бүрэн эрх нь орон нутгийн чиг үүрэгт хамааралгүй, харин төрөөс төлөөлөн гүйцэтгэх чиг үүрэгт илүү хамааралтай байгаа нь харагдаж байна.

Харин үерийн хамгаалалтын байгууламжтай холбоотой асуудлаар Усны тухай хууль (2012)-д зааснаар аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрхэд “үерийн аюул, болзошгүй хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, уршгийг

арилгах” (хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д) арга хэмжээтэй холбоотой бүрэн эрх бий.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 20-д заасны дагуу “гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа” нь төрийг төлөөлөн гүйцэтгэх чиг үүрэг бөгөөд Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 20-д зааснаар “гамшгаас урьдчилан сэргийлэх” гэдэг нь “аюулт үзэгдэл, ослын хор уршиг, хохирол, сөрөг үр дагавраас зайлсхийх, таслан зогсоох, бууруулах зорилгоор авч хэрэгжүүлж байгаа цогц арга хэмжээ” гэж тодорхойлсон тул “гал түймэр, үерийн хамгаалалтын байгууламж, суваг шуудуу” хэмээх орон нутгийн чиг үүрэг нь үүнд хамаарч байна гэж ойлгож болно.

Тухайн чиг үүргийг аймаг, сум, нийслэл, дүүргийн Онцгой комисс; аймаг, нийслэл, дүүргийн Онцгой байдлын газар, хэлтэс хариуцна.

**“Орон нутгийн цэвэрлэх байгууламж”** чиг үүргийг цэвэр ус, бохирусны шугам болон хаягдал ус зайлуулах байгууламж, тэдгээрт хамааралтай барилга байгууламжийн арчлалтыг суманд; төлөвлөлт, ашиглалт, хяналт тавих чиг үүрэг нийслэлд хуваарилсан байхад харин аймагт “бохир усны шугам болон хаягдал ус зайлуулах байгууламж ... эдгээрт хамааралтай барилга байгууламжийн төлөвлөлт, ашиглалт, хяналт” гэж тодорхойлжээ. Цэвэрлэх байгууламжтай холбоотой асуудлыг “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль” (2011)-иар нарийвчлан зохицуулсан байдаг. Тус хуулиар аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон аймаг, сум, нийслэлийн Засаг даргад тодорхой эрх хэмжээг олгосон байдаг бөгөөд хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 11-д “цэвэрлэх байгууламж” гэж бохир ус татан зайлуулах шугамаас бохир усыг хүлээн авч цэвэрлэх цогц байгууламжийг хэлнэ гэснээс үзэхэд аймагт цэвэрлэх байгууламжтай холбоотой чиг үүрэг хуваарилсан гэж үзэхээр байна.

2022 онд тус хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөс үзэхэд “хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт”-ын талаарх аймаг, сум, нийслэлийн Засаг даргын бүрэн эрхэд хамаатай заалт оруулсан нь орон нутгийн чиг үүрэгт нийцүүлэх ажлыг хийсэн гэж үзэж болохоор байна.

Энэхүү чиг үүргийг нийслэлд Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтэс, Ус сувгийн удирдах газар; аймгийн төвийн сумдад Тохижилт үйлчилгээний газар ОНӨААТҮГ хариуцна.

**“Орон нутгийн зам, гүүр”** чиг үүрэг нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд зааснаар зөвхөн суманд хамаатай байх бөгөөд “орон нутгийн зам, гүүрийн тэмдэг, тэмдэглэгээ, арчлалт, хамгаалалт”-ын асуудлыг хариуцуулсан байна.

Харин Авто замын тухай хууль (2017)-д нийслэл, орон нутгийн чанартай

авто зам, түүний зурвас газрыг эзэмшигч нь аймаг, нийслэлийн Засаг дарга байхаар (17 дугаар зүйлийн 3 дахь хэсэг); авто замыг эзэмшигч нь “...өөрийн эзэмшлийн авто зам, замын байгууламжийн засвар, арчлалтыг хариуцна” гэж (мөн хуулийн 17 дугаар зүйлийн 5 дахь хэсэг) зохицуулж өгснөөс үзэхэд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд орон нутгийн чиг үүргийг аймаг, нийслэлд тухайлан хуваарилаагүй боловч нийслэл, орон нутгийн чанартай авто замыг эзэмшигчийн эрхээ хэрэгжүүлэх, шийдвэр гаргах зайлшгүй шаардлага байгаа юм.

Гэтэл Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 6-д “нийслэлийн авто замын арчлалт, засвар, төлөвлөлт, хяналт”-ыг Нийслэл хотын чиг үүрэг байхаар заасан. Эдгээр зохицуулалтаас харахад Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар зөвхөн суманд олгосон чиг үүрэгтэй зөрчилдөж байна.

Энэ чиг үүргийг аймаг, нийслэлд ЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс; аймагт Авто замын засвар арчлалтын АЗЗА ТӨХК; нийслэлд Нийслэлийн замын хөгжлийн газар хариуцан хэрэгжүүлнэ.

**“Суурин газрын гэрэлтүүлэг”** чиг үүрэг нь зөвхөн сум, дүүрэгт хамааралтай байхаар Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд тогтоожээ. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль (2021)-ийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 7-д зааснаар “гэрэлтүүлэг, түүний засвар, арчлалт, цэвэрлэгээ, үйлчилгээ, хамгаалалт” нь нийслэл хотын тусгай чиг үүрэгт хамаарч байгаа бөгөөд өөр хуульд суурин газрын гэрэлтүүлэгтэй холбоотой зохицуулалт байхгүй юм.

Уг чиг үүргийг нийслэлд Захирагчийн ажлын албаны Хотын инженерийн байгууламжийн хэлтэс; аймгийн төвийн сумдад Тохижилт үйлчилгээний газар ОНӨААТҮГ хариуцан хэрэгжүүлнэ.

**“Бэлчээрийн ашиглалт, хамгаалалт”** чиг үүргийг зөвхөн багт “бусдын эзэмшил, ашиглалтад олгоогүй хадлан, тариалан, бэлчээрийн хамгаалалт, ашиглалт, зохицуулалт” гэсэн томъёоллоор хариуцуулжээ. Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлд аймаг, сум, нийслэл, дүүргийн ИТХ нь нутаг дэвсгэртээ бэлчээрийн болон суурин мал маллагааны бүс нутгийг тогтоох, бэлчээр ашиглах ерөнхий хуваарь, бэлчээрийн хэмжээ, бэлчээр ашиглах журмыг тогтоох эрхтэй байна. Мөн сум, дүүргийн ИТХ нь бэлчээрийн хуваарийг газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж батлахаар; аймгийн ИТХ нь гамшиг, аюулт үзэгдэл тохиолдсон үед ашиглах сум дундын отрын нөөц нутаг, түүний заагийг тогтоохоор заажээ. Харин сум дүүргийн Засаг дарга нь бэлчээр ашиглуулах шийдвэр гаргах эрхтэйгээр тусгагджээ.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан төрийг төлөөлөн гүйцэтгэх чиг үүрэгт “бэлчээрийн менежмент” гэсэн ерөнхий утгаар орсон тул Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлд заасан ИТХ, Засаг даргын бүрэн эрх нь төлөөлөн гүйцэтгэх чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэгдэж байна.

Харин Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар багт олгосон чиг үүрэг нь “бусдын эзэмшил, ашиглалтад олгоогүй ... бэлчээрийн хамгаалалт, ашиглалт, зарцуулалт” гэж байгаа нь субсидиар зарчмыг баримтлаагүй гэдгийг харуулж байна. Гэхдээ Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар баг, хорооны Засаг дарга “бусдын эзэмшил, ашиглалтад олгоогүй хадлангийн болон тариалангийн талбай, бэлчээр, уст цэгийг хамгаалах, ашиглах хуваарь гаргаж зохицуулах” бүрэн эрхтэй байх зохицуулалттай уялдуулсан нь харагдаж байна.

Уг чиг үүргийн бэлчээр хуваарилах асуудлыг багийн иргэдийн Нийтийн Хурал, хэрэгжилтийг хангах ажлыг багийн Засаг дарга хариуцна.

#### ***Төлөөлөн гүйцэтгэх төрийн чиг үүрэг***

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт төрийн зарим чиг үүргийг нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагаар төлөөлөн гүйцэтгүүлэхээр шилжүүлж болохоор заасан.

Төрийн зарим чиг үүргийг төлөөлөн гүйцэтгүүлэхээр шилжүүлэхдээ нэгж тус бүрийн чиг үүрэг, онцлогийг харгалзан үзэж, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг хамтад нь шилжүүлэх бөгөөд чиг үүргийн хүрээ, хязгаарлалтыг нэгж тус бүрээр тодорхойлж, тайлагнах, хяналт тавих журмыг хууль, гэрээнд тодорхой зааж өгөхөөр хуульчилсан.

Төлөөлөн гүйцэтгүүлж болох төрийн 25 чиг үүргийг уг хуулийн 27 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт жагсаасан байна. Эдгээр нь энэхүү судалгааны үндсэн зорилгод шууд хамаарах асуудал биш учраас зөвхөн судалгааны мэдээллийг шалгах, баталгаажуулах үүднээс дор дурдсан 3 чиг үүргийг сонгон авч чиг үүргийн хууль, эрх зүйн зохицуулалт, хэрэгжүүлж буй ерөнхий зохион байгуулалт, санхүүжилтэд нь шинжилгээ хийлээ.

*Улсын бүртгэл* чиг үүргийг Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д “эрх, үүрэг үүсэх, өөрчлөгдөх, дуусгавар болохтой холбоотой хуульд заасан бүртгэлийн үйл ажиллагаа” гэж тодорхойлсон байна. Уг хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Улсын бүртгэлийн байгууллагын тогтолцоо нь улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага түүний орон нутаг дахь газар, хэлтэс, тасаг, улсын бүртгэлийн ажилтан, хилийн чанадад ажиллаж байгаа Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн газрын консулын ажилтнаас” бүрддэг, түүнчлэн

төв болон орон нутагт ажиллаж буй улсын бүртгэгчийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга томилж, чөлөөлдөг (хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг), нэгдмэл тогтолцоотой, төвлөрсөн удирдлагатай (хуулийн 15 дугаар зүйлийн 2 дахь хэсэг) байхаар хуульчилсан байна.

Үүний зэрэгцээ Статистикийн тухай хуулийн дагуу баг, хорооны Засаг дарга хүн ам, өрхийн болон иргэний түр оршин суух бүртгэлийг хөтөлж, Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн дагуу бүртгэлийн мэдээллийг улсын бүртгэлийн байгууллагатай харилцан солилцохоос өөрөөр орон нутаг нь улсын бүртгэлийн чиг үүргийг төлөөлөн гүйцэтгэхгүй байгаа нь илэрхий байна.

Монгол Улсын Засгийн газрын одоо хүчин төгөлдөр мөрдөж буй бүтэц, орон тооны хязгаарыг тогтоосон шийдвэр (Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 360, 377 дугаар тогтоолууд)-т улсын бүртгэлийн чиг үүргийг хэрэгжүүлж буй нэгж нь аймаг, нийслэлд Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг - Улсын бүртгэлийн газар, хэлтэс байхаар заасан.

Дээр дурдсанаас үзвэл Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн дагуу улсын бүртгэлийн үйл ажиллагаа, бүтэц нь төвлөрсөн удирдлагатай, нэгдмэл тогтолцоо учраас орон нутаг нь үнэн хэрэгтээ уг чиг үүргийг төлөөлөн гүйцэтгэхгүй байгаа нь харагдаж байна.

*Соёлын үйлчилгээ*-г Соёлын тухай хууль (3.1.5)-д зааснаар “арилжааны үнэ цэнээс үл хамааран, хүний соёлын хэрэгцээг хангах зорилгоор үзүүлж байгаа соёлын илэрхийллийг агуулсан үйлчилгээ” гэж тодорхойлсон бөгөөд үүнийг “соёлын байгууллага” (3.1.2) эрхлэн гүйцэтгэнэ.

Орон нутгийн соёлын байгууллагын удирдлагыг соёлын асуудал эрхэлсэн дээд шатны байгууллагатай зөвшилцөн тухайн нэгжийн Засаг дарга томилж чөлөөлөх бөгөөд, аймаг, нийслэлд мэргэжлийн урлагийн байгууллага (театр, чуулга); сум, дүүрэг, тосгонд соёлын ордон, соёлын төв; аймаг, нийслэлд музей; аймаг, сум, нийслэл, дүүрэгт номын сан байна. Түүнчлэн аймаг, нийслэлд ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс, Соёл, урлагийн газар; дүүрэгт ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн хэлтэс; суманд ЗДТГ-ын Нийгмийн бодлогын мэргэжилтэн соёлын талаарх төрийн захиргааны үүргийг гүйцэтгэнэ.

Соёлын тухай хууль (3.2)-д зааснаар “Соёлын үйл ажиллагааны төсөв нь улсын болон орон нутгийн төсөв, Засгийн газрын тусгай сан, дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллагын хандив, соёлын байгууллагын төлбөртэй үйлчилгээ, дотоод, гадаадад зохион байгуулсан соёл, урлагийн арга хэмжээнээс олсон орлого, өөрийн үйл ажиллагааны орлого, хуулиар хориглоогүй бусад эх үүсвэрээс бүрдэнэ” гэснээс үзэхэд зардлын тодорхой хэсгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлдэг байна.

Соёлын байгууллагын бүтэц, зохион байгуулалт, орон тоо, удирдах ажилтны томилгоо зэрэг нь орон нутгийн эрх мэдлийн хүрээний асуудал, түүнчлэн төсөвт зардлын тодорхой хэсгийг (зарим байгууллагын хувьд төсөв нь бүхэлдээ) орон нутгийн төсвөөс санхүүжүүлдэг, мэргэжил арга зүйн удирдлагаар хангахаас бусад чиг үүрэг нь орон нутгаас хэрэгжүүлж байгаа зэргээс үзэхэд “соёлын үйлчилгээ” чиг үүргийг төлөөлөн гүйцэтгэж байгаа гэхээс илүүтэйгээр орон нутгийн чиг үүрэг гэж хэлж болохоор байна.

*Нийтийн биеийн тамир* чиг үүрэгт хамаарах “биеийн тамир” гэх ойлголт нь Биеийн тамир, спортын тухай хууль (4.1.2)-д зааснаар “хүн амын идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх, эрүүл мэндийг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагаа” бөгөөд энэхүү үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулах, биеийн тамир спортын талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах төрийн захиргааны үүргийг орон нутагт аймаг, нийслэлд Биеийн тамир, спортын газар; дүүрэгт Биеийн тамир, спортын хороо; суманд Нийтийн биеийн тамирын арга зүйч (төсөв, зохион байгуулалтын асуудал нь хараахан шийдэгдээгүй тул орон тооны арга зүйчтэй сум ховорхон байна) гүйцэтгэж байна.

Санхүүжилтийн хувьд нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх чиглэлээрх хэд хэдэн чиг үүргийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр Биеийн тамир спортын тухай хууль (24.2)-д заасан байна. Тухайлбал, “аймаг, дүүргийн өсвөр үеийн шигшээ багт орон нутгийн төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх” (18.5); “биеийн тамир, спортыг хөгжүүлэх, дэмжих чиглэлээр идэвх, санаачилгатай ажиллаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах, дэмжлэг үзүүлэх” (8.1.3); суманд орон тооны биеийн тамирын арга зүйч ажиллуулах (8.1.4); спортын барилга байгууламж, спортын зааланд иргэнийг идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллүүлэх дэмжлэг үзүүлэх (26.6). Судалгаанд хамрагдсан аймаг, нийслэлийн төсвөөс харахад Биеийн тамир, спортын газрын байр ашиглалтын тогтмол зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж байгаа бөгөөд үүнээс гадна дээр дурдсан зардлын санхүүжилтийг төсөвт тусгасан нь харагдлаа.

Аймаг, нийслэлийн биеийн тамир, спортын газрын даргыг биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн аймаг, нийслэлийн Засаг дарга томилж, чөлөөлөх бөгөөд тус газрын бүтэц, зохион байгуулалт, орон тооны хязгаарыг батална.

Биеийн тамир, спортын байгууллагын бүтэц, зохион байгуулалт, орон тоо, удирдах ажилтны томилгоо зэрэг нь орон нутгийн эрх мэдлийн хүрээний асуудал, түүнчлэн төсөвт зардлын тодорхой хэсгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлдэг боловч нийтийн биеийн тамирын зарим үүргийг (тухайлбал, Биеийн тамир спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9-д заасан “хүн амд эрүүл аж төрөх зан үйлийг хэвшүүлэх, иргэнийг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх



ажлыг зохион байгуулах” бүрэн эрх) Биеийн тамир, спортын улсын хороо хариуцан зохион байгуулж байгаа зэргээс харахад “нийтийн биеийн тамир” чиг үүргийг бүхэлд нь орон нутагт төлөөлөн гүйцэтгүүлэхээр шилжүүлсэн гэж үзэх үндэслэлгүй байна. Сонгож авсан дээрх гурван чиг үүрэгт шинжилгээ хийснээр төлөөлөн гүйцэтгэх төрийн чиг үүргийн хэрэгжилтийг тусгайлан судлах хэрэгцээ байгаа гэж үзэв.

Хуулиудад хийсэн шинжилгээнээс дүгнэн үзэхэд хуульд заасан орон нутгийн чиг үүрэгтэй холбогдох салбарын хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах ажил хараахан гүйцээгүй, системтэй ажил болж хэрэгжээгүй нь харагдаж байгаа бөгөөд үүнээс хамаараад Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан орон нутгийн чиг үүргийн хэрэгжилт ч үүнтэй холбогдоод хүлээсэн үр дүнд хүрээгүй байна.

Орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлт, орон нутгийн төсөв, өмч, хөрөнгө оруулалт, татварын тогтолцоо нь хэдийгээр бүгд “орон нутгийн” гэх тодотголтой боловч нэгдмэл, төвлөрсөн тогтолцооны нэг хэсэг учраас орон нутгийн чиг үүрэг болж бүрэн хэмжээнд төлөвшөөгүй байна.

Орон нутгийн чиг үүргээс зөвхөн 4 чиг үүрэг (орон нутгийн сан; орон нутгийн хүний нөөцийн бодлогын төлөвлөлт, хөтөлбөр; оршуулгын газрын зохицуулалт; суурин газрын гэрэлтүүлэг)-т нь шууд хамаарах хууль байхгүй, аймаг, нийслэлийн түвшинд хуулийн хүрээнд бие даан шийдвэрлэх боломжтой гэж үзэж болохоор байна.

Орон нутгийн 3 чиг үүрэг (орон сууц, нийтийн аж ахуй; нийтийн эзэмшлийн зам, талбай, олон нийтийн соёл амралтын хүрээлэн, ногоон байгууламж; бэлчээрийн ашиглалт, хамгаалалт)-т шууд хамаарах салбарын хууль, тогтоомж байхгүй, Хот байгуулалтын тухай, Орон сууцны тухай, Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай, Газрын тухай хуулиар дам зохицуулдаг боловч харьцангуй төвлөрсөн шинжтэй зохицуулалттай, тухайн чиг үүрэгт хамаарах зүйл, заалтад ойрын хугацаанд нэмэлт өөрчлөлт оруулаагүй байна.

Мөн 4 чиг үүрэг (хүн амын ундны болон ахуйн хэрэгцээний усан хангамж; орон нутаг дахь нийтийн тээвэр; гудамж, талбайн нэр, хаягжуулалт; хог хаягдлын менежмент)-ийн хувьд шууд холбогдох хуультай боловч орон нутагт шийдвэрлэж байгаа байдал, гүйцэтгэж буй ажил үүргийн хэмжээ зэргээс үзэхэд төвлөрсөн зохицуулалтын хүрээ бага, орон нутагт тухайн чиг үүргийг бүрэн шилжүүлэхэд хялбар гэж үзэхээр байна.

Үүнээс гадна 4 чиг үүрэг (орон нутгийн үйлдвэрлэл, хүнс, хөдөө аж ахуй; хөшөө дурсгалын зохицуулалт; гал түймэр, үерийн хамгаалалтын байгууламж, суваг шуудуу; бэлчээрийн ашиглалт, хамгаалалт)-т хамаарах



асуудал нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан төрийн чиг үүргийг төлөөлөн гүйцэтгэх чиг үүрэгт шууд хамааралтай байгаа нь эдгээр чиг үүргийг орон нутгийн чиг үүрэг гэж үзэх үндэслэл бага байна.

Орон нутгийн сан нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “төсвийн тухай хуульд зааснаас өөр, төсвийн бус хөрөнгийн эх үүсвэртэй” байхаар заасан боловч холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудын зүгээс хуулийн дээр дурдсан заалтын агуулгыг ойлгохгүй, үл тоомсорлож аймаг, сум, нийслэл, дүүргийн Хурлаас гарсан шийдвэрийг бүртгэж баталгаажуулахгүй байна.

Баг, хороонд тусгайлан хуваарилсан чиг үүргүүд нь хэт ерөнхий, ажил, арга хэмжээ хэлбэртэй томъёологдсон, голчлон хуваарилаагүй үлдсэн чиг үүрэг учраас уг асуудлыг бие даан шийдвэрлэх, хэрэгжүүлэх бараг боломжгүйд хүрч баг, хорооны түвшинд холбогдох чиг үүргээр гарсан шийдвэр тун цөөхөн болжээ.

#### **4.2. Орон нутгийн шийдвэрт хийсэн шинжилгээ**

Орон нутгийн чиг үүргийн хэрэгжилтийг судлахдаа аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргаас орон нутгийн тодорхой чиг үүрэгт хамаарах асуудлаар гаргасан шийдвэрийг авч үзэж,

- Уг шийдвэрийн агуулга нь тухайн нэгжид хуваарилсан чиг үүрэгт хамаарч байгаа эсэх;
- Уг шийдвэрт эрх зүйн үндэслэл болгон авсан хууль тогтоомжийн зүйл заалт нь шийдвэрийн агуулгад нийцэж байгаа эсэх;
- Уг шийдвэрт холбогдох чиг үүргийг үндэслэл болгон авсан эсэх;
- Уг шийдвэр нь тухайн шийдвэр гаргагч этгээдийн бүрэн эрхэд хамаарч байгаа эсэх;
- Уг шийдвэрт шийдвэр гаргагчийн бүрэн эрхийг үндэслэл болгон авсан эсэхийг

шалган үзэж, хуулиар тодорхойлсон орон нутгийн чиг үүрэгт салбарын эрх зүйн зохицуулалт нь уялдаж байгааг болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүдэд хуваарилсан чиг үүрэг нь нийцэн хэрэгжиж байгаа эсэхийг тодорхойлов.

Судалгааны ажлын хүрээнд 4 аймаг, 13 сум, нийслэл, 2 дүүргийн 2021-2023 онд гаргасан ИТХ-ын 1305 тогтоол, Засаг даргын 13660 захирамж нийт 14965 шийдвэртэй танилцаад:

- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан орон нутгийн чиг үүрэгт агуулгаараа хамаарч буй байдал
- мөн хуульд заасан орон нутгийн чиг үүргийг үндэслэл болгон авсан байдал

гэсэн хоёр шалгуурт үндэслэн ИТХ-ын 256 тогтоол, Засаг даргын 1037 захирамж, нийт 1293 шийдвэрийг түүвэрлэн авч агуулгын шинжилгээ хийв (Хүснэгт 4). Эдгээр шийдвэрийн 359 (43 нь ИТХ-ын тогтоол; 316 нь Засаг даргын захирамж) аймгийн, 653 сумын (163; 490), 153 нийслэлийн (27; 126), 128 дүүргийн (23; 105) түвшний ИТХ, Засаг даргын шийдвэр байлаа. Ийнхүү судлахдаа тухайн нэгжид хамаарах чиг үүргийг шийдвэрт үндэслэл болгон аваад уг чиг үүргийг хэрэгжүүлэхэд хамаарах шийдвэр гаргагч этгээдийн бүрэн эрхийг мөн үндэслэх нь шийдвэрийг бүрэн гүйцэд, хэрэгжих эрх зүйн чадамжтай болгож байна гэж үзэж, үндсэн шалгуур болгон ашиглалаа. Үүний зэрэгцээ хуульд заасан чиг үүрэг, бүрэн эрхийг үндэслэж байгаагаас гадна салбарын хууль тогтоомжийг үндэслэл болгож байгаа эсэхийг авч үзсэн нь уг чиг үүргийг “эрх мэдлийг бүрэн шилжүүлэх” (devolution) хэлбэрээр хуваарилсан эсэхийг шалгах үзүүлэлт гэж үзэв.

**Хүснэгт 4. Агуулгын шинжилгээ хийсэн шийдвэрийн тоо (Аймаг, сум, нийслэл, дүүргийн ИТХ, Засаг даргын шийдвэр, түүвэрлэн авснаар, оноор)**

Засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгж	ИТХ-ын тогтоол			Засаг даргын захирамж			Нийт
	2021	2022	2023	2021	2022	2023	
Аймаг	18	22	3	71	152	93	359
Сум	58	92	13	172	213	105	
Нийслэл	5	10	12	25	21	80	
Дүүрэг	7	11	5	33	44	28	128
Нийт	256			1037			1293

*Эх сурвалж: Судалгааны өгөгдөл*

**Орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлт** чиг үүргийн хүрээнд ИТХ нь аймаг, нийслэлийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, хөгжлийн жилийн төлөвлөгөө, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тус тус баталдаг.

Орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн чиглэлээр ИТХ-аас гаргасан шийдвэрүүдийг түүвэрлэж үзэхэд орон нутгийн чиг үүргийн тухайн нэгжид хамаарах хуулийн заалтыг голчлон зөв үндэслэсэн байх боловч зарим газарт зөвхөн тухайн асуудлаарх ИТХ-ын бүрэн эрхийг

(тухайлбал, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35.1.5, 35.1.8); тухайн асуудалд хамааралгүй заалтыг (тухайлбал, хуулийн 77.1); тухайн нэгжид хамаарахгүй буюу ерөнхий заалтыг (тухайлбал, хуулийн 20.1.1) үндэслэл болгосон нь хуулийг зөв хэрэглэх дадал төлөвшөөгүй байгаа нь харагдаж байна. Уг асуудалд шууд хамааралтай салбарын хууль болох Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн холбогдох заалтууд (тухайлбал, хуулийн 4.1.14; 9.11.1; 18.6; 19.1.2)-ыг аймаг, нийслэлийн ИТХ-уудад ихэвчлэн зөв хэрэглэсэн байна. Мөн зарим газарт тухайн асуудалд холбогдох бусад байгууллагын шийдвэр (тухайлбал, УИХ, Засгийн газрын тогтоол, журам г.м.)-ийг нэмэлт үндэслэл болгожээ.

Харин сум, дүүрэгт хамаарах ямар нэгэн төлөвлөлтийн баримт бичиг байх эсэхийг хуульд заагаагүйн улмаас тухайн асуудлаар шийдвэр гаргахдаа Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийг үндэслэл болгож авахгүй байна.

Орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлт чиг үүргийн хүрээнд Засаг дарга нь стратегийн болон үйл ажиллагааны төлөвлөгөө батлах, хэрэгжилтэд хяналт - шинжилгээ хийх, үнэлэлт, дүгнэлт өгөх, мөн хууль, бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлыг харьяа нутаг дэвсгэртээ зохион байгуулах шийдвэрийг гаргадаг. Энэ хүрээнд 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс хойш аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын гаргасан шийдвэрүүдэд шинжилгээ хийж үзэхэд уг чиг үүрэгт хамаарах зүйл заалтыг зөв хэрэглэсэн (тухайлбал, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21.1.1; 22.1.1; 24.1.1; 25.1.1; 60.1.1; 60.1.2), зарим тохиолдолд үндэслэл болгохдоо тухайн асуудалд шууд хамааралгүй заалтуудыг хэрэглэсэн (тухайлбал, мөн хуулийн 15.1.1; 15.3), тухайн нэгжид хамаарахгүй буюу ерөнхий заалтыг (тухайлбал, хуулийн 20.1.1) үндэслэл болгосон нь мөн л хуулийг зөв хэрэглэх дадал төлөвшөөгүй байгаа нь харагдаж байна.

2022 оны 4 дүгээр сард гарсан Засаг даргын нэг захирамжид 2022 оны 1 дүгээр сарын 1-нээр хүчингүй болгосон Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн зүйл, заалтыг үндэслэл болгосон тохиолдол гарав. Энэ нь тухайн шийдвэрийн төслийг боловсруулсан, мөн санал өгсөн нэгж, албан тушаалтны хариуцлагын асуудал гэж үзэж болох юм.

**“Орон нутгийн өмчийн удирдлага”** чиг үүргийн хүрээнд ИТХ нь орон нутгийн өмчийн үйлдвэрийг байгуулах, өөрчлөх, татан буулгах, өмчийн тооллого хийх, өмчид хөрөнгө бүртгэн авах, шилжүүлэх, худалдах, хувьчлах, хасах шийдвэрүүдийг гаргана. Энэхүү чиг үүргээ хэрэгжүүлэхдээ ИТХ нь тухайн нэгжид шууд хамаарах зүйл заалтуудыг (тухайлбал, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21.1.2,

22.1.2, 24.1.2, 25.1.2) өөрийн бүрэн эрхийн хамт үндэслэл болгон шийдвэр гаргаж байна. ИТХ нь орон нутгийн өмчийн өмчлөгч нь болохын хувьд төрийн болон орон нутгийн өмчийн холбогдох зүйл, заалтыг (тухайлбал, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйл; 77.1; 77.3) үндэслэл болгон авч байна.

ИТХ-ын түүвэрлэсэн тогтоолуудаас үзэхэд ерөнхийдөө холбогдох зүйл заалтуудыг зөв хэрэглэж байгаа боловч зарим тохиолдолд аль нэгийг нь (тухайн нэгжийн чиг үүрэг, эсвэл ИТХ-ын бүрэн эрх) орхигдуулах (тэр бүү хэл нэг өдөр гарсан, ижил төстэй агуулгатай, дараалсан хоёр тогтоолд үндэслэлийг ялгаатай тогтоосон байв), тухайн шийдвэрийн үндэслэлд шууд хамааралгүй зүйл заалтыг (тухайлбал, уг хуулийн 15.1.1; 15.1.4) хэрэглэх тохиолдол ажиглагдлаа.

Засаг дарга “Орон нутгийн өмчийн удирдлага” чиг үүргийг хэрэгжүүлэхдээ Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд зааснаар орон нутгийн өмчийн эзэмшил, ашиглалтыг зохион байгуулж, орон нутгийн өмчийг бусдад эзэмшүүлэх, түрээслэх, худалдах, хувьчлах зэргээр захиран зарцуулах санал боловсруулан ИТХ-д оруулж шийдвэрлүүлэх (хуулийн 59.1.6, 60.1.6, 62.1.6, 63.1.6) бүрэн эрхтэй.

Түүвэрлэж авсан Засаг даргын захирамжуудадагуулгын шинжилгээхийж үзэхэд тухайн асуудлаар Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (тухайлбал, 21.1.2, 22.1.2, 24.1.2, 25.1.2), мөн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн (тухайлбал, 78 дугаар зүйл) холбогдох зүйл заалтуудыг авч хэрэглэсэн нь шийдвэрийн эрх зүйн үндэслэл зөв байгааг харууллаа. Харин зарим Засаг даргын хувьд дээрх хуулиудаар олгосон бүрэн эрхэд хамаарахгүй асуудлаар захирамж гаргажээ. Тухайлбал, Засаг дарга захирамж гаргахдаа тухайн шатны ИТХ-аас эрх хэмжээг шилжүүлсэн үндэслэлийг дурдалгүй шийдвэр гаргасан байна.

**“Орон нутгийн төсөв, албан татвар, төлбөр, хураамж”** чиг үүргийн хүрээнд ИТХ нь тухайн шатны Засаг даргын өргөн мэдүүлсэн аймаг, сум, нийслэл, дүүргийн төсвийг хэлэлцэж батлах, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах, гүйцэтгэлийг батлах, хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд албан татвар, төлбөр, хураамжийн хувь хэмжээг тогтоох бүрэн эрхтэй.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 2020 оны шинэчилсэн найруулгыг хүчин төгөлдөр мөрдөж эхэлснээс хойш ИТХ-аас орон нутгийн төсөв, гүйцэтгэл батлах, нэмэлт өөрчлөлт оруулах, татвар, төлбөр, хураамжийн хувь хэмжээ тогтоохдоо аймаг, сум, нийслэл, дүүрэгт нийтлэг байдлаар Хурлын холбогдох бүрэн эрх (35.1.9; 35.1.10), Төсвийн тухай хууль дахь ИТХ-ын бүрэн эрх (64.1.2; 64.1.3)-ийг үндэслэл болгосон нь төсөвт хамаарах ИТХ-ын бүрэн эрх шинээр

мөрдөгдөж байгаа хуулиудад агуулгын хувьд хэвээр үлдсэн, эдгээрийг шийдвэрт үндэслэл болгон хэрэглэж хэвшсэн байгааг харуулж байна.

Харин орон нутгийн төсөв баталсан, нэмэлт өөрчлөлт оруулсан, гүйцэтгэл баталсан, татвар, төлбөр, хураамжийн хувь хэмжээ тогтоосон Хурлын шийдвэрүүдэд орон нутгийн чиг үүргийн холбогдох зүйл, заалт (21.1.3; 21.1.4; 22.1.3; 22.1.4; 24.13; 24.1.4; 25.1.3; 25.1.4)-ыг хэрэглэсэн тохиолдол үндсэндээ гарсангүй. ИТХ-аас төсөв баталсан шийдвэрт Хурлын бүрэн эрх (22.1.3)-ийг үндэслэл болгон авсан тохиолдол судалгаанд хамрагдсан ганцхан суманд гарлаа.

Энэхүү чиг үүргийн хүрээнд Засаг дарга нь төсвийн ерөнхийлөгч захирагч болохын хувьд шийдвэр гаргахдаа төсвийн төсөл боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах, төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулах, Хуралд тайлагнах, татварын орлогыг төвлөрүүлэх, шилжүүлэх бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

Төсвийн талаарх орон нутгийн чиг үүргийг Засаг дарга шийдвэртээ үндэслэл болгосон тохиолдол зөвхөн төсвийн хуваарь баталсан нийслэл, дүүргийн шийдвэрт гарлаа. Аймаг, сумдад Төсвийн тухай хуулийн холбогдох заалт (14.2.2; 14.2.3; 14.2.4; 65.1.7)-ыг дурдахаас биш орон нутгийн чиг үүргийг үндэслэл болгохгүй байна. Төсвийг захиран зарцуулах, хөрөнгө гаргах, санхүүжилт зөвшөөрөх шийдвэрүүддээ Засаг дарга Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан бүрэн эрх (59.1.5; 60.1.5; 62.1.5; 63.1.5)-ээ бус, Төсвийн тухай хуульд заасан төсвийн ерөнхийлөн захирагчийн бүрэн эрх (14.2)-ийг үндэслэл болгох нь түгээмэл байна. Үүнээс гадна Сангийн сайдаас баталсан журам, бусад шийдвэрийг мөн үндэслэл болгох нь нийтлэг тохиолдож байна.

Засаг дарга татварын орлого бүрдүүлэх, шилжүүлэхтэй холбоотой шийдвэр гаргахдаа Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан бүрэн эрх (59.1.19; 60.1.10; 62.1.10; 63.1.10)-ээ үндэслэл болгож авахгүй байгаа бөгөөд Төсвийн болон Татварын хуулиудын холбогдох заалтыг үндэслэдэг нь анзаарагдлаа.

**“Орон нутгийн сан”**-тай холбоотой чиг үүргийн тухайд ИТХ нь орон нутгийн чиг үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зориулалтаар орон нутгийн санг байгуулах, бүрдүүлэх, захиран зарцуулах, хяналт тавих журмыг батлах, журмын хэрэгжилтэд хяналт тавих эрх зүйн зохицуулалт бий. Зарим аймаг, сумдын Хурал орон нутгийн санг хуульд заасны дагуу шинээр байгуулах шийдвэр гаргасан байна. Шийдвэртээ уг санг байгуулж ажиллуулахтай холбоотой хуулийн заалт (17.1; 17.2; 17.3) болон Хурлын бүрэн эрх (35.1.13; 35.1.14)-ийг үндэслэл болгож авсан байна.

Судалгаанд хамрагдсан нэг л сумын Хурал санг байгуулж, үйл ажиллагааны журмыг нь баталсан шийдвэртээ орон нутгийн холбогдох чиг үүрэг (22.1.5)-ийг үндэслэл болгон авчээ. Энэ сангийн талаар аймаг, сумдын ИТХ-аас баталсан журмуудыг ХЗДХЯ одоог хүртэл бүртгээгүй тухай энэхүү тайланд өмнө нь дурдсан билээ.

Үүнээс гадна энэ чиг үүргийн хүрээнд Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, хуваарилалттай холбоотой чиг үүргийг нэгжүүдэд тусгайлан нэмж хуваарилсан бөгөөд судалж үзэхэд Хурал нь Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний жагсаалтыг тухайн нэгжийн төсөвтэй хамт (ихэвчлэн нэг тогтоолоор) баталдаг тул орон нутгийн төсөвт хамаарах чиг үүргийг үндэслэхээс биш, орон нутгийн санд хамаарах чиг үүргийг үндэслээгүй байна. Үүнээс шалтгаалан орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, зарцуулалт, түүний хэрэгжилттэй холбоотой үүргээ хэрэгжүүлэхдээ Хурал нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан орон нутгийн чиг үүрэгтэй холбогдох заалтыг үндэслэхгүй байна.

Сум, дүүргийн Засаг дарга нь Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөх, жагсаалтын дагуу бараа ажил үйлчилгээг худалдан авах гэрээ байгуулах, худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих үүргийг хэрэгжүүлнэ. Үүнтэй холбогдуулан гаргасан шийдвэрүүдийг судлан үзэхэд Төсвийн тухай хууль (14.2.3), Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (46.1.3; 46.1.4)-ийн холбогдох зүйл, заалтыг үндэслэхээс биш, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан орон нутгийн чиг үүрэг (тэр байтугай төсөвтэй холбоотой Засаг даргын бүрэн эрх (59.1.4; 59.1.5; 62.1.4; 62.1.5)-ийг хүртэл)-ийг дурдахгүй байгаа нь анхаарал татаж байна.

**“Худалдаа үйлчилгээний зохицуулалт”** чиг үүргийн хүрээнд Хурал нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд зааснаар “худалдаа, үйлчилгээний төрөл, ангилал, худалдаа үйлчилгээ эрхлэхэд тавих шаардлага, бүрдүүлэх баримт бичиг, худалдаа, үйлчилгээ эрхлэгчийн эрх, үүргийг тодорхойлсон нийтлэг журам батлах” (35.1.16) бүрэн эрхтэй. Харин Засаг даргад энэ хуулиар тухайлан бүрэн эрх олгоогүй бөгөөд “хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг хангах...” (60.1.1) бүрэн эрхийн хүрээнд салбарын хууль тогтоомжид заасан бүрэн эрхийн дагуу шийдвэр гаргах ба “Хурлаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах” (60.1.2) нийтлэг бүрэн эрхийг мөн адил хэрэгжүүлнэ. Энэ чиг үүргийн хүрээнд салбарын хууль тогтоомжоор зөвшөөрөл олгох, цуцлах, зохицуулалт хийх, хяналт тавих, албадан сахиулах төрлийн шийдвэрийг гаргаж байна.

Судалгаанд хамрагдсан Хурлуудын шийдвэрийг шинжилж үзэхэд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хүчин төгөлдөр мөрдөж эхэлснээс хойш нэг л Хурлаас “худалдаа, үйлчилгээ эрхлэх нийтлэг журам” батлан гаргасан байх бөгөөд уг журмыг баталсан тогтоолд орон нутгийн холбогдох чиг үүргийг үндэслэл болгож авалгүй, зөвхөн Хурлын холбогдох бүрэн эрх (35.1.14; 35.1.16)-ийг хэрэглэсэн байна.

Засаг даргын шийдвэрүүдээс харахад уг чиг үүрэгт хамаарах бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ зарим тохиолдолд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн холбогдох зүйл заалт (21.1.9; 22.1.9; 24.1.9; 25.1.6)-ыг, зарим тохиолдолд салбарын хууль тогтоомжийн холбогдох зүйл заалт (Зөвшөөрлийн тухай хууль, Тамхины хяналтын тухай хууль, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль г.м)-ын аль нэгийг нь үндэслэж шийдвэрээ гаргасан байна. Үүнээс үзэхэд орон нутгийн энэ чиг үүргийг Засаг даргын бүрэн эрхтэй холбон хэрэглэх практик хэвшээгүй байгааг харуулж байна.

Өмнө авч үзсэн орон нутгийн таван чиг үүрэг (Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20.1.1; 20.1.2; 20.1.3; 20.1.4; 20.1.8) тус бүрээр ИТХ-д тусгайлан бүрэн эрх олгогдсон бөгөөд бусад арван найман чиг үүрэг (20.1.5; 20.1.6; 20.1.7; 20.1.9; 20.1.10; 20.1.11; 20.1.12; 20.1.13; 20.1.14; 20.1.15; 20.1.16; 20.1.17; 20.1.18; 20.1.19; 20.1.20; 20.1.21; 20.1.22; 20.1.23)-ээр ИТХ-д тусгайлан бүрэн эрх олгоогүй мэт боловч уг хуулийн 35 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 13-т зааснаар “энэ хуулиар тогтоосон тухайн нэгжийн чиг үүрэгт хамаарах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх, холбогдох журам батлах” гэсэн Хурлын бүрэн эрхийн дагуу чиг үүргээ хэрэгжүүлэх боломжийг олгосон гэж үзнэ.

Засаг даргад орон нутгийн хөгжлийн бодлогын төлөвлөлт, төсөв, өмчийн асуудлаар л энэ хуулиар тусгайлан бүрэн эрх олгосон бөгөөд бусад чиг үүргийг нийтлэг байдлаар нэг талаас Хурлаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах (59.1.8; 60.1.8; 62.1.8; 63.1.8), нөгөө талаас хууль тогтоомж, Засгийн газар болон харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийг хэрэгжүүлэх (59.1.1; 60.1.1; 62.1.1; 63.1.1) бүрэн эрхийн хүрээнд шийдвэр гаргаж байна.

Эдгээр арван найман чиг үүргийн хүрээнд судалгаанд хамрагдсан аймаг, сум, нийслэл, дүүргийн ИТХ, Засаг даргын шийдвэрүүдэд шинжилгээ хийж үзлээ.

**“Орон нутгийн хүний нөөцийн бодлогын төлөвлөлт, хөтөлбөр”** чиг үүргийн хүрээнд орон нутгийн хүний нөөцийн төлөвлөлт, хөтөлбөрийг аймгийн түвшинд хариуцаж буй тул аймгийн ИТХ-аас бодлогын баримт бичиг батлан гаргах, Засаг даргаас бодлогын хэрэгжилтийг хангах чиглэлээр



шийдвэр гаргана. Судалгаанд хамрагдсан аймгуудын Хурлаас төрийн албан хаагчдын хөгжил, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангахад чиглэсэн хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийг баталсан тогтоолд энэхүү чиг үүргийг үндэслэсэн тохиолдол байсангүй. Харин Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан Хурлын бүрэн эрхтэй шууд холбогдолгүй заалт (35.1.8) болон Төрийн албаны тухай хуулийн холбогдох заалт (55.3)-ыг л авч үзжээ.

Судалгаанд хамрагдаагүй хэд хэдэн аймгийн ИТХ-ын шийдвэрүүдийг шүүж үзэхэд энэ чиглэлээр шинээр баталсан болон нэмэлт өөрчлөлт оруулсан хөтөлбөрүүдэд орон нутгийн чиг үүрэг (21.1.6)-ийг үндэслэл болгосон хэдий ч Хурлын холбогдох бүрэн эрх (35.1.13)-ийг орхигдуулсан нь харагдлаа.

Засаг дарга аймгийн хүний нөөцийн хөгжлийн бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах асуудлаар шийдвэр гаргах учиртай. Гэтэл судалгаанд хамрагдсан аймгууд нийтлэг байдлаар бодлогыг боловсруулж батлах шатандаа байгаа тул Засаг дарга нь голчлон баримт бичгийг боловсруулах үүрэгтэй ажлын хэсэг байгуулсан шийдвэрүүд гаргасан байна. Уг шийдвэрүүдэд хууль зүйн үндэслэлийг авч үзэхдээ Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуульд заасан орон нутгийн чиг үүрэг (22.1.6; 23.1.6)-ийг үндэслэл болгон авч үзсэн тохиолдол үндсэндээ байхгүй, ихэвчлэн Засаг даргын бүрэн эрхэд шууд холбогдолгүй зүйл, заалт (59.1.2; 59.1.3; г.м)-ыг үндэслэл болгожээ.

Судалгаанд хамрагдсан аймгийн Засаг даргын нэг л шийдвэрт үндэслэвэл зохих холбогдох хуулийн зүйл, заалт бүрийг авсан нь анхаарал татлаа. Уг чиг үүрэгтэй холбогдон гарч байгаа Засаг даргын шийдвэр нь төрийн албан хаагчийн сургалт, хөгжил, нийгмийн баталгаанд хамаарах асуудлаар гарч байгаа тул ихэнхдээ Төрийн албаны тухай хуулийн холбогдох заалт (55.3; 61.1)-ыг авч хэрэглэж байна.

**“Орон нутгийн үйлдвэрлэл, хүнс, хөдөө аж ахуй”** чиг үүргийг хэрэгжүүлэх бүрэн эрх нь ИТХ болон Засаг даргад тухайлан олгогдоогүй. Гэхдээ тухайн чиг үүргийг хэрэгжүүлэхдээ Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн дагуу Хурал нь 35.1.13-д зааснаар шийдвэрлэх ба Засаг дарга нь 59.1.2; 59.1.7; 60.1.2; 60.1.8-д заасны дагуу уг шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

Аймаг, сумдын Хурал, Засаг даргын шийдвэрийг шинжилж үзэхэд холбогдох орон нутгийн чиг үүрэг болон үүнд хамаарах Хурлын бүрэн эрхийг үндэслэл болгосон нь тус тус ганцхан удаа байлаа. Орон нутгийн чиг үүргийг үндэслэхдээ тухайн нэгжид хамааралтай зүйл заалт (21.1.7; 21.1.8; 22.1.7; 25.1.7)-ыг бус, холбогдох ерөнхий зүйл, заалт (20.1.6)-ыг хэрэглэх нь түгээмэл байна.



Мөн түүнчлэн шууд хамааралтай бус заалт (20.1.1, 21.1.1, 35.1.8, 35.1.17) хэрэглэх, харин зарим тохиолдолд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийг үндэслэл болгож авалгүй зарим нэг салбарын хуулийн зүйл, заалт (тухайлбал, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль)-ыг үндэслэсэн нь харагдаж байна.

**“Хүн амын ундны болон ахуйн хэрэгцээний усан хангамж”** чиг үүрэгт хамаарах асуудлаар судалгаанд хамрагдсан нэг л Хурал шийдвэр гаргажээ. Энэ нь “уст цэгийг эзэмших, ашиглах журам батлах” тогтоол байсан бөгөөд уг тогтоолын үндэслэлд холбогдох чиг үүрэг, Хурлын бүрэн эрхийг бүрэн тусгасан, ямар нэгэн алдаагүй байлаа.

Сумын түвшинд Засаг даргын захирамж нь энэ чиг үүргийн хүрээнд ус ашиглах зөвшөөрөл олгох, худаг гаргах, усны сан бүхий газарт хамгаалалтын бүс тогтоох чиглэлээр гарч байна. Аймаг, нийслэлийн түвшинд энэ чиг үүргийн хүрээгээр бус цэвэр бохир усны шугам, хаягдал ус зайлуулах байгууламжийн төлөвлөлт, ашиглалт, хяналт чиг үүрэг (21.1.15; 24.1.14)-ийн хүрээнд хүн амын ундны усны хангамжийн асуудлаар шийдвэр гаргаж байна. Дүүрэгт төвлөрсөн бус усан хангамжтай холбоотой чиг үүрэг байгаа хэдий ч судалгаанд хамрагдсан дүүргүүдийн хувьд ийм шийдвэр гараагүй байна.

Судалгаанд хамрагдсан сум, нийслэлийн ИТХ, Засаг даргаас “Орон сууц, нийтийн аж ахуй” чиг үүрэгт хамаарах асуудлаар Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг мөрдөж эхэлснээс хойших хугацаанд шийдвэр гараагүй байна.

**“Орон нутаг дахь нийтийн тээвэр”**-ийн зохицуулалт хийхдээ аймаг, нийслэлийн Хурал бүрэн эрхийнхээ хүрээнд шийдвэр гаргаснаас үзэхэд зарим шийдвэрт холбогдох чиг үүргийг үндэслэл болгосон хэдий ч “... чиг үүрэгт хамаарах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх, холбогдох журам батлах” (35.1.13) бүрэн эрхийг үндэслэл болгоогүй, эсвэл бүрэн эрхийг үндэслэл болгосон атлаа хамаарах чиг үүргийг үндэслэл болгоогүй орхигдуулсан байна. Энэ нь холбогдох нэгж, албан тушаалтны хууль тогтоомж хэрэглэх үр чадвараас хамаарч байна гэж үзэж болох юм.

Судалгаанд хамрагдсан аймаг, нийслэлийн Засаг даргаас гаргаж буй шийдвэрт шинжилгээ хийх явцад орон нутгийн чиг үүргийг огт үндэслэл болгоогүй буюу холбогдох зүйл, заалтыг хэрэглээгүй, гэхдээ салбарын хуулийн зохицуулалтыг нарийвчлан авч үзэж байгаа нь харагдлаа. Мөн Хурлын тодорхой шийдвэрийг үндэслэл болгож гаргасан захирамжид уг шийдвэрийг “... хэрэгжүүлэх үйл ажиллагааг хариуцан зохион байгуулж, үр дүнг хариуцах” Засаг даргын бүрэн эрх (60.1.2; 63.1.2)-ийг үндэслэл болгохгүй орхигдуулсан тохиолдол гарлаа.

**“Суурин газрын замын хөдөлгөөн, авто зогсоол”** чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд Хурал, Засаг даргаас гаргасан шийдвэрийг судалж үзэхэд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуульд заасан орон нутгийн чиг үүрэг [22.1.11; 24.1.12; 25.1.9]-ийг ердөө нэг сумын Засаг даргын хоёр захирамжид тусгасан байв.

Мөн нэг сум, нэг дүүргийн Засаг даргын захирамжийн агуулгаас үзэхэд холбогдох чиг үүрэгт бүрэн дүүрэн хамаарах асуудал (авто зогсоолын зохицуулалт, арчилгаа)-ыг шийдвэрлэсэн атлаа Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуульд заасан чиг үүрэг, бүрэн эрх [22.1.11; 25.1.9; 35.1.13]-ийг огт үндэслэл болгож авалгүй, зөвхөн салбарын хуулийн холбогдох заалтыг оруулсан байлаа.

**“Гудамж, талбайн нэр, хаягжуулалт”** чиг үүргийн хүрээнд судалгаанд хамрагдсан аймаг, нийслэлийн ИТХ-аас гаргасан (2022 оноос хойш) хоёр л шийдвэр байв. Эдгээр нь гудамж, талбайд нэр өгөх тухай шийдвэр байсан бөгөөд тухайн асуудалд хамаарах салбарын хуулийн холбогдох зохицуулалт байхгүй тул Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуульд заасан чиг үүрэг, [21.1.11; 24.1.17], Хурлын бүрэн эрх [35.1.13]-ийг үндэслэл болгож авсан, эрх зүйн ямар нэгэн зөрчилгүй шийдвэрүүд байлаа.

Засгийн газрын 2022 оны 180 дугаар тогтоолын дагуу гудамж, зам, талбай, үл хөдлөх хөрөнгийн хаягийн мэдээллийг Хурлаар батлуулах, хаягжуулах ажлыг зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосон боловч судалгаанд хамрагдсан аймаг, нийслэлд энэ асуудлыг шийдвэрлэсэн Хурлын тогтоол, Засаг даргын захирамж гараагүй байна.

Судалгаанд хамрагдсан аймаг, нийслэл, суманд **“Хөшөө дурсгалын зохицуулалт”** чиг үүрэгт хамаарах асуудлаар бүх шатны ИТХ-ууд огт шийдвэр гаргаагүй, харин Засаг даргаас уг асуудлаар шийдвэр гаргахдаа Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан холбогдох орон нутгийн чиг үүрэг [21.1.12; 22.1.12; 24.1.18]-ийг үндэслээгүй, төлөөлөн гүйцэтгэх төрийн чиг үүрэг [27.5.8; 27.5.19]-ийг үндэслэл болгон авчээ.

**“Нийтийн эзэмшлийн зам, талбай, олон нийтийн соёл амралтын хүрээлэн, ногоон байгууламж”** чиглэлээр гарсан Хурлын шийдвэрүүд нь бусад чиг үүргийн хүрээнд гарч буй шийдвэрүүдийн нэгэн адил холбогдох чиг үүрэг [22.1.13; 24.1.19; 25.1.10] болон бүрэн эрх [35.1.13] ийн аль нэгийг нь үндэслэх нь түгээмэл байна. Засаг дарга захирамж гаргасан үндэслэл нь өмнө дурдсантай нэгэн адил хуулийг зөв хэрэглэлгүй холбогдох зүйл заалт [22.1.13; 25.1.10; 59.1.1; 59.1.2; 59.1.7; 60.1.1; 60.1.2; 60.1.8; 63.1.1; 63.1.2]-ыг орхигдуулах, эсвэл салбарын хууль тогтоомж, дээд газрын шийдвэр

(Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Сангийн яамнаас гаргасан журам)-ийг үндэслэж байна.

**“Орон нутгийн аялал, жуулчлалын бодлого, менежмент”** чиг үүргийг хэрэгжүүлэхдээ аймаг, нийслэл, сумын ИТХ-аас гаргасан шийдвэрт холбогдох чиг үүрэг (21.1.13; 22.1.14; 25.1.20), бүрэн эрх (35.1.13)-ийг үндэслэл болгожгүй, голчлон “нутаг дэвсгэрийн хөгжлийн ... бодлого, ... чиглэлийг батлах бүрэн эрх” (35.1.8)-ийг үндэслэл болгосон байна.

Засаг даргаас аялал, жуулчлалын талаар гаргасан шийдвэрт Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан холбогдох чиг үүргийг огт үндэслэл болгожгүй, салбарын бусад хууль тогтоомж (Аялал жуулчлалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төсвийн тухай хууль г.м.)-ийн холбогдох зүйл, заалтыг хэрэглэсээр байна. Мөн Засаг даргын зарим шийдвэрт хүчингүй болсон хууль, хуулийн зүйл, заалтыг үндэслэл болгон авсан тохиолдол хэд хэдэн удаа гарлаа.

Аймаг, нийслэлийн Хурлаас бүрэн эрхийнхээ хүрээнд “Хог хаягдлын менежмент” чиг үүргийг хэрэгжүүлэхдээ хуульд заасан үндсэн чиг үүргийг биш, салбарын хууль тогтоомжид заасан холбогдох Хурлын бүрэн эрхийг, зарим тохиолдолд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан төлбөр, хураамжийн хувь хэмжээг тогтоох (21.1.4; 22.1.4; 24.1.4; 25.1.4) бүрэн эрхийг үндэслэсэн байна. Үүнээс гадна хог, хаягдлыг булшлах зардлын нэгж тариф тогтоох шийдвэрт дээр дурдсан “төлбөр, хураамжийн хувь, хэмжээ тогтоох” бүрэн эрхийг үндэслэл болгосон нь зөрчилтэй байна.

Дээрх чиг үүргийн хүрээнд гаргасан сум, дүүргийн ИТХ-ын шийдвэрт хог, хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг тогтоох шийдвэрүүд зонхилж байгаа бөгөөд эдгээр шийдвэрийн зөвхөн хоёрт нь холбогдох чиг үүргийг үндэслэл болгон авч үзсэн, түүнчлэн уг чиг үүрэгт хамаарах бүрэн эрхийг үндэслэл болгосон нэг тохиолдол байна. Харин салбарын хууль тогтоомжийн холбогдох зүйл заалтыг шийдвэр гаргахдаа голчлон үндэслэдэг нь хэвээр байна.

Судалгаанд хамрагдсан аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргаас хог, хаягдлын менежментийн асуудлаар гаргасан захирамжид Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан орон нутгийн холбогдох чиг үүрэг (21.1.4; 22.1.4; 24.1.4; 25.1.4) болон Засаг даргын бүрэн эрх (59.1.1; 59.1.2; 60.1.1; 60.1.2; 62.1.1; 62.1.2; 63.1.1; 63.1.2)-ийг үндэслэл болгон авч үзээгүй, салбарын холбогдох бусад хууль тогтоомж (Хог хаягдлын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төсвийн тухай хууль г.м.)-ийн зүйл заалтыг хэрэглэсэн байна.

**“Оршуулгын газрын зохицуулалт”** чиг үүргийн хүрээнд судалгаанд хамрагдсан аймаг, сум, нийслэл, дүүргийн Хурал, Засаг даргаас судалгааны хамрах хугацаанд гаргасан шийдвэрүүд байсангүй.

**“Төрийн болон орон нутгийн өмчийн боловсрол, эрүүл мэнд, нийгэм, соёлын байгууллагын барилга, байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар”** чиг үүргийн хүрээнд судалгаанд хамрагдсан аймаг, сум, нийслэл, дүүргийн ИТХ-аас гаргасан шийдвэр байсангүй. Эдгээр үйлчилгээний зохион байгуулалт, санхүүжилт төвлөрсөн загвартай хэвээр, салбарын хууль тогтоомжуудад энэхүү чиг үүрэг нь шат, шатны төрийн захиргааны байгууллагуудын бүрэн эрх байдлаар хуваарилагдсан хэвээр байгаа учраас ИТХ уг чиг үүргийг санхүүжилт, зохион байгуулалтын талаас нь бие даан шийдвэрлэх боломжгүй байна.

Энэ чиг үүрэгт хамаарах салбаруудын үйлчилгээний зохион байгуулалт, санхүүжилт нь төвлөрсөн байгаатай уялдаад Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль зэрэг бусад хууль тогтоомжид үндэслэж гарч байгаагаас биш, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан орон нутгийн холбогдох чиг үүрэг (21.1.16; 22.1.17; 24.1.8; 25.1.8)-ийг огт үндэслэхгүй байна. Нэгэнт дээр дурдсан бусад хууль тогтоомжийн зүйл заалтыг үндэслэж байгаа болохоор салбарын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд чиглэсэн Засаг даргын бүрэн эрх (59.1.5; 59.1.6; 60.1.5; 60.1.6; 62.1.5; 62.1.6; 63.1.5; 63.1.6)-ийг нэмэлт үндэслэл болгож байгаа нь харагдлаа.

**“Гал түймэр, үерийн хамгаалалтын байгууламж, суваг шуудуу”** чиг үүрэг нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 20-д заасан “гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа” гэсэн төрийг төлөөлөн гүйцэтгэх чиг үүрэгт хамаарч ирсэн тул Хурлаас тухайн асуудлаар шийдвэр гаргах үндэслэл, санаачилга гаргахгүй байна. Судалгаанд хамрагдсан аймаг, сум, нийслэл, дүүргийн Хурлуудаас энэ чиг үүргийн хүрээнд хамааруулан авч үзэж болох асуудлаар нэг л шийдвэр гарчээ. Уг шийдвэрт холбогдох чиг үүргийг оновчтой дурдаагүй, харин Хурлын бүрэн эрх (35.1.13)-ийг зөв үндэслэсэн байна.

Харин Засаг даргын хувьд гамшгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах асуудлаар салбарын хуулиудад (Галын аюулгүй байдлын тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Усны тухай хууль, Ойн тухай хууль г.м) заасан бүрэн эрхийн хүрээнд шийдвэр гаргаж байгаа нь орон нутгийн чиг үүргийг гүйцэтгэж байгаагаас илүүтэйгээр төрөөс төлөөлөн гүйцэтгэх чиг үүргийг хэрэгжүүлж байгаа нь харагдаж байна. Засаг дарга салбарын хуулиудыг үндэслэн шийдвэр гаргахдаа Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан Засаг

даргын холбогдох бүрэн эрх (59.1.1; 59.1.12; 59.1.21)-ийг давхар үндэслэсэн нь цөөн тохиолдлоо. Ихэнх тохиолдолд салбарын хуулиудын зүйл заалтаас өөр үндэслэлгүй гарах нь элбэг байна.

**“Орон нутгийн цэвэрлэх байгууламж”** чиг үүрэгт хамаарах асуудлыг өмнө нь холбогдох салбарын хуулиар Хурал, Засаг даргын бүрэн эрхийг тараан байршуулах хэлбэрээр хуваарилсан, асуудлыг үндсэндээ орон нутагт зөвхөн төвлөрсөн цэвэрлэх байгууламжийн хүрээнд авч үздэг байсан болохоор нийслэлд л уг асуудал хамаарч ирсэн гэж үзэж болохоор байна. Судалгаанд хамрагдсан аймаг, сум, нийслэл, дүүргийн Хурлуудаас энэ чиг үүргийн хүрээнд хамааруулан авч үзэж болох асуудлаар нэг шийдвэр гарсан байна. Уг шийдвэрт холбогдох чиг үүргийг оновчтой дурдаагүй, харин Хурлын бүрэн эрх (35.1.13)-ийг зөв үндэслэсэн байна. Харин Засаг даргаас судалгааны хугацаанд гаргасан ямар нэгэн шийдвэр байсангүй.

Нийслэл, орон нутгийн чанартай авто замын эзэмшигч нь аймаг, нийслэлийн Засаг дарга байхаар Автозамын тухай хуульд заасан тул **“Орон нутгийн зам, гүүр”** чиг үүрэгт хамаарах асуудлаар голчлон Засаг даргын шийдвэр гарч байна. Хурлын шийдвэрийн тухайд судалгаанд хамрагдсан нэг газрын ИТХ-ын 3 тогтоол байгаа бөгөөд холбогдох чиг үүрэг нь тухайн нэгжид хамааралгүй тул зөвхөн Хурлын бүрэн эрх (35.1.13), бусад хууль тогтоомжийг үндэслэл болгож шийдвэрээ гаргасан байна. Засаг даргын шийдвэрүүдэд хууль тогтоомжийг үндэслэл болгохдоо тухайн нэгжид холбогдох чиг үүргийг тухайлан хуваарилаагүйн улмаас өөр чиг үүргийг үндэслэл болгож авсан, эсвэл зөвхөн салбарын бусад хууль тогтоомжийг үндэслэсэн байгаа юм.

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд заасан Нийслэл хотын холбогдох чиг үүрэг (8.2.7; 8.3.6)-ийг Нийслэлийн ИТХ-ын шийдвэр, Засаг даргын захирамжид оновчтой хэрэглэсэн байна.

**“Суурин газрын гэрэлтүүлэг”** чиг үүргийн хүрээнд судалгаанд хамрагдсан аймаг, сум, нийслэл, дүүргийн ИТХ-аас гаргасан нэг шийдвэр байгаа бөгөөд тухайн нэгжид холбогдох чиг үүргийг хуваарилаагүйн улмаас зөвхөн Хурлын бүрэн эрх (35.1.13)-ийг зарим нэг ерөнхий хууль (тухайлбал, Захиргааны ерөнхий хууль)-ийн зүйл, заалтыг үндэслэн шийдвэр гаргажээ. Засаг даргын тухайд уг чиг үүрэгт хамаарах асуудлаар сумын Засаг даргын шийдвэрүүд байгаа бөгөөд голчлон Засаг даргын захирамж гаргах бүрэн эрх (66.1)-ээс өөр үндэслэл аваагүй байна.

**“Бэлчээрийн ашиглалт, хамгаалалт”** чиг үүргийг сумын түвшинд хуваарилаагүй боловч сумын ИТХ-аас “бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журам”-ыг баталсан тогтоолд холбогдох орон нутгийн чиг үүргийг ерөнхий утга (20.1.23)-аар нь үндэслэж үүн дээр Хурлын холбогдох бүрэн эрх (35.1.13; 35.1.14), Газрын тухай хууль, Захиргааны ерөнхий хуулийн холбогдох заалтыг үндэслэсэн нь хэм хэмжээний акт

тогтооход баримтлах зарчмыг бүрэн хангасан байна. Харин Засаг даргаас гаргасан захирамжуудад орон нутгийн чиг үүргийг хэрэглээгүй, голчлон Газрын тухай хуулиас өөр үндэслэлгүйгээр гаргасан байна.

Судалгаанд хамрагдсан сумдын багуудын иргэдийн Нийтийн Хурлын болон Засаг даргын шийдвэрийг шүүн үзэхэд 2022 оноос хойш бэлчээр хуваарилах, хязгаарлалт тогтоох зэрэг асуудлаар албажсан шийдвэр огт гараагүй байна. Хэдийгээр бэлчээр хуваарилах, ашиглах асуудлыг багийн Хурлын хуралдааны үеэр хэлэлцдэг (нэг биш удаа) боловч шийдвэр гаргалгүй үлддэг, ихэнх тохиолдолд сумын Хурал, Засаг даргад уламжлан Газрын тухай хуульд заасан үндэслэлээр сумын түвшинд шийдвэр гаргуулдаг гэж хэд хэдэн багийн Засаг дарга ярьж байлаа.

Иймээс орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэх утгаар бус, төрөөс төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэх утгаар Газрын тухай хуульд зааснаар сумын түвшинд бэлчээрийн асуудлыг шийдвэрлэхээс биш, багийн түвшинд шийдвэрлэхгүй байгаа нь харагдав.

Орон нутгийн шийдвэрт хийсэн шинжилгээнээс дүгнэж харахад Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг хүчин төгөлдөр мөрдөж эхэлснээс хойш буюу 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс хойш гарсан аймаг, сум, нийслэл, дүүргийн ИТХ, Засаг даргын шийдвэрийн үндэслэл нь голчлон тухайн салбарын хууль тогтоомж, бусад дээд шатны байгууллагын шийдвэрийн холбогдох зүйл, заалт байгаа нь нэг талаас төрийн албан хаагчид хуулийн шинэчилсэн найруулга, түүний хэрэглээний талаар нэгдсэн ойлголттой болоогүй, хэрэглэж хэвшээгүй, нөгөө талаас хуульд салбарын хууль тогтоомжийг нийцүүлэх ажиллагаа системтэй хийгдээгүй нь хүчтэй нөлөөлж байгааг харуулж байна.

Судалгаанд хамрагдсан аймаг, сум, нийслэл, дүүргийн ИТХ, Засаг даргын шийдвэрт Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан орон нутгийн чиг үүргийг үндэслэл болгон авсан тохиолдол дөнгөж 9.8 хувь байгаа юм.

Гаргаж байгаа шийдвэр нь салбарын хууль тогтоомжтой холбогдохгүй буюу агуулгын хувьд нийцэхгүй байгаа, түүнчлэн хуульд заасан ИТХ, Засаг даргын бүрэн эрх ч холбогдохгүй байгаа тохиолдолд мөн хуулийн 48 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан "... хэлэлцсэн асуудлаар тогтоол гаргах", 66 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан "... өөрийн эрх хэмжээний хүрээнд ... захирамж гаргана" гэсэн заалтыг л үндэслэл болгож байгаа нь нийтлэг ажиглагдаж байна.

Мөн Хурал, Засаг даргаас бүрэн эрхийнхээ хүрээнд шийдвэр гаргахдаа зарим шийдвэрт холбогдох чиг үүргийг үндэслэл болгож байгаа хэдий ч Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан уг чиг үүрэгт шууд холбогдох, Хурлын (35.1.13), Засаг

даргын бүрэн эрх (59.1.7; 60.1.8; 62.1.8; 63.1.8)-ийг үндэслэл болгоогүй, эсвэл холбогдох бүрэн эрхийг үндэслэл болгосон атлаа хамаарах чиг үүргийг үндэслэл болгохгүй байгаа, түүнчлэн салбарын хууль тогтоомж, дээд газрын шийдвэрийг үндэслэл болгочихоод Засаг даргын “хууль тогтоомж, Засгийн газар болон харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийг хэрэгжүүлэх” бүрэн эрхийг үндэслэхгүй байгаа нь Хурлын ажлын алба, ЗДТГ, бусад байгууллагын нэгж, албан тушаалтны хууль эрх зүйн мэдлэг, хууль тогтоомжийн хэрэглээний ур чадвартай шууд холбоотой.

Үүнээс гадна тухайн нэгжид хамаарах чиг үүргийг шийдвэрт үндэслэл болгон аваад уг чиг үүргийг хэрэгжүүлэхэд хамаарах шийдвэр гаргагч этгээдийн бүрэн эрхийг мөн үндэслэх нь шийдвэрийг бүрэн гүйцэд, хэрэгжих эрх зүйн чадамжтай болгох учиртай. Гэтэл үүнийг бүхэллэг байдлаар харж шийдвэрийн төслийг боловсруулж, хянаж, баталж байгаа нь нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагуудад тун ховор байна.

## ТАВДУГААР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (2020)-ийн шинэчилсэн найруулгад орон нутгийн чиг үүргийг тодорхойлоод, уг чиг үүргийг орон нутаг бие даан шийдвэрлэх бөгөөд төрөөс үүнд оролцохгүй байх, чиг үүргийг аль болох иргэдэд ойр нэгжид хуваарилан, санхүүжилтийн асуудлыг хамтад нь шийдвэрлэх гэсэн үндсэн зарчмыг баримталсан байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 45 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуультай бусад хууль тогтоомжийг нийцүүлэх, холбогдох хуулийн төслийг өргөн мэдүүлэх” гэж Засгийн газарт үүрэг болгосны дагуу орон нутгийн нийт 23 чиг үүргийн 10 чиг үүрэгт хамаарах хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулж, тодорхой хэмжээний нийцүүлэх ажлыг хийсэн байна. Гэвч “нийцүүлэх ажил” нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн үзэл баримтлалын хүрээнд бус, системгүй, голчлон бүрэн бус, бусад хууль тогтоомжтой төдийлөн уялдаагүй, тухайн салбарын төрийн захиргааны төв байгууллагуудын үзэмжээр хийсэн гэхээр байна.

Салбарын хууль тогтоомжийг боловсруулж батлахдаа тухайн салбарын төрийн захиргааны байгууллагуудын ажил үүргийг яам, Засгийн газрын агентлаг, аймаг, сум, баг, нийслэл, дүүрэг, хорооны Хурал, Засаг даргын бүрэн эрх байдлаар тараан байршуулах төдийгөөр шийдвэрлэж байна. Энэ нь захиргааны шинэчлэлийн олон улсын туршлагаас харвал тийм ч түгээмэл бус хэрэглэдэг, “нягтралыг сийрэгжүүлэх” хэлбэр болохыг харуулж байгаа юм. Зүй нь орон нутагт чиг үүргийг “эрх мэдэл бүрэн шилжүүлэх” хэлбэрээр л голчлон шийдвэрлэдэг байна [Долгоржав Я., 2023].

Хэрэв чиг үүргийг “эрх мэдлийг бүрэн шилжүүлэх” хэлбэрээр шилжүүлсэн бол Засгийн газарт уг чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой бүрэн эрх үлдэхгүй. Гэтэл Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан орон нутгийн чиг үүрэгт нийцүүлсэн гэж үзээд байгаа салбарын хуулиудад ч Засгийн газрын дор хаяад ямар нэг бүрэн эрх үлдэх ёстой мэт үзсээр байна.

Үүний зэрэгцээ Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан орон нутгийн чиг үүрэгт хамаарах ямар нэг хууль байхгүй нь уг чиг үүргийг орон нутаг өөрийн эрх хэмжээний хүрээнд Үндсэн хуульд нийцүүлэн “бие даан шийдвэрлэх боломж” гэдгийг



орон нутаг хараахан ойлгож, хүлээн зөвшөөрч чадахгүй, урьдын адил дээд газрын шийдвэр хүлээдэг хэвээр байна.

Аливаа чиг үүргийг хэрэгжүүлэхэд төсвөөс шууд хамааралтай байгаа учир бие даан шийдвэрлэх, хэрэгжүүлэх боломж нь хязгаарлагдмал. Төсвийн тогтолцоо өөрөө “их гэрт бага гэр, бага гэрт балчир хүүхэд” гэдэг хүүхдийн оньсого лугаа адил тогтолцоо учир орон нутаг яаж ч “биеэ даах” хүсэл эрмэлзэлтэй ч хэрэгжүүлж чадахгүйд хүрдэг нь гаргаж буй шийдвэрүүдээс нь илт харагдаж байна.

Орон нутгийн өмч нь нийтийн өмчийн бие даасан хэлбэр болж төлөвшөөгүй, урьдын адил төрийн өмчийн орон нутагт “байх” хэсэг гэж ойлгогддог, хэрэглэгддэг учир орон нутагт өөрийн орлого олох боломж хомс, уг орлого нь чиг үүргийг санхүүжүүлэхэд чиглэдэггүй, “нийтийн тогоо”-нд л ордог болохоор сонирхол ч бага хэвээр байна.

## ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

- Abdullah H. Alharthy, Hamad Rashid, Romano Pagliari, Faisal Khan. (2017). Identification of Strategy Implementation Influencing Factors and Their Effects on the Performance. *International Journal of Business and Social Science*, Vol. 8, No. 1, pp 38.
- Council of Europe. (1985). CETS 122 - European Charter of Local Self-Government: <https://rm.coe.int/european-charter-of-local-self-government-eng/1680a87cc3-ээс> Гаргасан
- Council of Europe. (1985). European Charter of Local Self-Government (ETS No. 122). Strasbourg. <https://www.coe.int/en/web/conventions/full-list?module=treaty-detail&treaty-num=122-ээс> Гаргасан
- OECD. (2019). "Understanding decentralisation systems", in Making Decentralisation Work: A Handbook for Policy-Makers. OECD Publishing, Paris, <https://doi.org/10.1787/53013b71-en>.
- Rondinelli Dennis. (1980). Government Decentralization in Comparative Perspective: Theory and Practice in Developing Countries. *International Review of Administrative Sciences*, Vol. 47, №2., 137.
- Salvador Parrado. (2005, p 5). Assigning competences and functions to local self-government in four EU member states: A Comparative Review. Madrid: Paper prepared for Sigma.
- Webster. (1995). Democracy, decentralized government, and NGOs in Indian rural development.
- Д.Байгал. (2019). Төрийн байгууллагын чиг үүрэг, бүтцэд шинжилгээ хийж төрийн албан хаагчдад тавигдах мэдлэг чадварын шаардлагыг тодорхойлсон нь. Төрийн удирдлага сэтгүүл, №8, хууд 76.
- Д.Сүнжид. (2016). Орон нугийн түвшин дэх чиг үүргийн хуваарилалт. Нутгийн удирдлага сорилт ба шийдэл үндэсний чуулган, (хууд. 164). Улаанбаатар.
- Долгоржав, Я. (1999). Төвлөрлийг сааруулж, үйлчилгээ хүргэх асуудалд. Н. Шведийн олон улсын хөгжлийн агентлаг-Д, Монгол улсад Нутгийн өөрийн удирдлагын чадавхийг дээшлүүлэх нь: Сонсогчийн гарын авлага (хууд. 142). Улаанбаатар.

Долгоржав, Я. (2023). Төвлөрлийг сааруулсан удирдлагын хэв маяг. Төрийн удирдлага, 53.

Долгоржав, Я. (2023). Төвлөрлийг сааруулсан удирдлагын хэв маяг. Төрийн удирдлага, 54.

Дэлхийн банк. (2007). Төрийн захиргаа, төрийн албаны шинэтгэл. Чиг үүргийн шинжилгээний арга зүйн гарын авлага.-Д Улаанбаатар.

ЗГХЭГ, Швейцарын хөгжлийн агентлаг. (2020). Орон нутагт хэрэгжүүлэхээр заасан чиг үүргүүд, тэдгээрийн хэрэгжилт, хүндрэл бэрхшээл, шийдвэрлэх арга замууд. Сэлэнгэ аймаг.

Конрад Аденауэр сан. (2017). Үр нөлөө бүхий нутгийн удирдлагын тогтолцоо.

Конрад-Аденауэр-Сан. (2022). Захиргааны шинжлэх ухааны нэр томьёоны тайлбар толь. Улаанбаатар.

Лүндэндорж, Н. (2005). Төрийн онол. Улаанбаатар.  
(2019). Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн шинжилгээ. Улаанбаатар.

Монгол Улсын Засгийн газрын тогтоол. (2018). Аргачлал батлах тухай. Улаанбаатар. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=13242-ээс>  
Гаргасан

Мөнхбаяр, М. (2017). Төрийн захиргааны байгууллагын стратегийн төлөвлөлтөд хийсэн судалгаа. Удирдахуйн онол, практикийн асуудлууд, 180.

Нарангэрэл, С. (2012). Хууль зүйн англи-монгол эх толь. Улаанбаатар.

Ник Маннинг, Нил Парисон. (2004). Определение структуры и функций правительства: Программные и функциональные обзоры. Москва.

Нутгийн өөрөө удирдах ёсны Европын Харти. (1985, 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг).

Нээлттэй нийгэм форум. (2005). Үндэсний ба нутгийн удирдлагын чиг үүргийн зохистой хуваарилалт. Улаанбаатар.

- Нээлттэй нийгэм форум. (2010). Орон нутгийн төсвийн зарлагын шинжилгээ. Улаанбаатар.
- ОХУ-ын Улс Түмний Найрамдлын сургууль. (2017). Гадаад орнуудын орон нутгийн эрх зүй: онол ба орчин үеийн практик. Москва.
- П.Зоригтбаатар. (2018). Монгол Улсын Засгийн газрын төвлөрлийг сааруулах бодлого, түүний хэрэгжилт. Төвлөрлийг сааруулах замаар иргэдэд үйлчилгээг ойртуулах нь, (хууд. 14). Улаанбаатар.
- Паул Витт. (2018). ХБНГУ-ын нутгийн өөрийн удирдлага, цаашдын хандлага. Төвлөрлийг сааруулах замаар иргэдэд үйлчилгээг ойртуулах нь: Ардчиллын IV чуулганы эмхэтгэл, (хууд. 23). Улаанбаатар.
- Сүнжид, Д. (2016). Орон нутгийн түвшин дэх чиг үүргийн хуваарилалт. Нутгийн удирдлага: сорилт ба шийдэл үндэсний чуулганы эмхэтгэл, (хууд. хууд 65). Улаанбаатар.
- Удирдлагын академи. (2007). Төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагын чиг үүргийн шинжилгээ. Улаанбаатар.
- Удирдлагын академи. (2011). “Төрийн болон нутгийн удирдлагын байгууллагуудын чиг үүргийн шинжилгээ” сэдэвт судалгааны тайлан. УБ.
- Удирдлагын академи. (2012). Төрийн болон нутгийн удирдлагын байгууллагуудын чиг үүргийн шинжилгээ. Улаанбаатар: Удирдлагын академи.
- Хууль зүйн үндэсний хүрээлэн. (2010). Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл. Боть 2. Улаанбаатар.
- Хууль зүйн үндэсний хүрээлэн. (2010). Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл. Боть 3. Улаанбаатар.
- Хүний хөгжил судалгаа, сургалтын төв. (2021). Монгол Улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуультай Төсвийн тухай хуулийг харьцуулсан судалгаа. Улаанбаатар.
- Цанжид, А. (2017). Төв орон нутгийн харилцаа, чиг үүргийн зохистой хуваарилалт. Үр нөлөө бүхий нутгийн удирдлагын тогтолцоо, (хууд. 15). Улаанбаатар.

- Шинжлэх ухааны академи. (1978, №107-108). Улсын нэр томъёоны комиссын мэдээ. УБ, хууд 271.
- (2021). Шинэчлэн баталсан Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн орлого, зарлага, төсвийн тэнцэл, төсвийн шилжүүлэгт үзүүлэх үр нөлөө. Улаанбаатар.
- ШУА. (1978). Улсын нэр томъёоны комиссын мэдээ №107-108. Хууль зүйн нэр томъёо. Тэргүүн дэвтэр, 271.
- Abdullah H. Alharthy, Hamad Rashid, Romano Pagliari, Faisal Khan. (2017). Identification of Strategy Implementation Influencing Factors and Their Effects on the Performance. International Journal of Business and Social Science, Vol. 8, No. 1, pp 38.
- Council of Europe. (1985). European Charter of Local Self-Government (ETS No. 122). Strasbourg. Retrieved from <https://www.coe.int/en/web/conventions/full-list?module=treaty-detail&treatynum=122>
- OECD. (2019). "Understanding decentralisation systems", in Making Decentralisation Work: A Handbook for Policy-Makers. OECD Publishing, Paris, <https://doi.org/10.1787/53013b71-en>.
- Rondinelli Dennis. (1980). Government Decentralization in Comparative Perspective: Theory and Practice in Developing Countries. International Review of Administrative Sciences, Vol. 47, №.2., 137.
- Salvador Parrado. (2005, p 5). Assigning competences and functions to local self-government in four EU member states: A Comparative Review. Madrid: Paper prepared for Sigma.
- Webster, N. (1995). Democracy, decentralized government, and NGOs in Indian rural development.

ХАВСРАЛТ 1. ОРОН НУТГИЙН ЧИГ ҮҮРЭГТ ХОЛБООТОЙ, ОДОО ХҮЧИН ТӨГӨЛДӨР  
МӨРДӨЖ БАЙГАА ХУУЛИУДЫН ЖАГСААЛТ

№	Хуулийн жагсаалт	батлагдсан огноо	н э м э л т өөрчлөлт орсон
1	Монгол Улсын Үндсэн хууль	1992	
2	Авто замын тухай хууль	2017	2021, 2022, 2023
3	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хууль	1999	2021, 2022, 2023
4	Аялал жуулчлалын тухай хууль	2023	
5	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль	2012	2022, 2023
6	Байгаль орчныг хамгаалах тухай хууль	1995	2021, 2022, 2023
7	Баяжуулсан хүнсний тухай хууль	2018	2021, 2022
8	Биеийн тамир, спортын тухай	2017	2021, 2022, 2023
9	Газрын тухай хууль	2002	2021, 2022
10	Галын аюулгүй байдлын тухай хууль	2015	2022, 2023
11	Гамшгаас хамгаалах тухай хууль	2017	2021, 2022, 2023
12	Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль	2019	2021, 2022
13	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль	2015	2021, 2022, 2023
14	Инновацийн тухай хууль	2012	2021, 2022
15	Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль	2017	2021, 2022, 2023
16	Малын генетик нөөцийн тухай хууль	2017	2021, 2022, 2023
17	Малын тоо толгойн албан татварын тухай хууль	2020	
18	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль	2020	2021, 2022, 2023
19	Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль	2021	2022
20	Нийслэл хотын албан татварын тухай хууль	2015	2021
21	Ойн тухай хууль	2012	2021, 2022, 2023
22	Органик хүнсний тухай хууль	2016	2021, 2022
23	Орон сууцны тухай хууль	1999	2021, 2022
24	Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи дан согтуурахтай тэмцэх тухай хууль	2022	2023

25	Соёлын өвийг хамгаалах тухай хууль	2014	2021, 2023	2022,
26	Соёлын тухай хууль	2021	2022, 2023	
27	Статистикийн тухай хууль	1997	2021, 2023	2022,
28	Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хууль	2003	2022	
29	Тамхины хяналтын тухай хууль	2005	2022, 2023	
30	Тариалангийн тухай хууль	2016	2021, 2022	
31	Таримал ургамлын үр сортын тухай хууль	2021	2022	
32	Татварын ерөнхий хууль	2019	2021, 2023	2022,
33	Төрийн албаны тухай хууль	2017	2021, 2023	2022,
34	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль	1996	2021, 2023	2022,
35	Төсвийн тухай хууль	2011	2021, 2023	2022,
36	Улсын бүртгэлийн ерөнхий хууль	2018	2021, 2022	
37	Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль	2010	2021, 2023	2022,
38	Үйлдвэрлэл технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль	2022	2023	
39	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хууль	2000	2021, 2022	
40	Тариалангийн тухай хууль	2016	2021, 2022	
41	Хаягжуулалтын тухай хууль	2013	2022	
42	Хог хаягдлын тухай хууль	2017	2021, 2023	2022,
43	Хоршооны тухай хууль	2021	2022	
44	Хот байгуулалтын тухай хууль	2008	2021, 2022	
45	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль	2011	2022, 2023	
46	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль	2020	2021, 2022	
47	Хөдөө аж ахуйн гаралтай бараа түүхий эдийн биржийн тухай хууль	2011		
48	Хувь хүний орлогын албан татварын тухай хууль	2019	2022	
49	Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль	2012	2022, 2023	
50	Хүнсний тухай хууль	2012	2022, 2023	



ХАВСРАЛТ 2-А. ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛЫН АГУУЛГАД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

ой	Айтаг, сум, дүүргийн нэр		өгөгдөл		ЗЗНДНТУТ Хууль (2020)		
	онгоо, дугаар		Шийдвэрийн үндэслэл, хуулийн заалт		Төгтөөлөн агуулга		
		Тэрүү		“нэгжийн хууль”		нэгжийн хууль	
		“салбарын хууль”		Засгийн газрын тогтоол		“салбарын хууль”	
		“Сайдын тушаал, журам”		бусад		“Засгийн газрын тогтоол”	
		үүрэгжүүлсэн этгээд		“санхүүгийн эх үүсвэр”		“аруулгыг илэрхийлэх үг”	
		“Үндсэн агуулга”		Нэр үг		“Зүйл, заалтын дугаар”	
		Түлхүүр үг		“Хамаарах зүйл, заалтын дугаар”		“аруулгыг илэрхийлэх нэр үг”	
				Агуулгыг илэрхийлэх нэр үг		“агуулгыг илэрхийлэх үг”	
				“Хамаарах зүйл, заалтын дугаар”		“агуулгыг илэрхийлэх үг”	
				Агуулгыг илэрхийлэх нэр үг		“агуулгыг илэрхийлэх үг”	
				Орон нутгийн чиг үүрэгт хамаарах асуудал /нэр үг/		Төлөөлөн гүйцэтгэх чиг үүрэг	
				Төгтөөлөн гүйцэтгэх чиг үүрэг		ИТХ-ын бүрэн эрх /үйл үг/	
				Төгтөөлөн гүйцэтгэх чиг үүрэг		Төлөөлөн гүйцэтгэх чиг үүргийг хэрэгжүүлэх ЗД-ын шийдвэрийг 62.1.7-оор зүйлчилнэ”	
				Тогтоолын агуулга		“байвал зохих хууль зүйн үндэслэл (Анхаарах зүйл: Төлөөлөн гүйцэтгэх чиг үүргийг хэрэгжүүлэх ЗД-ын шийдвэрийг 62.1.7-оор зүйлчилнэ)”	



ХАВСРАЛТ 2-Б. ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖИЙН АГУУЛГАД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

ӨГӨГДӨЛ		ЗЭНДНТҮХууль (2020) (Анхаарах зүйл: Төлөөлөн гүйцэтгэх чиг үүргийг хэрэгжүүлэх ЗД-ын шийдвэрийг 62.1.7-оор зүйлчилнэ)		ДҮГНЭЛТ																									
№	Аймаг, сум, дүүргийн нэр Сар, өдөр, дугаар Тэрүү	Шийдвэрийн үндэслэл, хуулийн заалт	Үрэгжүүлсэн этгээд Санхүүгийн эх үүсвэр	Захирамжийн агуулга	Орон нутгийн чиг үүрэгт хамаарах асуудал	Төлөөлөн гүйцэтгэх чиг үүрэгт хамаарах асуудал	ЗД-ын бүрэн эрхт хамаарах асуудал	Бусад хамаарах хууль, зүйл заалтын агуулга, дугаар (ЗД-ын бүрэн эрх)	Нэгжийн хууль	Салбарын хууль	Засгийн газрын тогтоол	Сайдын тушаал, журам	Хурлын шийдвэр	Бусад	Камаарах зүйл, заалтын дугаар	Агуулгыг илэрхийлэх нэр үг	Эрх хэмжээг илэрхийлсэн түлхүүр үг	Камаарах зүйл, заалтын дугаар	нэр үг	Үйл үг	Агуулгыг илэрхийлэх нэр үг	Камаарах зүйл, заалтын дугаар	Агуулгыг илэрхийлэх нэр үг	Камаарах зүйл, заалтын дугаар	Агуулгыг илэрхийлэх нэр үг				
																										Үндсэн агуулга	Түлхүүр үг	Нэр үг	Үйл үг



### ХАВСРАЛТ 3-А. ОРОН НУТГИЙН ЧИГ ҮҮРГИЙН ТАЛААРХ ХУУЛИУДЫН ЗОХИЦУУЛАЛТ

МУ-ын 3ЗНДНТУТХуулийн 4.1.6. “орон нутгийн чиг үүрэг” гэж хуульд заасны дагуу нутгийн өөрийн удирдлагад тусгайлан олгосон, нутгийн өөрөө удирдах байгууллага хариуцан шийдвэрлэх эдийн засаг, нийгмийн шинжтэй асуудлыг

№	Орон нутгийн чиг үүрэг-23 /20.1/	ИТХ-ын бүрэн эрх	Аймгийн чиг үүрэг- 16 /21.1/	Сумын чиг үүрэг-21 /22.1/	Багийн чиг үүрэг-6 /23.1/	Нийслэлийн чиг үүрэг-22 /24.1/	Дүүргийн чиг үүрэг-14 /25.1/	Хорооны чиг үүрэг
1	20.1.1.орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлт;	35.1.5.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг батлах, тайланг хэлэлцэж, үйл ажиллагаанд нь үнэлэлт, дүгнэлт өгөх	21.1.1.аймгийн дунд хугацааны хөгжлийн үндсэн чиглэл, бодлого, төлөвлөлт;	22.1.1.сумын хөгжлийн үндсэн чиглэл, бодлого, төлөвлөлт;		24.1.1.нийслэлийн хөгжлийн бодлого, төлөвлөлт;	25.1.1.дүүргийн хөгжлийн үндсэн чиглэл, бодлого, төлөвлөлт, ерөнхий ба хэсэгчилсэн төлөвлөгөө;	
		35.1.6.тухайн Хурлын шийдвэрийн хэрэгжилтийн талаарх Засаг даргын тайланг хэлэлцэж, ажилд нь үнэлэлт, дүгнэлт өгөх;						
		35.1.8.нутаг дэвсгэрийн хөгжлийн дунд хугацааны бодлого, жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах;						
2	20.1.2.орон нутгийн өмчийн удирдлага;	35.1.11.орон нутгийн өмчийн зүйлсийн өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэх;	21.1.2.аймгийн өмчийн ашиглалт, эзэмшилт, захиран зарцуулалт, түүнд тавих хяналт;	22.1.2.сумын өмчийн ашиглалт, эзэмшилт, захиран зарцуулалт, түүнд тавих хяналт;		24.1.2.нийслэлийн өмчийн ашиглалт, эзэмшилт, захиран зарцуулалт, түүнд тавих хяналт;	25.1.2.дүүргийн өмчийн ашиглалт, эзэмшилт, захиран зарцуулалт, түүнд тавих хяналт;	
		35.1.12.орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, дүрмийг батлах, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх;						
		18.2.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өмчийн хувьд өмчлөгчийн эрхийг хуульд заасан хязгаарын хүрээнд тухайн нэгжийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, өмчийн удирдлагыг тухайн нэгжийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас олгосон эрх хэмжээний хүрээнд Засаг дарга хэрэгжүүлнэ.						

№	Орон нутгийн чиг үүрэг-23 /20.1/	ИТХ-ын бүрэн эрх	Аймгийн чиг үүрэг- 16 /21.1/	Сумын чиг үүрэг-21 /22.1/	Багийн чиг үүрэг-6 /23.1/	Нийслэлийн чиг үүрэг-22 /24.1/	Дүүргийн чиг үүрэг-14 /25.1/	Хорооны чиг үүрэг
3	20.1.3.орон нутгийн төсөв, албан татвар, төлбөр, хураамж;	35.1.9.Засаг даргын өргөн мэдүүлснээр тухайн аймаг, сум, нийслэл, дүүргийн төсвийг хэлэлцэж батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гүйцэтгэлийг батлах	21.1.3.аймгийн төсөв, түүний төлөвлөлт, гүйцэтгэл, тайлан, хяналт;	22.1.3.сумын төсөв, түүний төлөвлөлт, гүйцэтгэл, тайлан, хяналт;		24.1.3.нийслэлийн төсөв, түүний төлөвлөлт, гүйцэтгэл, тайлан, хяналт;	25.1.3.дүүргийн төсөв, түүний төлөвлөлт, гүйцэтгэл, тайлан, хяналт;	
		35.1.10.хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд албан татвар, төлбөр, хураамжийн хувь хэмжээг тогтоох;	21.1.4.хууль тогтоомжид заасан хүрээнд албан татвар, төлбөр, хураамжийн хувь хэмжээг тогтоох асуудал;	22.1.4.хууль тогтоомжид заасан хүрээнд албан татвар, төлбөр хураамжийн хувь хэмжээг тогтоох асуудал;		24.1.4.хууль тогтоомжид заасан хүрээнд албан татвар, төлбөр, хураамжийн хувь хэмжээг тогтоох асуудал;	25.1.4.хууль тогтоомжид заасан хүрээнд албан татвар, төлбөр, хураамжийн хувь хэмжээг тогтоох асуудал;	
4	20.1.4.орон нутгийн сан;	35.1.13.энэ хуулиар тогтоосон тухайн нэгжийн чиг үүрэгт хамаарах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх, холбогдох журам батлах;	21.1.5.аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, хуваарилалт болон бусад сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, тайлан, хяналт;	22.1.5.сумын орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, хуваарилалт болон бусад сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, тайлан, хяналт;		24.1.5.нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, хуваарилалт болон бусад сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, тайлан, хяналт;	25.1.5.дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, хуваарилалт болон бусад сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, тайлан, хяналт;	
		17.2.Энэ хуулийн 17.1-д заасан санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих журмыг тухайн шатны Хурал тогтоож, түүний хэрэгжилтэд хяналт тавина.						
5	20.1.5.орон нутгийн хүний нөөцийн бодлогын төлөвлөлт, хөтөлбөр;	35.1.13.энэ хуулиар тогтоосон тухайн нэгжийн чиг үүрэгт хамаарах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх, холбогдох журам батлах;	21.1.6.аймгийн хүний нөөцийн бодлогын төлөвлөлт, хөтөлбөр;	22.1.6.аймгийн хүний нөөцийн хөтөлбөрийн хэрэгжилт, ажиллах нөхцөл;				
6	20.1.6.орон нутгийн үйлдвэрлэл, хүнс, хөдөө аж ахуй;	35.1.13.энэ хуулиар тогтоосон тухайн нэгжийн чиг үүрэгт хамаарах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх, холбогдох журам батлах;	21.1.7.аймгийн хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн хөтөлбөр, хэрэгжилтэд тавих хяналт;	22.1.7.аймгийн хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн хөтөлбөрийн хэрэгжилт;		24.1.6.нийслэлийн жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн менежмент;	25.1.7.нийслэлийн үйлдвэрлэлийн хөтөлбөрийн хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн хөтөлбөрийн хэрэгжилт;	
			21.1.8.аймгийн жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн менежмент;		23.1.1.нутаг дэвсгэрийнхээ иргэдэд хуульд заасны дагуу хүргэх үйлчилгээ;			
7	20.1.7.хүн амын ундны болон ахуйн хэрэгцээний усан хангамж;	35.1.13.энэ хуулиар тогтоосон тухайн нэгжийн чиг үүрэгт хамаарах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх, холбогдох журам батлах;		22.1.8.сумын хүн амын ундны болон ахуйн хэрэгцээний уст цэгийн төлөвлөлт, байршил, ашиглалт, хамгаалалт;		24.1.7.нийслэлийн хүн амын ундны болон ахуйн хэрэгцээний уст цэгийн төлөвлөлт, хяналт;	25.1.13.дүүргийн төвлөрсөн бус хүн амын ундны болон ахуйн хэрэгцээний уст цэгийн төлөвлөлт, байршил, ашиглалт, хамгаалалт;	

№	Орон нутгийн чиг үүрэг-23 /20.1/	ИТХ-ын бүрэн эрх	Аймгийн чиг үүрэг- 16 /21.1/	Сумын чиг үүрэг-21 /22.1/	Багийн чиг үүрэг-6 /23.1/	Нийслэлийн чиг үүрэг-22 /24.1/	Дүүргийн чиг үүрэг-14 /25.1/	Хорооны чиг үүрэг
8	20.1.8.худалдаа, үйлчилгээний зохицуулалт;	35.1.16.худалдаа, үйлчилгээний төрөл, ангилал, худалдаа үйлчилгээ эрхлэхэд тавих шаардлага, бүрдүүлэх баримт бичиг, худалдаа, үйлчилгээ эрхлэгчийн эрх, үүргийг тодорхойлсон нийтлэг журам батлах;	21.1.9.худалдаа, үйлчилгээний нийтлэг зохицуулалт, хяналт;	22.1.9.худалдаа, үйлчилгээний зохион байгуулалт, хяналт;		24.1.9.худалдаа, үйлчилгээний нийтлэг зохицуулалт, хяналт;	25.1.6.худалдаа, үйлчилгээний зөвшөөрөл, хяналт;	26.1.1.нутаг дэвсгэрийнхээ иргэдэд хуульд заасны дагуу хүргэх үйлчилгээ;
9	20.1.9.орон сууц, нийтийн аж ахуй;	35.1.13.энэ хуулиар тогтоосон тухайн нэгжийн чиг үүрэгт хамаарах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх, холбогдох журам батлах;		22.1.10.орон сууц, нийтийн аж ахуйн удирдлага;	23.1.2.хууль тогтоомжид заасан болон өөрийн санаачилсан асуудлаар нутаг дэвсгэрийнхээ иргэдийн нийтлэг санал, хүсэлтийг зохих шатны байгууллага, албан тушаалтанд уламжлах ажлын зохион байгуулалт;	24.1.10.орон сууц, нийтийн аж ахуйн удирдлага, үйлчилгээ;		26.1.2.хууль тогтоомжид заасан болон өөрийн санаачилсан асуудлаар нутаг дэвсгэрийнхээ иргэдийн нийтлэг санал, хүсэлтийг зохих шатны байгууллага, албан тушаалтанд уламжлах ажлын зохион байгуулалт;
10	20.1.10.орон нутаг дахь нийтийн тээвэр;	35.1.13.энэ хуулиар тогтоосон тухайн нэгжийн чиг үүрэгт хамаарах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх, холбогдох журам батлах;	21.1.10.сум хоорондын нийтийн тээврийн зохицуулалт;		23.1.3.хууль, зохих дээд байгууллагын шийдвэрт тухайлан заагаагүй тохиолдолд багийн бие даан шийдвэрлэх нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын тодорхой асуудал;	24.1.11.нийслэлийн нийтийн тээвэр, такси үйлчилгээний зохицуулалт;		26.1.3.хууль, зохих дээд байгууллагын шийдвэрт тухайлан заагаагүй тохиолдолд хорооны бие даан шийдвэрлэх нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын тодорхой асуудал;
11	20.1.11.суурин газрын замын хөдөлгөөн, авто зогсоол;	35.1.13.энэ хуулиар тогтоосон тухайн нэгжийн чиг үүрэгт хамаарах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх, холбогдох журам батлах;		22.1.11.суурин газрын замын хөдөлгөөн, авто зогсоолын зохицуулалт;	23.1.4.улс, аймаг, сумын чанартай асуудлаар хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд багийн иргэдийг зохион байгуулж оролцуулах ажил;	24.1.12.нийслэлийн замын хөдөлгөөний зохицуулалт;		26.1.4.улс, нийслэл, дүүргийн чанартай асуудлаар хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд хорооны иргэдийг зохион байгуулж оролцуулах ажил;
		35.1.13.энэ хуулиар тогтоосон тухайн нэгжийн чиг үүрэгт хамаарах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх, холбогдох журам батлах;				24.1.13.нийслэлийн авто зам, зогсоолын төлөвлөлт, байршил;	25.1.9.дүүрэг дэх авто зогсоолын арчилгаа;	6.1.5.хуульд заасны дагуу тухайн нутаг дэвсгэрийнхээ нийтийн эзэмшлийн газар, зам талбайн газар зохион байгуулалт, орчны эрүүл ахуй, ариун цэврийн байдалд тавих хяналтад иргэдийн оролцоог хангах ажил.

№	Орон нутгийн чиг үүрэг-23 /20.1/	ИТХ-ын бүрэн эрх	Аймгийн чиг үүрэг- 16 /21.1/	Сумын чиг үүрэг-21 /22.1/	Багийн чиг үүрэг-6 /23.1/	Нийслэлийн чиг үүрэг-22 /24.1/	Дүүргийн чиг үүрэг-14 /25.1/	Хорооны чиг үүрэг
12	20.1.12.гудамж, талбайн нэр, хаягжуулалт;	35.1.13.энэ хуулиар тогтоосон тухайн нэгжийн чиг үүрэгт хамаарах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх, холбогдох журам батлах;	21.1.11.гудамж, талбайн нэр, хаягжилтын нийтлэг зохицуулалт;			24.1.17.гудамж, зам, талбай, барилга байгууламжийн нэр, хаягжуулалтын зохицуулалт;		
13	20.1.13.хөшөө дурсгалын зохицуулалт;	35.1.13.энэ хуулиар тогтоосон тухайн нэгжийн чиг үүрэгт хамаарах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх, холбогдох журам батлах;	21.1.12.хөшөө дурсгалын нийтлэг зохицуулалт;	22.1.12.хөшөө дурсгалын байршил, хамгаалалт;		24.1.18.хөшөө дурсгалын нийтлэг зохицуулалт;		
14	20.1.14.нийтийн эзэмшлийн зам, талбай, олон нийтийн соёл амралтын хүрээлэн, ногоон байгууламж;	35.1.13.энэ хуулиар тогтоосон тухайн нэгжийн чиг үүрэгт хамаарах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх, холбогдох журам батлах;		22.1.13.нийтийн эзэмшлийн зам, талбай, олон нийтийн соёл амралтын хүрээлэн, ногоон байгууламжийн ашиглалт, хамгаалалт;		24.1.15.хот байгуулалт, барилга, стандарт, хяналт, зохицуулалт;	5.1.10.нийтийн эзэмшлийн зам, талбай, олон нийтийн соёл амралтын хүрээлэн, ногоон байгууламжийн арчилгаа, хамгаалалт;	
		35.1.13.энэ хуулиар тогтоосон тухайн нэгжийн чиг үүрэгт хамаарах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх, холбогдох журам батлах;				24.1.19.нийтийн эзэмшлийн зам, талбай, олон нийтийн соёл амралтын хүрээлэн, ногоон байгууламж, төлөвлөлт, хяналт;		
15	20.1.15.орон нутгийн аялал жуулчлалын бодлого, менежмент;	35.1.13.энэ хуулиар тогтоосон тухайн нэгжийн чиг үүрэгт хамаарах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх, холбогдох журам батлах;	21.1.13.аймгийн аялал жуулчлалын бодлого, менежмент;	22.1.14.аялал жуулчлалын үйл ажиллагааны зохицуулалт;		24.1.20.нийслэлийн аялал жуулчлалын бодлого, менежмент;		
16	20.1.16.хог хаягдлын менежмент;	35.1.13.энэ хуулиар тогтоосон тухайн нэгжийн чиг үүрэгт хамаарах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх, холбогдох журам батлах;	21.1.14.аяултай болон үйлдвэрлэлийн хог хаягдлын менежмент;	22.1.15.хог хаягдлын цэгийн байршил, энгийн хог хаягдлын менежмент;		24.1.21.хог хаягдлын нэгдсэн төлөвлөлт, удирдлага, зохицуулалт;	25.1.14.хог хаягдлын менежмент.	
17	20.1.17.оршуулгын газрын зохицуулалт;	35.1.13.энэ хуулиар тогтоосон тухайн нэгжийн чиг үүрэгт хамаарах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх, холбогдох журам батлах;		22.1.16.оршуулгын газрын үйл ажиллагааны зохицуулалт;		24.1.22.оршуулгын газрын нийтлэг зохицуулалт, менежмент.	25.1.11.оршуулгын газрын үйл ажиллагааны зохицуулалт;	

№	Орон нутгийн чиг үүрэг-23 /20.1/	ИТХ-ын бүрэн эрх	Аймгийн чиг үүрэг- 16 /21.1/	Сумын чиг үүрэг-21 /22.1/	Багийн чиг үүрэг-6 /23.1/	Нийслэлийн чиг үүрэг-22 /24.1/	Дүүргийн чиг үүрэг-14 /25.1/	Хорооны чиг үүрэг
